



Монгол Улс

***Хэвлэл мэдээллийн эрх зүй.
Нэр төр гутаах, онлайнаар үзэл
бодлоо илэрхийлэх ба өөрийн
зохицуулалт
Сургалтын гарын авлага***

2015 оны 10 дугаар сар

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	1
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	3
МОДУЛЬ 1: ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ	4
1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	4
2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтууд	5
3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ерөнхий төлөв байдал	5
Лавлагаа	10
МОДУЛЬ 2: Нэр төр гутаах:	11
1. Ухагдахууны тодорхойлолт	11
2. Хамрах хүрээ	16
3. Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиуд	18
МОДУЛЬ 3: НЭР ТӨР ГУТААХ: ӨМГӨӨЛӨЛ	24
1. Үнэнийг өмгөөлөх нь	25
2. Үзэл бодол	27
3. Үндэслэлтэй нийтлэл	31
4. Өмгөөллийн бусад хэлбэрүүд	34
МОДУЛЬ 4: НЭР ТӨР ГУТААХ : ШИЙТГЭЛ, БУСАД АСУУДАЛ БА ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	37
1. Шийтгэх арга хэмжээ	37
2. Хууль эрх зүйн тусламж	40
3. Нэр төр гутаасан үйлдлийг өмгөөлөх нь	41
Нэр төр гутаахтай холбоотой лавлагаа	42
МОДУЛЬ 5: ИНТЕРНЭТИЙН ЗОХИЦУУЛАЛТ	44
1. Интернэтийн бүтцийн зохицуулалт	44
2. Зохиогчийн эрх болон оюуны өмч	49
3. Контентийн асуудал	51
МОДУЛЬ 6: ИНТЕРНЭТИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ	55
1. Эрх зүйн дэвшил	55
2. Үр дагавар	56
3. Хүртээмжээр хангахад тулгарах асуудал бэрхшээл	57
МОДУЛЬ 7: ОНЛАЙН ДАХЬ ХУВИЙН НУУЦ БА МӨРДӨН ХЯНАХ АЖИЛЛАГАА	62
1. Хувийн нууцын тодорхойлолт ба хүрээ	63
2. Өгөгдөл хамгаалах ба Хувийн нууц	65
3. Мөрдөн хянах ажиллагаа	68
Интернэттэй холбоотой лавлагаа	73
МОДУЛЬ 8: ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ	74
1. Танилцуулга	74
2. Хэвлэл мэдээллийн эсвэл Хэвлэлийн зөвлөл: Гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа	74
3. Гомдол гаргах болон эрх зүйн залруулга хийх механизмын хоорондын харилцаа	79
Өөрийн зохицуулалттай холбоотой лавлагаа	86

ТАЛАРХАЛ

Энэхүү гарын авлагыг Эрх зүй ба ардчилал төвийн гүйцэтгэх захирал Тоби Мендел эрхлэн бэлтгэлээ. Тус гарын авлагыг Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр боловсруулав.

ТАНИЛЦУУЛГА

Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг үндсэн суурь эрх чөлөө гэдгийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг. Энэ нь өөрөө маш чухал эрх төдийгүй, бусад бүх эрхийг хүндэтгэх үндэс суурийг бүрдүүлдэг. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүндэтгэхэд гадны халдлагад өртөх, бүхий л эрхүүд эрсдэлд орох нь бий. Бусад бүх эрхийн хамгаалалтыг баталгаажуулах үүргээ гүйцэтгэсний үр дүнд, чухамдаа ардчилал өөрөө үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол хүний эрхийн суурь, язгуур мөн хэмээн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг олон улсын болон үндсэн хуулиар баталгаажуулахдаа цөөн хэдэн өгүүлбэрт багтаан гол мөн чанарыг нь товч тодорхойлдог. Гэхдээ энэ эрх нь өөрөө цогц бүрдэл шинжтэй. Үүний нэг тал нь, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд авч үзэн хамгаалахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болохыг улс орнуудад олон улсын хуулиар зөвшөөрсөн. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь улс орнуудын хувьд зөрчихөөс татгалзах ёстой гэсэн утгаараа эерэг эрх, төдийгүй нийгэм дэх мэдээлэл, үзэл санааны чөлөөт урсгалыг дэмжин баталгаажуулсны эерэг хэмжүүр үзүүлэлт болдог. Эцэст нь, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ярьж буй хүнийг төдийгүй, мөн сонсогчийг хамгаалж, хэвлэл мэдээллийн олон талт байдлыг хөхиүлэн дэмжих үндсэн хэмжүүр болж байдаг юм. Эдгээр бүхий л асуудлууд нь хүний эрхийн нарийн төвөгтэй байдлыг улам нэмэгдүүлнэ.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн сонгож авсан асуудлуудаар буюу нэр төр гутаах, онлайнаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, өөрийн зохицуулалтын асуудлаар сургалт явуулах энэхүү гарын авлагыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний болон хэвлэл мэдээллийн хуулийн хүрээний үндсэн гурван асуудал, тодруулбал хүний нэр төрийг хамгаалах, онлайнаар үг хэлэх, өөрийн зохицуулалтын асуудалд төвлөрч боловсруулав. Тус гарын авлагыг “Хэвлэл мэдээллийн эрх зүйн үндсэн асуудлууд” сургалтын дараагийн шатны гүнзгийрүүлсэн сургалтад зориулж боловсруулсан болно. Энэхүү гарын авлагыг одоогийн зохион байгуулж буй сургалтад ашиглахаар бүтээсэн боловч, цаашид мөн лавлагаа мэдээлэл болгон ашиглах боломжтой.

Энэ гарын авлага нь найман модульд хуваагдах ба модуль бүр нь сургалтын үеэр заах хичээлүүдэд нийцсэн байна. Эхний модулиар энэхүү сургалтын үндэс суурь болсон анхан шатны сургалтад өмнө ашигласан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын гол гол хэм хэмжээг эргэн нягталж байна. Энэ бүлэгт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын баталгаажилт, түүний үндсэн шинж чанарууд, хязгаарлалтын шалгуурын асуудлууд багтах бөгөөд хэвлэл мэдээллийн зохицуулалтын эрх зүйн хүрээний бүхий л гол мэдээллүүдийг багтаасан.

Хоёроос дөрөв дэх модульд энэхүү сургалтын үндсэн сэдэв болж буй нэр төр гутаахтай холбогдох асуудлыг оруулав. Үүнд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хэрэг, ухагдахуун, хамрах хүрээ; өмгөөлөл; шийтгэл, бусад асуудал ба өмгөөллийн үйл ажиллагаа зэргийг нарийвчлан толилуулав. Эдгээр модулиар нэр төр гутаах гэж чухам юу болохоос эхлээд, эрүүгийн хуулийн гүтгэлгийн асуудал, түүнийг өмгөөлөх, ийм хэрэг дээр хэрэглэх шийтгэлийн асуудлаарх өргөн хүрээний мэдлэгийг оролцогчдод олгоно.

Дараагийн гурван модуль буюу таваас долдугаар модуль нь цахим орчинд үг хэлэхтэй холбоотой зохицуулалтын өөр өөр асуудлуудад, тухайлбал интернэтийн

зохицуулалт, интернэтийн хүртээмж, онлайн дахь хувийн нууц ба мөрдөн хянах ажиллагаа сэдвүүд багтаж байна. Эхний хэсэгт интернэтийн зохицуулалтын үндэсний болон олон улсын тогтолцоо бүхий зохицуулалтыг аль алиныг нь багтаасан. Мөн үүнд оюуны өмчийг хамгаалахтай холбоотой асуудлаар болон цахим ертөнцөд агуулгын хязгаарлалт тавих зэрэг болно. Хоёр дахь хэсэгт интернэтийн хүртээмжийг хүний эрхийн үүднээс харж, түүнд нөлөө үзүүлэх практик аргууд, эрх зүйн ойлголтын хувьд энэ үзэл баримтлалын утга агуулгад анхаарлаа хандуулсан. Энэ бүлгийн сүүлийн хэсэгт онлайн ертөнц дэх хувийн нууц ба мөрдөн хянах ажиллагааны чухал асуудлуудад анхаарлаа хандуулсан бөгөөд үүнд дагаж мөрдөх хүний эрхийн гол хэм хэмжээг оруулав.

Төгсгөлийн буюу найм дахь модуль нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хэсэг юм. Өөрийн зохицуулалтын гомдол хянан шийдэврлэх өөрийн зохицуулалтын тогтолцоо болон хохирлыг барагдуулах эрх зүйн зохицуулалтын тогтолцооны хоорондын холбоо хамааралд тухайлан анхаарсан болно.

Хэвлэл мэдээллийн эрх зүй сургалтын хөтөлбөр

**Глоб Интернэшнл төв ТББ / Дойчэ Вэллэ / Тоби Мэндел
2015 оны 10 дугаар сарын 28-30 (2.5 өдөр)**

ӨДӨР 1: Лхагва гараг, 10 дугаар сарын 28

09:00-09:15	Нээлт
09:15-09:45	Танилцуулга, хөтөлбөр, хүлээж буй үр дүн
09:45-10:45	Олон улсын хэм хэмжээг нягтлах нь
10:45-11:00	<i>Цай, кофе завсарлага</i>
11:00-12:30	Нэр төр гутаах: Монголын нөхцөл байдал
12:30-13:30	Үдийн хоол
13:30-14:30	Нэр төр гутаах: Нэр төр гутаах эрүүгийн хууль, ухагдахуун, хамрах хүрээ
14:30-15:15	Нэр төр гутаах: өмгөөлөл
15:15-15:30	<i>Цай, кофе завсарлага</i>
15:30-16:00	Нэр төр гутаах: Шийтгэл, бусад асуудал ба өмгөөллийн үйл ажиллагаа
16:00-17:00	Нэр төр гутаахтай холбоотой үндсэн дасгал ажлууд

ӨДӨР 2: 10 дугаар сарын 29

09:00-10:30	Монгол дахь интернэтийн зохицуулалт: Асуудал, сорилтууд
10:30-10:45	<i>Цай, кофе завсарлага</i>
10:45-12:15	Интернэтийн зохицуулалт
12:15-13:15	Үдийн хоол
13:15-14:30	Интернэтийн хүртээмж
14:30-14:45	<i>Цай, кофе завсарлага</i>
14:45-15:45	Онлайн дахь хувийн нууц болон мөрдөн хянах ажиллагаа
15:45-17:00	Интернэтийн асуудлаарх үндсэн дасгал

ӨДӨР 3: 10 дугаар сарын 30

09:00-10:30	Монголын Хэвлэлийн Зөвлөлийн төлөвшлийн үйл явц
10:30-10:45	<i>Цай, кофе завсарлага</i>
10:45-12:00	Өөрийн зохицуулалт: Холбогдох олон улсын хэм хэмжээ
12:00-12:30	Хаалт
12:30-13:30:	Үдийн хоол

Модуль 1: Олон улсын хэм хэмжээний тойм

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэдэг нэр томъёог сонсоод танд юу бодогдож байна вэ? Энэхүү эрхийн өвөрмөц онцлог шинж нь юу вэ? Хүний эрхийн ямар ойлголт вэ? Үүнийг чухал эрх гэж та хэлэх үү? Яагаад тийм, эсвэл үгүй вэ?

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн тодорхойлолт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭТОУП)-ын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт:

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл:

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална

Хэлэлцүүлэг: Дээрх баталгаануудын хооронд ялгаа бий юу? Эдгээр ялгаа нь илэрхий байна уу? Бодит амьдрал дээр эдгээр баталгаа нь аливаа өөрчлөлт авчрах уу? Үндсэн хуулийн баталгаа нь таны хүсч байгаагаас үр нөлөө багатай байгаа талаар жишээ байна уу?

ИБУТЭТОУП-аар баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх эрхийн 7 гол шинж чанар:

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь **эерэг** болон **сөрөг** талтай;
2. Эрх нь **хүн бүрт** хамаатай.
3. Энэ эрх үг хэлэх эрхээс давж, **хайх, хүлээн авах** (түүний дотор сонсох, эрэн сурвалжлах) эрхийг багтаана.
4. Уг эрхэд хэр зэрэг чухал байхаас үл хамаарч, зөв буруу аль нь ч бай, тэр байтугай олонх хүмүүс доромжлол гэж тооцохыг үл харгалзан **бүхий л төрлийн мэдээлэл, үзэл санаа** хамаарна

5. Хил хязгаарыг үл харгалзан уг эрхийг эдэлнэ. Үүнийг ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд тодорхой заасан. Энэ эрхийг эдлэхэд улсын хил хязгаар хорио саад болохгүй.
6. Үүнд үзэл санааны илэрхийлэл бүхий ямар ч төрлийн агуулгыг уламжлалт, орчин үеийн аль ч аргаар түгээх эрх багтана. Энэ эрхийг нь “өөрийн сонгосон хэвлэлийн болон уран сайхны бусад аргаар түгээх” хэмээн ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд тодорхойлжээ.
7. Төрөөс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг шууд, шууд бусаар хязгаарлах аливаа үйлдэл нь өнгөц харахад хөндлөнгийн оролцоо гэж болохоор. Төрөөс үзэл бодлын эрх чөлөөг хязгаарлаж болох хууль батлах, хэрэгжүүлэх аргаас гадна шууд бус аргаар хязгаарлаж болдог.

2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтууд

- ИБУТЭТОУП-ын 19(3) дугаар зүйлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтад хууль ёсны хэмжүүр тогтоосон:

Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

- (a) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- (b) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах

- Энэ нь хязгаарлалтад гурван талт хатуу шалгуур тогтоосон нь. Үүнд:
 - a. Хуулиар тогтоогдсон байх
 - b. Дээрх (a) болон (b) заалтанд тусгагдсан эрх ашгийн аль нэгийг хамгаалах зорилгоор
 - c. Эрх ашиг хамгаалах шаардлагаас үүдэн гарсан байх

Дасгал 1: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтууд

3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ерөнхий төлөв байдал

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хүрээний тухайд зохицуулалтын ямар хэлбэрийг мэдэхийг та хүсч байна вэ?

Агуулга

Мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж

Эрүүгийн
<ul style="list-style-type: none"> • <i>Үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэг</i> Үндсэрхэг үзлээр, арьс үндсээр, шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийг өдөөн турхирахыг хуулиар хориглох • <i>Үндэсний аюулгүй байдал/нийгмийн дэг журам</i> Зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой • <i>Зүй зохисгүй үг хэллэг/садар самууныг сурталчлах</i> Бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн материал төдийгүй хүүхдийг садар самуунд уруу татсан зэрэг хор хохиролтой агуулга бүхий • <i>Шүүн таслах ажиллагаа</i> Хувь шүүгчийг хамгаалах бус, шүүн таслах ажиллагааны шударга байдлыг хамгаалах • <i>Шашин шүтлэгийг үл ойшоох/Худал мэдээлэл</i> Ардчилсан нийгэмд аль нь ч шаардлагатай биш
Иргэний/захиргааны
<ul style="list-style-type: none"> • <i>Нэр төр гутаах</i> Зүй ёсны өмгөөлөл (үнэн, үзэл бодол, үндэслэл бүхий нийтлэл)-өөр зөвхөн хууль ёсны нэр төрийг хамгаалах, хариуцлага санц нь хязгаартай байх • <i>Хувийн нууц</i> Хувийн нууцыг үндэслэл бүхий шаардлага байх, олон нийтийн ашиг сонирхлыг илүүд үзэх

Хэвлэл мэдээллийн зохицуулалт

Хараат бус зохицуулах байгууллага

Арилжааны асуудлууд

Сэтгүүлчид	Сонин хэвлэл
<ul style="list-style-type: none"> • <i>Тусгай зөвшөөрөл/бүртгэл байхгүй</i> Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх нь хүн бүрт чөлөөтэй • <i>Эх сурвалжийг хамгаалах</i> Мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах эрх • <i>Аккредитаци/давуу эрх олгох</i> Хязгаарлалт бүхий байууллагад нэвтрэн орох давуу эрхийг баталгаажуулсан ба мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тогтоохгүй 	<ul style="list-style-type: none"> • <i>Тусгай зөвшөөрөл байхгүй</i> • <i>Техникийн бүртгэл</i> Шаардлагатай мэдээллээр хангахаас шууд татгалзахдаа үзэмжээрээ шийддэггүй байх • <i>Залруулга хийх, хариу өгөх эрх</i> Гэм хорыг арилгахын тулд залруулга хийх эрхтэй; хууль ёсны эрхийг зөрчсөн бол хариу өгөх эрхийг хангах • <i>Гомдол барагдуулах</i> Өөрийн зохицуулалтыг илүүд үзэх; урьдчилан тогтоосон ёс зүйн кодтой ба зөөлөн санцтай байх
Хувийн өргөн нэвтрүүлэг	Олон нийтийн өргөн нэвтрүүлэг
<ul style="list-style-type: none"> • <i>Тусгай зөвшөөрөл</i> <ul style="list-style-type: none"> - Давтамжийн төлөвлөгөөнд үндэслэх - Олгох процесс ажиллагаа нь шударга, ил тод байх - Үндсэн зорилго нь олон талт байдлыг хөхиүлэн дэмжих; хүйн өргөн нэвтрүүлэг • <i>Баримтлах ёс зүйн код</i> Шийтгэл ногдуулах биш, стандарт тогтоох зорилгоор бүхий л оролцогч талуудын зөвлөгөөнөөр ёс зүйн кодоо боловсруулж батлах 	<ul style="list-style-type: none"> • <i>Хараат бус байдал</i> Хараат бус удирдах зөвлөлөөр удирдуулдаг, олон нийтийн санхүүжилтыг хараат бус эх үүсвэрээс авдаг • <i>Эрх/Мандат</i> Энэхүү эрх мандат нь хуулиар тогтоогдсон байна. Чанартай мэдээгээр олон нийтийг хангах, нийгмийн бүхий л бүлэгт үйлчлэх үүрэг хүлээнэ.

1. Агуулгын дүрэм журам

- Бидний судалж мэдсэнээр, олон улсын хуульд бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлагын үүднээс хууль ёсны ашиг сонирхлыг хангахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болохыг хүлээн зөвшөөрдөг ч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой. Ардчилсан улс орнууд хязгаарлалтын боломжтой хэлбэр бүрийг албан ёсны болгохгүйгээр, харин цөөн хэдэн хязгаарлалтыг л тогтоож өгдөг.

Эрүүгийн хуулийн дүрэм журам

Үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэг

- Дийлэнх улс орнууд үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийг дэлгэрүүлэхийг эрүүгийн хуулиараа хориглодог ба олон улсын хуулиар ч үүнийг шаарддаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20(2)-р зүйлд “Алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглоно” гэж заасан.

Үндэсний аюулгүй байдал/Нийгмийн дэг журам

- Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалахын тулд чөлөөтэй үг хэлэхийг хязгаарлах шаардлага гардаг. Үүний зэрэгцээ, эдгээр шалтгаан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хууль бус хязгаарлалт тогтоохыг хүлцэн өнгөрүүлэхэд түүхэн цаг үед буруугаар ашиглагдаж байсан төдийгүй, тодорхой бус ойлголтууд одоо бараг л хэвээрээ байна.

Зүй зохисгүй үг хэллэг/Садар самууныг сурталчлах

- Зүй зохисгүй үг хэллэгт тооцогдох материал тараахад зарим төрлийн хязгаарлалтыг улс орнууд тогтоодог. Хүүхэд, залуучуудыг хамгаалах нь үүний нэг чухал хэсэг болдог ба насанд хүрэгчдэд зориулсан материалд боломжит хязгаарлалт тавьснаараа насанд хүрээгүйчүүд түүнийг олж авахаас урьдчилан сэргийлдэг. Ихэнх улс орнуудад, зүй зохисгүй үг хэллэгтэй материалын тодорхой төрлүүдийг бүрмөсөн хориглогдог.

Шүүн таслах ажиллагааг хамгаалах

- Шүүхийн захиргааны хууль ёсны дагуу, үйл ажиллагаа хэвийн, саадгүй явуулах баталгааг хангах, шүүх эрх мэдлийг хамгаалах нь хоёулаа шүүн таслах ажиллагааны шударга байдлыг хамгаалахад чухал үүрэгтэй. Хэн ч бай гэрч, шүүгчийг нөлөөндөө оруулах, эсвэл айлган сүрдүүлэх, шүүхэд худлаа ярих (худал мэдүүлэг өгөх), шүүн таслах ажиллагааг тасалдуулахыг хориглосон дүрэм журам байх шаардлагатай гэсэн ерөнхий ойлголт байдаг.

Хэлэлцүүлэг: Монгол Улсад эрүүгийн бусал ямар зохицуулалтууд байдаг вэ? Тэдгээр нь зайлшгүй шаардлагатай юу? Энийг иргэний журмаар шийдвэрлэх болож бий юу?

Иргэний хууль тогтоомж

Нэр төр гутаах

- Улс орон бүр гүтгэлгийн эсрэг хууль тогтоомж гэж нэрлэгддэг нэр төрийг хууль бус халдлагаас хамгаалах тогтоол шийдвэр байдаг. Олон улсын хууль тогтоомжоор ийм хууль нь иргэний хууль байх ёстой гэдэг ба эрүүгийн хуулийн гүтгэлэг нь нийгмийн дэг журмыг хангах үүднээс гэж түүхэнд зөвтгөгддөг байсан ч, одоо энэ үндэслэл дэмжигдэхээ больсон.

Хувийн нууц

- Дийлэнх улс орнууд хувийн нууцыг иргэний хуулиараа мөн хамгаалдаг. Хувийн нууцтай байх ашиг сонирхлыг хамгаалбал зохих дөрвөн төрлийг тодорхойлсон. Үүнд: бусдын орон байранд үндэслэлгүй нэвтрэх, хэн нэгний нэр, хөрөг зургийг ашиглах, хуурамч мэдээлэл хэвлэн нийтлэх, хэн нэгний хувийн амьдралын тухай байж болшгүй нийтэл гаргах.

Мэдээлэл олж авах эрх

- Төрийн байгууллагуудад хадгалагдаж буй мэдээллийг хүн бүр олж авах эрхтэй. Үүнд олон улсын хуулиар хүлээн зөвшөөрсөн үл хамаарлын хязгаарлалт байж болох ба үндэсний хууль тогтоомжоор энэ дамжин хэрэгжинэ.
 - Мэдээлэл олж авахыг дэмжсэн өргөн боломж нөхцлийг бүрдүүлэх
 - Төрийн байгууллагууд мэдээллээ ил болгох идэвхтэй ажиллагааг шаардах
 - Мэдээлэл авах хүсэлтийг шийдвэрлэх нарийн тодорхой процедурыг бий болгох
 - Мэдээлэл олж авах эрхийн үл хамаарлыг явцуу, маш тодорхой тогтоох
 - Бие даасан давж заалдах механизмыг бүрдүүлэх

Хэвлэл мэдээллийн зохицуулалт

- Гурван гол зарчим нь ардчилсан хэвлэл мэдээллийн зохицуулалтын үндсэн тулгуур болдог.
 - a. Эрх чөлөө: Тогтоол шийдвэр нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулахад ч, эсвэл агуулгын зохицуулалтын хувьд ч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалтыг хэтрүүлж болохгүй.
 - b. Хараат бус байдал: Тогтоол шийдвэрээр хэвлэл мэдээлэлд улс төрийн болон арилжааны хөндлөнгийн оролцоо нөлөөллийн аль алинаас нь урьдчилан сэргийлэх ёстой.
 - c. Олон ургальч байдал: Тогтоол шийдвэр нь хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдлыг дэмжих ёстой

Хараат бус зохицуулах байгууллага

- Хэвлэл мэдээллийн зохицуулагч байгууллага нь улс төр, арилжааны хөндлөнгийн оролцоо нөлөөллөөс хамгаалагдахын тулд хараат бус байх ёстой. Хараат бус байх шалтгаан нь маш тодорхой харагдаж байна. Ийм хамгаалалт байхгүй бол зохицуулах байгууллагын шийдвэр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон нийтийн ашиг сонирхлоос илүүтэй улс төрийн, эсвэл арилжааны талаасаа нөлөөлөлд орох болно. Энэ нь олон улс орны хувьд ноцтой асуудал болоод байна. Бодит байдал дээр хараат бус байдлыг баталгаажуулах нь маш хэцүү. Энэхүү хараат бус байдлыг баталгаажуулах арга зам нь улс орны улс төр болон институт/зохион байгуулалтын нөхцөл байдалд нийцсэн байх ёстой.

Сэтгүүлчид

- Бусад мэргэжлээс эрс ялгаатай нь, хүний үндсэн суурь эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө эдэлснээр сэтгүүл зүйн практик бий болдог учир сэтгүүлчдэд тусгай зөвшөөрөл олгох нь хууль ёсны биш юм. Олон улсын хуулиар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэдгээр ч зөвтгөж болдоггүй учраас сэтгүүлчдийг бүртгэх тогтолцоо нь ч хууль ёсны биш юм.
- Олон улсын хуулиар сэтгүүлчдийн хувьд хоёр эерэг хамгаалалтыг хүлээн зөвшөөрдөг:
 - Сэтгүүлчид мэдээллийн нууц эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрхтэй. Эс тэгвээс тэдгээр эх сурвалж нь эхний ээлжинд олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн мэдээллийг гаргаж тавихаа болино.
 - УИХ, мөн шүүх зэрэг хязгаарлалт бүхий газруудад нэвтрэх давуу эрхтэй байх ёстой. Тэдгээр газарт юу болж буй талаар олон нийтэд өргөнөөр мэдээлж байхын тулд үүнийг баталгаажуулж өгдөг.

Сонин хэвлэл

- Ихэнх ардчилсан улс оронд хэвлэл мэдээллийн тусгай хууль байхгүй байна. Улс орнуудын сонин хэвлэлийг зохицуулах тусгай дүрэм журам, тогтоол шийдвэрт дараах зарчмыг баримтлах шаардлагатай:
 - Сонин хэвлэлд тусгай зөвшөөрөл шаардах нь хууль ёсны биш (өөрөөр хэлбэл, хэвлэл байгуулахад албан ёсны зөвшөөрөл шаардах гэх мэт).
 - Тэр ч байтугай, хэвлэл мэдээлэлд техникийн бүртгэлийн систем ч урвуулан ашиглагдаж болзошгүй тул шаардлагагүй гэж үздэг. Хэрэв ийм тогтолцоо байгаа бол энэ нь хэт төвөгтэй, дарамттай байх ёсгүй.
 - Иргэний хуулиар заасан хувийн нууцад халдах, нэр төр гутаахын эсрэг гомдол барагдуулах сайн тогтолцоо нь алдаагаа засах, хариу эрх олгох байдаг. Гэхдээ энэ нь чөлөөтэй үг хэлэх эрхийг хязгаарлахад буруугаар ашиглагдахааргүй зүй ёсны, маш нарийн тодорхой байх шаардлагатай.
 - Мэргэжлийн ур чадварыг дэмжих, хэвлэл мэдээллийн талаар гаргасан гомдолд хариу өгөх өөрийн зохицуулалтын тогтолцоо нь буруу байдлаар урвуулан ашиглагдахаагүй байхыг илүүд үзэх ёстой. Хэвлэлийн зөвлөл нь хуулиар байгуулагдсан бол хараат бус байж, түүнд хэвлэл мэдээллийн гишүүдийн хүчтэй бүрэлдэхүүнийг оролцуулах нь тохиромжтой.

Хувийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч

- Сонин хэвлэлээс ялгаатай нь, олон нийтийн хязгаарлагдмал нөөц болох агаарын долгионы эмх цэгцтэй хэрэглээг бий болгох зорилгоор л өргөн нэвтрүүлэгт тусгай зөвшөөрөл шаардлагатай байна.
- Олон улс оронд, өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох, агуулгад хяналт тогтоох аль алинд зохицуулалт хийж байна.
- Давтамжийн нэгдсэн төлөвлөгөөн дээр тулгуурлан олон нийтийн, арилжааны болон хүйн өргөн нэвтрүүлгүүдэд адил тэгш давтамж авах боломжтойгоор хуваарилалтыг хийж, тусгай зөвшөөрөл олгоно. Олон талт байдлыг дэмжсэн, өмчлөлийн хэт их төвлөрөл бий болохоос хамгаалах зэрэг зорилгод нийцүүлэн урьдчилан тогтоож, нийтэд зарласан шалгуур үзүүлэлтээр давтамж хүссэн өргөдлийг үнэлж дүгнэнэ.

- Өргөн нэвтрүүлгүүдэд хөтөлбөрийн хамгийн наад захын стандарт, баримтлах ёс зүйн кодыг тогтоож өгөх нь түгээмэл байдаг. Өргөн нэвтрүүлгийн баримтлах ёс зүйн код нь бүхий л оролцогч талуудтай зөвшилцөн боловсруулагдсан, кодоо зөрчвөл хүлээлгэх хариуцлага санкц хэмжээндээ, тохирсон байх хэрэгтэй.

Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид

- Бүхий л хэвлэл мэдээллийн нэгэн адил олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч нь засгийн газрын оролцоо, ялангуяа, удирдах зөвлөлийг томилоход оролцох арга замаар нөлөөлөхөөс хамгаалагдах ёстой.
- Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь арилжааны өргөн нэвтрүүлгийнхээс илүү баялаг, өргөн хүрээний агуулгатай хөтөлбөр нэвтрүүлэгтэй байх зорилт тавьдаг. Үүний тулд улс орны эрх ашиг, онцгой хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээ сурвалжилга хийх эрхийг нь хуулиар тодорхой тогтоож өгдөг. Улс төрийн дарамт шахалтаас хамгаалагдсан байхаар хуульд заасан боловч, тэдэнд олон нийтийн санхүүжилт мөн хэрэгтэй.

Хэлэлцүүлэг: Монгол улсын олон нийтийн өргөн нэвтрүүлэг хэр зэрэг хараат бус байна вэ? Түүний хараат бус байдлыг сайжруулахад практикт ямар арга хэмжээ хэрэгжүүлж болох вэ?

Лавлагаа

1. *Inter-American Declaration of Principles on Freedom of Expression*, adopted by the Inter-American Commission on Human Rights at its 108th Regular Session, 19 October 2000, available at: <http://www.iachr.org/declaration.htm>
2. *Declaration of Principles on Freedom of Expression in Africa*, adopted by the African Commission on Human and Peoples' Rights at its 32nd Session, 17-23 October 2002, available at: http://www.achpr.org/english/declarations/declaration_freedom_exp_en.html
3. Declaration on the Freedom of Expression and Information, adopted by the Committee of Ministers on 29 April 1982. Available at: [http://www.coe.int/t/dghl/standardsetting/media/Doc/CM/Dec\(1982\)FreedomExpr_en.asp#TopOfPage](http://www.coe.int/t/dghl/standardsetting/media/Doc/CM/Dec(1982)FreedomExpr_en.asp#TopOfPage)
4. Joint Declarations by the special international mandates on freedom of expression, available at: <http://www.osce.org/fom/66176>
5. ARTICLE 19, *Central Asian Pocketbook on Freedom of Expression*. Available at: <http://www.article19.org/data/files/pdfs/tools/central-asian-pocketbook.pdf>

Модуль 2: Нэр төр гутаах

Хэлэлцүүлэг: Та нэр төр гутаасан явдлыг хуулиар шийдвэрлэхэд хүргэдэг гол шалтгааныг юу гэж үзэж байна? Нэр гутаахтай холбоотой хуулиудад болзошгүй асуудал, эрсдэл тулгардаг гэж та бодож байна уу? Монголд энэ төрлийн эрсдэлүүд байдаг гэж та үзэж байна уу?

1. Ухагдахууны тодорхойлолт

Эерэг онцлогууд

- “Нэр төр гутаахтай холбоотой” хууль хэмээх өргөн хэрэглэгддэг хэллэгийг хувь хүний нэр төр, мэдрэмжийг хамгаалдаг бүхий л төрлийн хуулийг хэрэглэхдээ дурддаг.
- Нэр төр гутаахтай холбоотой хууль бүх улсад байдаг ч энэхүү хэллэгийн хамрах хүрээ нь гүтгэх, хов жив тараах, доромжлох, үл тоомсорлох гэх мэт олон ухагдхууныг тодорхойлдог. Эдгээр хуулийн агуулга, хэлбэр нь орон бүрт ялгаатай, өөр байдаг. Зарим улсад, “нэр төр гутаахтай холбоотой хууль” хэмээн тусгайлсан хууль байдаг хэдий ч ихэнх орнууд, тухайлбал, Монгол улс энэхүү сэдэвтэй холбоотой заалтуудыг эрүүгийн хууль эсвэл иргэний эрх зүй гэсэн гол хуулиуддаа тусгасан байдаг.
- Нэр төр гутаахтай холбоотой хуулиуд нийгмийн чухал зорилгын төлөө, тухайлбал, хувь хүний нэр хүндийг хамгаалах, эсвэл, асуудлыг арай өөрөөр авч үзвэл, хүмүүсийн нийгэмд эзэлдэг байр суурь, хүндлэлийг үгүй болгож мэдэх зүй бус мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэхэд үйлчилдэг юм.
- Зарим орны хуулинд ам, хэлээр (доромжлох) ба сонин хэвлэл ашиглан (гүтгэхийн ялгааг гаргаж өгсөн байдаг. Дээрх хоёрын тухайд, сонин хэвлэл олон хүнд хүрдэг учраас гүтгэлэгийг ерөнхийдөө илүү ноцтой гэмт хэрэг гэж тооцдог. Үүнтэй ижил шалтгаанаар, орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, тухайлбал, радио, телевизээр дамжуулан нэр төр гутаасан, гүтгэсэн мэдэгдэл тараасан тохиолдолд хэдийгээр, яриа ярилцлага маягаар илэрхийлсэн байсан ч гүтгэлэг гэсэн төрөлд хамааруулан авч үздэг.
- Энэхүү сонирхлыг урьдал болгох үүднээс, энэ төрлийн үр нөлөө үзүүлэх хандлагатай мэдэгдэл нь хэвлэсэн, өргөн нэвтрүүлгээр дамжсан, үгээр илэрхийлсэн эсвэл өөр аль нэг хэлбэрээр эдгээртэй холбогдсон байх ёстой.
- Үр дүнд нь нэр төр гутаахтай холбоотой хууль заавал үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг илэрхийлсэн байх ёстой. Хүний нэр төр хамгаалах шаардлага ба хүний үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хоорондох зохистой тэнцвэр буюу алтан дундажийг олоход асуудлын гол нь оршдог.

Сөрөг онцлогууд эсвэл юуг гүтгэлэг, доромжлол гэж тооцохгүй байх

- Олонх орнууд үүнтэй эндүүрч болмоор олон төрлийн хуультай байдаг ба хэдийгээр энэхүү нэр томъёог өргөн утгаар авч үздэг ч нэр төр гутаахтай холбоотой хуулийг бусад хуулиас ялгах хэрэгтэй юм. Үүнд үзэн ядсан үг хэллэг, шашин шүтлэгийг доромжлохын эсрэг ба хувийн нууцын тухай хуулиуд багтана.
- Шашин шүтлэг, арьс өнгө, үндэстэн, ястны онцлог шинжээ хадгалсан бүлэг хүмүүсийн эсрэг хүчирхийлэх эсвэл ялгаварлан гадуурхах, дайсагнахыг уриалсан мэдэгдэл хийхийг хориглосон хуулийг үзэн ядах үг хэллэгийн тухай хууль гэнэ. Зарим нэгэн хэрэг дээр “ бүлэг хүмүүсийг доромжлон гутаасан” хэмээх нэр томъёог тухайн хуулиас иш татан хэрэглэх нь бий. Гэсэн хэдий ч, энд

нэр төр гутаахтай холбоотой хуулиас ялгагдах хоёр чухал ялгаа байдаг: нэгдүгээрт, үзэн ядсан үг хэллэгийн тухай хууль нь эмзэг бүлгийн нэр хүндийг хамгаалахаас илүүтэй тэдний аюулгүй байдал ба нийгмийн тэгш эрхийг хангахыг зорьдог ба хоёрдугаарт, хувь хүн эсвэл хуулийн этгээдийг (тухайлбал, бизнес эсвэл ашгийн бус байгууллага) хамгаалахаас илүүтэй үзэн ядсан үг хэллэгийн тухай хууль нь тодорхой нэг шинж чанараараа бусдаас ялгардаг хэсэг бүлэг хүмүүсийг хамгаалахыг чухалчилдаг юм.

- Шашин шүтлэгийг элэглэн дооглох, эсвэл үгүйсгэн доош хийхийг шашин шүтлэгийг доромжлохын эсрэг хуулиар хориглодог. Шашин шүтлэгийг доромжлохын эсрэг хуулийн нэр төр гутаах хуулиас ялгагдах онцлог нь энэ хуулиар хувь хүн эсвэл тухайн шашны нэр хүндийг тусгайлан хамгаалдаггүй. Харин ч тухайн шашныг даган баримталдаг хүмүүсийн сүсэг бишрэл буюу мэдрэмжийг хамгаалдаг гэвэл илүүтэй зохино.
- Жирийн иргэн хүний хувийн амьдралд хууль бусаар нэвтрэх эсвэл нарийвчилсэн мэдээллийг нийтлэхийг хориглодог хуулийг Хувийн нууцын тухай хууль гэдэг. Нэр төр гутаахтай холбоотой хуулиас эрс ялгаатай нь *үнэн* баримтыг тухайлбал, орон гэрт нь нууцаар авсан бодит гэрэл зураг сэлтийг түгээхийг хувийн нууцын тухай хуулийг хэрэглэн хориглож болдог. Цаашилбал, эдгээр бодит баримтын үр нөлөө бага, холбогдох этгээд буюу хувь хүний нэр хүндийн талаарх чухал материал гэж тооцогддоггүй. Гомдол мэдүүлэгч этгээд хууль бус аргаар тухайн эрэгтэй эсвэл эмэгтэйн хувийн нууцад халдсан эсэх нь асуудлыг шийдвэрлэгч хүчин зүйл болдог. Зарим тохиолдолд, хувийн нууцын тухай хууль ба гүтгэлэг, доромжлолын тухай хууль давхцах нь бий. Иймэрхүү төрлийн хэргүүд, жишээлбэл, нууцаар авсан гэрэл зургийг харсан хэн нэгэн тухайн хүнийг бусадтай амрагийн холбоотой гэсэн буруу ташаа дүгнэлт хийж болох юм.
- Нийгмийн хэв журмын тухай хууль нь эмх замбараагүй байдал эсвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой ба гэмт хэрэгт өдөөн турхирахыг хориглох мөн цагдаагийн мөрдөн байцаах шатны нууцлал ба тэр талын мэдээллийн нууцлах журам зэргийг багтаасан байдаг. Түүхэн эх сурвалжаас харахад, нийгмийн хэв журмын ба гүтгэлэг, доромжлолын тухай хуулиудын хооронд нягт уялдаа холбоо байжээ. Жишээлбэл, Нэгдсэн Вант Улсын Гүтгэлэг, доромжлолын тухай эрүүгийн хуулийн гарал үүсэл нь 1275 онд гаргасан Вестминстерийн Тогтоолоос эхтэй бөгөөд үүнд Дээдэс, язгууртнуудыг доромжлохыг хориглосон заалтыг тусгахдаа:

... хаан эзэн эсвэл гүнт улсын дээдэс язгууртан ба тэдний харьяат ард иргэдийн хооронд хов жив тараан дэлгэрүүлэх тэгснээр олныг санааг үймүүлэх эсвэл эмх замбараагүй байдал үүсгэж болох аливаа худал хуурмаг мэдээ эсвэл аман яриа ярих ба нийтлэхийг завдсан хэнийг ч хатуу цээрлүүлнэ...

Хэлэлцүүлэг: Гүтгэлэг, доромжлолын тухай хууль ба бусад төрлийн үзэл бодлоо илэрхийлэх асуудлын хоорондох эдгээр ялгааг шударга гэж та бодож байна уу? Эдгээр санаа хоорондоо ихэнх нь давхцаж байгаа эсвэл тэдгээр нь хоорондоо эрс ялгаатай гэж та бодож байна уу? Бусдыг ам хэлээр доромжилсноор нийгмийн эмх замбараагүй байдал (хүчирхийлэл гэх мэт) үүсгэх асуудалд хөтөлж мэдэх эрсдэл Монголд байсаар байгаа гэж та бодож байна уу?

Нэр хүнд ба мэдрэмжийг сөргүүлэн тавих нь

- “Гүтгэлэг ба доромжлолын эсрэг хууль “ хэмээх нийтлэг нэрээр нэршсэн өргөн хүрээтэй хууль тогтоомжийн хүрээнд, хувь хүнд нийгмийн бусад гишүүдийн зүгээс үзүүлдэг хүндэтгэл гэж тодорхойлж болох *нэр хүндийг* үнэхээр хамгаалах зорилготой хуулиуд ба хувь хүний нийгэмд эзлэх байр суурь буурсан эсэхээс үл

хамааран тухайн хүнд санаа сэтгэлийн хохирол учруулахаас сэргийлдэг хуулиудын хоорондох чухал ялгааг авч үзэх хэрэгтэй юм.

- Санаа сэтгэл буюу мэдрэмжийг хамгаалдаг хуулиуд цэвэр субъектив үнэ цэнэтэй зүйлийг хамгаалахыг зорьдогт гол ялгаа нь оршино. Эрэгтэй, эмэгтэй хэн боловч тухайн хүний өөрийнх нь хэлж ярьснаар зөвхөн баримт нотолгоо гэж тооцож болохоос бус хэн нэгэн үнэхээр хохирсон эсэхийг батлан тайлбарлах гадаад хүчин зүйл энд байхгүй юм. Нэр хүнд бол харин эсрэгээрээ объектив ойлголт ба: гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр хэн нэгний нэр хүндэд хор хохирол учирсныг батлах боломжтой. Жишээлбэл, бизнесийн компанийн эсрэг хилсээр буруутгасан нийтлэл гарсны дүнд ашиг орлого нь огцом буурсан, эсвэл хувь хүн найз нөхдөө алдсан болохыг тэднээс ирүүлсэн уурлаж хилэгнэн бичсэн захидлуудыг үзүүлэх зэргээр батлаж чадах юм.
- Санаа сэтгэл буюу мэдрэмжийг хамгаалдаг хуулийн тухайд гэвэл, нэхэмжлэгч талд шалтгаангүйгээр давуу нөхцөл олгодог бөгөөд зарга мэдүүлэгч этгээд хэлэлцэгдэж байгаа мэдэгдэл гэмт хэргийн шинжтэй болохыг шүүхэд ятган үнэмшүүлэхэд хангалттай ба шүүгдэгч талын хувьд аливаа нэгэн эсрэг баримт нотолгоо гаргах үндсэндээ боломжгүй байдаг. Мэдээжээр, энэ төрлийн хуулийг нөлөө бүхий этгээдүүд өөрсдийн шүүмжлэгчид рүү довтолгоо хийхдээ өргөнөөр хэрэглэдэг юм. Ардчилалд зайлшгүй байх ёстой нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх үүднээс олонх орнууд өөрсдийн хуулиас жинхэнэ “нэр хүнд”-ийн төлөө гэгдэх хувь хүний мэдрэмжийг хамгаалсан заалтыг авах болсон юм. Гэхдээ энэ нь хувь хүн гэмт хэргийн шинжтэй мэдэгдэлийн эсрэг хууль ёсны арга хэмжээ авах ёсгүй гэсэн үг биш бөгөөд гэхдээ нэхэмжлэгч талууд тэдний талаарх бусад хүмүүсийн үнэлэмж буурсан болохыг амжилттай батлан харуулах хэрэгтэй болж байгаа юм.
- Тухайн хууль нэр хүнд юмуу эсвэл мэдрэмжийг хамгаалж байгаа эсэх нь өгөгдсөн хуулийн бодит заалт ба түүний үр дагаварт хийсэн дүн шинжилгээнээс хамаарна. Хуулийн нэр томъёоны яг оносон тайлбар олонх тохиолдолд асуудлын хариу болох ба, зарим үед хууль бодит байдал буюу амьдралд хэрхэн нийцэж байгааг судлах шаардлагатай. Дотоодын хууль тогтоомжид хэрэглэж буй нэр томъёо бодит байдал дээр янз бүр байх ба тодорхой нэг хууль ямар төрөлд хамаарахыг шууд хэлэх боломж тэр бүр байдаггүй.
- Аливаа орны дотоодын хууль тогтоомжид “доромжлол” ба “нэр хүнд” гэхээс гадна “нэр төр” гэсэн нэр томъёог түгээмэл хэрэглэдэг. “Нэр төр” гэсэн үг ихэнхдээ хоёрдмол утга агуулах ба: үүнийг хэн нэгэн хүний омогшил, бахархалыг тээсэн дотоод сэтгэл ба тухайн хүний талаарх нийтийн үнэлэмж хоёуланд нь хамааруулан хэрэглэж болох юм. Дээр дурдсанчлан, аливаа тохиолдолд, хуулийн жинхэнэ шинж чанар түүнийг хэрхэн тайлбарласан ба бодит нөхцөлд хэрхэн нийцсэн гэдгээс шалтгаална.

Хэлэлцүүлэг: Мэдрэмжийг хамгаалах тухай санааг та юу гэж үзэж байна? Объектив ойлголтыг хамгаалах нь хангалттай бишүү эсвэл бид бас субъектив мэдрэмжийг хамгаалах шаардлагатай юу? Хэрвээ бид мэдрэмжийг хамгаалах бол бид яаж илүү сайнаар өмгөөлөл үзүүлж чадах вэ?

Эрхийн тэнцвэржүүлэх нь

- Нэр төр гутаахтай холбоотой хууль нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах замаар - өөр нэг зайлшгүй чухал ашиг сонирхол болох - хүний нэр хүндийг хамгаалдаг.
- Нэр хүндийг хамгаалах нь өөрөө хүний эрхийг хамгаалж буй хэрэг юм. Иймээс, Иргэний улс төрийн эрхийн олон улсын пакт (ИУТЭОУП)-ын 17 дугаар зүйлд дурдахдаа:

1. Захидал харилцаа эсвэл гэр бүл ба хувийн нууцад нь хууль бусаар халдах эсвэл дур мэдэн байцаах явдалд хэн ч өртөх ёсгүй бөгөөд мөн тухайн хүний алдар нэр ба нэр хүндэд хууль бусаар халдах ёсгүй.
 2. Ийм төрлийн халдлага, хөндлөнгийн оролцооны эсрэг хүн бүр хуулийн хүрээнд хамгаалуулах эрхтэй.
- Үүнд бэлэн хэвшсэн, шаталсан ангилал байхгүй ба нарийвчлан тодорхойлсон дүрэм журамтай уялдуулсан тэнцвэрт байдал зайлшгүй байх ёстой. Мөн гэмтэн этгээд өмгөөлөгчид хандах боломжтой, буруутгагч тал зайлшгүй нотлож чадахаар элементүүдийг нарийн тодорхойлсон хуулийн систем оролцоно.
 - Үүний зэрэгцээ, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг өргөн хүрээнд хамгаалдаг бол (хууль ёсны хязгаарлалтын сэдэв) нэр хүндийг хамгаалах эрхийг зөвхөн “хууль бус халдлага дайралтаас ” хамгаалдаг. Энэхүү ангилал нь үзэл бодлоо илэрхийлэх эрхэд хамгаалалтын нэмэлт баталгаа болж улмаар улс орнуудад ямар төрлийн халдлагыг тэд хууль бус гэж үзэх хүсэлтэйгээ шийдэх, цар хүрээг тодорхойлох боломж олгох зорилготой юм.
 - Нэр төр ба нэр хүндэд хамаарах зөвхөн зориудын ба ноцтой хөндлөнгийн дайралтад “ халдлага” гэсэн үгийг хэрэглэх нь оновчтой юм. ИУТЭОУП-ыг батлахад хүргэсэн зөвшилцөлийн үеэр нэлээд хэдэн Улс орнууд шударга санал сэтгэгдэл эсвэл үнэн бодит мэдэгдэл хэзээ ч “халдлага” гэсэн тодорхойлолтод хамаарахгүй хэмээн мэдэгдэж байв.
 - ИУТЭОУП-д “нэр төр” ба “нэр хүнд”-ийн хоорондох ялгааны ач холбогдолыг тун бүрхэг гаргасан байдаг. Пактыг батлахад хүргэсэн хэлэлцүүлгийн үеэр зарим төлөөлөгчид тодорхой бус утга агуулсан гэсэн үндэслэлээр “ нэр төр” гэсэн үгийг эсэргүүцэж байсан юм. Гэсэн хэдий ч эцсийн хувилбарт “ нэр төр” гэсэн үгийн үлдээсэн нэг шалтгаан нь зарим төлөөлөгчид “ нэр хүнд” ба “нэр төр” бол хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлдэг хоёр өөр хүчин зүйл гэж үзсэнтэй холбоотой юм. Энэ өнцгөөс харвал, “ нэр хүнд” тухайн хүний ажил мэргэжил эсвэл нийгмийн байр сууртай илүү холбоотой бол “ нэр төр” нь ёс суртхуунтай хэм хэмжээг илэрхийлдэг. Урагшгүй хэн нэгнийг хилсээр буруутгах нь, жишээлбэл, нэр хүндэд халдсан хэрэг бол, хүнийг хулгайд хардах нь нэр төрийг нь гутаасан явдал болно. Жишээ авсан текстээс харвал, “ нэр төр” гэсэн үг энэ тохиолдолд субъектив ойлголт мэдрэмжтэй ойролцоо утгатай бус харин ч хувь хүний нийгэмд эзэлдэг байр суурь гэсэн объектив үнэлэмжийн асуудал болж таарч байна.
 - Нэр хүндээ хамгаалах эрх нэг талаасаа Төрийн эсрэг хандсан ба: шийдвэр гаргагч байгууллагуудад жирийн иргэн хүний нэр хүндэд хууль бусаар халдахаас татгалзах үүрэг ногдуулж байна. Үүнээс гадна ИУТЭОУП-ын 17 дугаар зүйл хувь хүний нэр хүнд “хуулиар хамгаалуулах” эрхээ эдлэх баталгааг Төрөөс шаардаж байгаа юм. Ингэснээр, улс орон бүр Төрийн байгууллагууд эсвэл эрх мэдэлтнүүд жирийн иргэн хүний нэр хүндэд сэв суулгасан тохиолдолд иргэд хуулийн хариуцлага тооцохыг шаардах боломж бүрдүүлсэн хууль тогтоомжтой байх ёстой гэдэг нь эндээс тодорхой харагдана. Хувь хүний халдлагаас хүний нэр хүндийг хамгаалсан хууль батлахыг Төрөөс шаардаж байгаа, мөн нэр хүндээ хамгаалах эрхийн эерэг талыг гаргасан эсэх нь тодорхойгүй. Гэсэн хэдий ч, дээр дурдсанчлан, бодит амьдралд бүх улс орнууд цаасан дээр ийм төрлийн хуультай байна.
 - Нэр хүнд ба үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хоорондох энэхүү тэнцвэрт байдлыг удирдлага болгохдоо, мэдээ мэдээлэл тараасан хүний ашиг сонирхол буюу зөвхөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөхөөс гадна - нийгэмд мэдээ мэдээлэл, санаа бодлоо чөлөөтэй

илэрхийлэх эрхтэй олон нийтийн түгээмэл ашиг сонирхлыг бас бодолцож, үүн дотроо олон нийтийн мэдээлэл авах эрх, улмаар мэдээлэлтэй иргэд шийдвэр гаргах боломжийг бас чухалчлах хэрэгтэй. Иймд зөвхөн хариуцлага хүлээлгэхийг урьдал болголгүй энэ нь мөн бусдын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг хүмүүст ч гэсэн үр нөлөө үзүүлдэгийг зайлшгүй бодолцох ёстой.

- Олон улсын хуулийн дагуу нэр төр гутаахтай холбоотой хуулиуд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг бүх хуулийн адилаар өмнө дурдсанчлан гурван талт шалгуурын дагуу зөвд тооцогдох ёстой. Тэнцвэрт байдлын чухал хэсэг нь доор дурдсан нэр төр гутаахтай холбоотой өмгөөллийн системийн дагуу хийгдсэн байна.
- Нэр төр гутаахтай холбоотой хуулиуд нь олон янзын шалтгааны улмаас нэр хүнд ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зохист тэнцвэрт эсрэгээр нөлөөлж болох юм. Зарим оронд, нэр төр гутаахтай холбоотой хуулиуд хувь хүний нэр хүндийг хамгаалах хууль ёсны зорилгоосоо хэтэрч Төрийн тэргүүн, гаднын улсын засгийн газар, туг далбаа, ба аль эсвэл Төрийн бэлэг тэмдэг зэрэг олон зүйлийг шүүмжлэхийг хориглосон байдаг. Төрийн зүтгэлтнүүд ба албаны хүмүүс мэдээжээр, өөрсдийгөө шүүмжлэлээс хамгаалахын тулд нэр төр гутаахтай холбоотой хуулийг урвуулан ашигладаг ба зарим улс оронд, тэдгээр эрх мэдэлтнүүд нэр төрөө хамгаалах хатуу хэрцгий хууль мөрдөж, шүүмжлэлтэй санал бодол хэлэх, чөлөөт мэтгэлцээн өрнүүлэхийг хааж боомилдог. Нөгөө талаар, маргааныг шүүхээр шийдвэрлэх олон шат дамжлага, нэр төр гутаасан хэргийг өмгөөлөх үйл ажиллагааны үнэ хөлс зэрэг нь олон нийтэд хамааралтай асуудлаархи чөлөөт хэлэлцүүлэгийг зогсоодог. Хэтэрхий хатуу шийтгэл улс төрийн чөлөөт хэлэлцүүлэг өрнөхөд саад болдог бол өмгөөллийн уламжлалт хэлбэр ардчилсан нийгэмд үг хэлэх эрхийг хамгаалах хангалттай баталгааг гаргаж өгдөггүй.
- Нэр төр гутаахтай холбоотой хуулиудыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтын стандартад нийцүүлэхийн тулд дараах хэлбэрээр боловсруулсан байвал зохино. Үүнд:
 1. Хуулийн хамрах хүрээ түүн дотроо хэн шүүхээр заалдаж байгаатайгаар холбогдуулан аль болох нарийн оновчтой тодорхойлох замаар хуулийг урвуулан ашиглахын эсрэг ялган зааглах;
 2. Нэр төр гутаасан хэргээр шүүхэд дуудагдсан хүмүүс зохих сайн хамгаалалт авах боломжийг баталгаажуулах; ба
 3. Нэр төр гутаасан үйлдэлд хувь тэнцсэн хариу өгөх боломжтой арга хэмжээний бүтцийг бүрдүүлэх
- Нэр төр гутаахтай холбоотой **сайн** хууль гэдэг нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хувь хүний нэр төрийг хамгаалах ойлголтын хооронд алтан дундажийг баримталсан үндэслэлтэй байх ба дараах байдлаар тодорхойлж болох юм. Энэ нь хүмүүсийн нэр төрд толбо суулгахаар бодит үнэнийг гуйвуулсан худал хуурмаг мэдээ, мэдээллийн эсрэг тэднийг хамгаалах зорилготой хууль юм. Хуулийн тодорхойлолт нь дөрвөн хэсгээс бүрдэнэ. Нэр төрийг гутаасан мэдээ мэдээлэл нь дараахь шинжийг агуулсан байх ёстой. Үүнд:
 - Худал хуурмаг байх (Үнэнийг хамгаалах тухай дор дурдсан хэсгээс тодруулна уу)
 - Үнэнийг гуйвуулсан байх (Санал бодлыг хамгаалах тухай хэсгээс тодруулна уу)
 - Олны өмнө хэлсэн байх, Дор хаяж хөндлөнгийн нэг этгээдийн хажууд хэлсэн байх, (өөрөөр хэлбэл ярьж буй этгээдээс гадна хөндлөнгийн хүн ярианд оролцсон байх)

- Тухайн хүний нэр төрд толбо суулгах буюу гутаах; энэхүү зорилгын үүднээс авч үзвэл нэр хүнд гэдгийг нийгмийн бусад гишүүдээс тухайн хүнд үзүүлж буй хүндэтгэл гэж тодорхойлж болно; тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь буурахгүй ч гомдож гутрах байдлаар илрэх хүмүүсийн мэдрэмжийг үүнд хамааруулахгүй, мэдрэмж нь субъектив ойлголт бол нэр хүнд гэдэг нь бодит шалгуураар хэмжигддэг ба гомдол гаргагчаас гадна өөр бусад хүмүүс мэдээллийг сонссон байдаг.

Хэлэлцүүлэг: Дээр дурдсан аргаар нэр төр гутаах үйлдлийг хязгаарлах нь зохимжтой гэж та бодож байна уу? Худал баримт дурдаагүй мөртөө үнэхээр шударга бус санал бодлыг юу гэж үзэх вэ? Хувь хүний нэр хүндэд халдаагүй хэрнээ тухайн хүний сэтгэлийг маш ихээр гонсойлгосон мэдэгдэлийг яах ёстой вэ?

2. Хамрах хүрээ

- Олон улсын хуулийн дагуу Төрийн байгууллагууд (тухайбал, төрийн яамд, засгийн газрын агентлагууд, парламент (УИХ) эсвэл хотын засаг захиргааны байгууллагууд) ямар ч тохиолдолд нэр төр гутаасан хэргээр шүүхээр заалдах ёсгүй. Үүнийг олон улс орны Дээд шүүхээс дэмжин сайшаасан байдаг.
 - *Жишээ нь:* Дербиширэ мужийн Зөвлөл ба Таймс Ньюспепер ХХК. Лордуудын танхимаас орон нутгийн шийдвэр гаргагчид нэр төр гутаасны хохирлын эсрэг арга хэмжээ авахыг хориглосон нийтлэг хууль баталжээ. Олон нийтийн сонгуульт байгууллага учраас “эдгээр байгууллага нь олон нийт чөлөөтэй шүүмжлэхэд эмзэглэхгүй, нээлттэй байх ёстой. Нэр төр гутаасан хэмээн иргэний шүүхээр далайлгах нь үг хэлэх эрх чөлөөнд зайлшгүй саад тотгор учруулах болно.” гэжээ.
 - *Жишээ нь:* Тамил Наду ба Ражгопал муж улс, Дербиширэ мужийн санаачлагыг дэмжин Энэтхэгийн Дээд Шүүхээс “Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа ба бусад байгууллагууд зэрэг төрийн эрх мэдлийг хэрэгжүүдэг байгууллагууд нэр төр гутаасан хэргээр шүүхэд хандах ёсгүй гэж заажээ. Энэ байр суурийг мөн АНУ ба Өмнөд Африкийн БНУ баримталдаг.
- Сонгуульт байгууллагын шүүхэд заалдах боломжийг хязгаарлах нь доорхи гурван үндэслэлтэй.
 - Нэгдүгээрт, засгийн газрыг шүүмжлэх нь ардчилалын амжилтад зайлшгүй чухал ба нэр төр гутаасан үйлдлийг шүүх нь олон нийтийн амин чухал ашиг сонирхолын талаар чөлөөлт хэлэлцүүлэгт саад учруулдаг. Жирийн иргэн хэн ч бай төрийн албан хаагчийг чөлөөтэй шүүмжлэх ёстой.
 - Хоёрдугаарт, Нэр төр гутаахтай холбоотой хуулиудыг нэр хүнд хамгаалахад зориулан боловсруулдаг. Тэдэнд байж болох аливаа нэр хүндийн асуудал нь өөрөө чөлөөт шүүмжлэлийн ашиг тусыг хүртдэг олон нийтэд бүхэлдээ хамаатай учраас сонгуульт байгууллагууд нэр төр гутаасан хэргээр шүүхэд заалдах ёсгүй гэдгийг шүүх байгууллага хянадаг. Ашгийн бус хийсвэр аж ахуйн нэгж болохын хувьд төрийн байгууллагад тэдний сайн нэрийг сэвтээсэн хохиролоос урьдчилан сэргийлэх санхүүгийн болон санаа сэтгэлийн ямар нэгэн ашиг сонирхол байхгүй билээ. Аливаа тохиолдолд, сонгуульт байгууллагын гишүүд байнга солигдож байдаг, тэгээд ч Дэрбиширегийн шүүхээс дурдсанчлан “орон

нутгийн засаг захиргаа гэсэн ийм төрлийн байгууллагад өөрийн гэсэн нэр хүнд байдаг гэж хэлэхэд хүндрэлтэй юм.”

- Эцэст нь, засгийн газар хатуу шүүмжлэлээс өөрийгөө бусад аргаар хамгаалах хангалттай чадавхтай ба жишээлбэл, ямар ч төрлийн мэдэгдэлд шууд хариу өгч чадна. Төрийн байгууллагыг шүүхэд хандахыг зөвшөөрвөл нэг талаас төрийн байгууллага шүүмжлэлийг үл тэвчих байдлаар ханддаг буруу хэвшил тогтоох, татвар төлөгчдийн мөнгийг зохисгүй хэлбэрээр зарцуулах болно.
- Энэ нь төрийн бүх шатны байгууллага, түүн дотроо орон нутгийн эсвэл бүсийн ба үндэсний хэмжээний байхаас үл шалтгаалан хууль тогтоох, хэрэгжүүлэх ба шүүхийн салбарууд зэрэгт хамаарна. Зарим оронд энэ заалтыг улам өргөжүүлэн Төрийн өмчит корпорациуд ба улс төрийн намуудад хориг тавьсан байдаг.
 - *Жишээ нь:* Өмнөд Африкийн төмөр замын Дай Спобонд бичсэнээр, Өмнөд Африкийн шүүх үндэсний төмөр замын корпораци нэр төр гутаасан хэргээр шүүхэд заалдахыг хоригложээ. Шүүх уг корпорацийг нэр төр гутаасан хэргээр заалдаж болохыг мэдэгдээд, гэхдээ нэр хүндэд хохирол учруулсаны төлөө заалдсан хэргийг ямар ч тохиолдолд шүүхээс эргүүлэн татаж болох ба “ тийм эрх байсан бол энэ талаар урьд нь заалдаж байсан хэргийн тайланг үзэж болох юм гэж найдах байлаа” хэмээн дурджээ.
 - *Жишээ нь:* Бараг 50 жилийн дараа, Зимбабве улсын Дээд Шүүхээс Төрийн өмчит Харилцаа Холбооны Корпораци нэр төр гутаасан хэргээр заалдах ёсгүйг тогтоожээ. Дай Спобонд сонинд бичсэн эх сурвалжаас голчлон харахад “ хуулийн этгээд” нэр төр гутаасан хэргээр заргалдаж болохоос бус Төр ба түүний харьяа байгууллагууд болохгүй болох нь тогтоогдсон байна. Үүгээр төрийн байгууллагын бүтэц санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлохдоо уг байгууллага нь олон нийтэд чухал үйлчилгээ үзүүлж байгаа, шүүмжлэл нь эмзэглэх үр нөлөөтэй эсэхээс шалтгаалан “ тухайн улс орны засаглалын нэгж болох эдгээр хуулийн этгээдийн ” заалдах эрхийг үгүйсгэжээ.

➤ Үүнийг мөн олон улсын шүүхүүд дэмжсэн байна.

- *Жишээ :* 2007 онд Орос оронд гарсан Дуйлдин ба Кисловын хэрэг. Европын Хүний эрхийн Шүүх дээр дараах өгүүлбэр бүхий мэдэгдэл дээр үндэслэн шийтгэл ноогдуулсан дээрх хэргийг авч хэлэлцсэн юм. Үүнд: “ Бүс нутгийн эрх баригчид хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн эсрэг хүч хэрэглэж эхлэв” Энэхүү өгүүлбэр нь нэр төр гутаасан санаа агуулаагүй учраас энд дурдагдсан бусад олон зүйлс дотроос Шүүх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдсан явдлыг онцолсон юм. Үүнд:

[Шүүх] гүтгэлэг, доромжлолын хуулийн үндсэн шаардлага нь хэн нэгэн хувь хүнд хандан нэр төрийг нь гутаасан мэдэгдэлийн эсрэг арга хэмжээ авах учиртайг дахин тодотгосон. Хэрвээ Төрийн бүх албан хаагчдад Төрийн харьяа байгууллагын удирдлагатай холбоотой аливаа шүүмжлэл тэр ч байтугай тодорхой нэр хаяг эсвэл бусдад танигдах хэлбэрээр онцлон дурдсан нөхцөлд ч нэр төр гутаасан хэргээр заалдахыг зөвшөөрвөл сэтгүүлчид шүүхийн зарлан дуудах хуудсанд дарагдах болно. Энэ нь зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тэнцвэргүй хүнд ачаа үүрүүлэх нөхцөл үүсгээд зогсохгүй тэднийг эх сурвалжид хэт их ачаалал өгч, эцэс төгсгөлгүй зарга заалхайд сэтгүүлчдийг татан оруулж, олон нийтийг мэдээллээр хангах нийгмийн хоточ нохой байх үйл ажиллагаа явуулдаг чөлөөт хэвлэлд зайлшгүй сөрөг үр нөлөө үзүүлэх болно.

- *Жишээ:* 2009 онд Унгарт гарсан Цсаникийн хэрэг. Орон нутгийн шүүх “Үнэн худал эсэхийг үл хайхран С.К –ийн хувь хүний эрхийг зөрчих нөхцлийг сүржин, бүдүүлэг ийм хэлбэрээр бүрдүүлсэн” гэсэн мэдэгдэл хийснийг үндэслэн зарга мэдүүлэгчийг шийтгэсэн байна.

Европын хүний эрхийн шүүх энэ хандлагаас татгалзан мэдэгдэхдээ:

Орон нутгийн эрх баригчид зарга мэдүүлэгчид өөрийн хийсэн мэдэгдэлийг нотлох боломж олгох ёстой байсан гэж Шүүх үзэж байна. Энэ нь нотолгоо бүхий мэдэгдэлийг зөвхөн ямар хэлбэрээр хийсэн дээр үндэслэн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлахыг зөвшөөрдөг 10 зүйлийн амин сүнс болсон заалтын эсрэг үйлдэл болжээ. Зарчмын хувьд энэ нь тухайн хэрэгт холбоотой хүмүүст сөрөг үр дагавар учруулах эсвэл олон нийтийг үл хүндэтгэсэн өнгө аясаар үнэн бодитой мэдэгдэл хийсэн үед үйлчлэх ёстой.

- Төрийн “нэр хүнд”-ийг хамгаалах, тухайлбал, төртэй холбоотой бодит зүйлүүд шашны бэлэг тэмдэг, туг далбаа, төрийн сүлдийг нэр төр гутаахтай холбоотой хуулиар хамгаалах нь мөн маргаан дагуулсан асуудал юм. Эдгээр хийсвэр зүйлд хамгаалж болох ямарваа нэгэн санхүүгийн болон сэтгэл санааны ашиг сонирхол байхгүй, мөн үнэнийг гуйвуулсан худал мэдээллээр гутааж болох аливаа нэгэн төрлийн “нэр хүнд” байгаа эсэх нь өөрөө эргэлзээтэй асуудал билээ. Цөөхөн тохиолдолд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн зорилго нь дээрх хийсвэр ашиг сонирхлыг олны санаанд нийцэхгүй улс төржсөн үг ярианаас сэргийлэхэд чиглэдэг.
- 2000 онд баталсан Хамтарсан тунхаглалын олон улсын тусгай илтгэлд энэ салбарын олон улсад мөрдөгдөх хэм хэмжээг тодорхойлон тусгасан. Үүнд:

Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд хамгийн багаар бодоход, дараах хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

- Төр, төртэй холбоотой объектууд, тухайлбал, туг далбаа, сүлд, төрийн байгууллагууд ба албан тушаалтнуудыг бүхий л төрлийн гутаан доромжилсон үйлдлээс сэргийлсэн агуулгатай байна.

Хэлэлцүүлэг: Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар төрийн байгууллагууд болон бэлэг тэмдгийг хамгаалах ёсгүй гэдэгтэй та санал нийлж байна уу? Хэрвээ үүнийг тооцохгүй бол төрийн байгууллагууд өөрсдийгөө хэрхэн худал хуурмаг, хорон үр дагавартай мэдээллээс хамгаалах вэ? Үндэсний омогшил бэлэг тэмдгийг хэрхэх вэ?

3. Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиуд

Оршил

- Хэдийгээр ихэнх оронд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч олон улсын хэм хэмжээгээр үүнийг хууль ёсны гэж тооцдоггүй. Мөн түүнчлэн нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхээс татгалзах хандлага давамгайлах болов. Тухайлбал, Босни-Герцоговина, Гүрж, Гана, Шриланк, Украин, Их Британи болон АНУ нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиасаа аль хэдийн хассан ба бусад олон орнууд хасах талаар судлаж байна. Зарим нэгэн улс орон, түүнчлэн Болгар, Франц улсууд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн үр нөлөөг багасгаж, тухайлбал хорих ял ногдуулдаг шийтгэлээс татгалзах болов.

- Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуультай уялдуулан маш олон асуудлууд үүсдэг. Тодорхой үйл ажиллагааг эрүүгийн хуулиар шийдвэрлэхийн ард нийгмийн санаа бодол, үйл хэргийг хянаж байх гэсэн Төрийн ашиг сонирхол оршдог ба нийгэм дэх тодорхой нэг үзэгдлээр энэ нь илэрнэ.
- Нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхэд хамгийн санаа зовоох асуудал нь тэрээр хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлдэгт оршино. Нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэх нь хүнд шийтгэл ногдуулах тухайлбал, шоронд хорих, төлж дийлэхээргүй торгууль хүлээх, сэтгүүлч нарын хувьд мэргэжлийн ажлаа гүйцэтгэх эрхийг боомилох зэрэгт хүргэдэг. Шийтгэлийг тооцохгүй байлаа гэхэд нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхэд хувь хүн цагдаагийн газарт баривчлагдах, улмаар урьдчилан хорих газарт хоригдох, эрүүгийн хэргийн шүүхэд дуудагдах гэхчлэн удаан хугацаанд үргэлжлэх сөрөг үр дагавартай. Хэдийгээр шүүх багахан хэмжээний торгууль ногдуулсан ч тухайн хүн эрүүгийн хэрэгт холбогдсон нэр зүүж олны өмнө нүүрээ улалзуулах болдог. Шоронд хорих ялыг түтгэлзүүлэхэд мөн дээрхи асуудал тулгардаг ба тухайн хүн хэдий чөлөөтэй үлдсэн ч дахин шоронд хоригдохоос эмээх айдас үүсэн ахиж хэзээ ч дуугарахгүй амаа хамхихад хүргэнэ.
- Баримтаас харахад, олон улс оронд нийгэмд нөлөөтэй эрх мэдэл бүхий хүмүүс буюу ихэнх тохиолдолд зарга зайлхай хийдэг хүмүүс тухайлбал, албан тушаалтнууд нэр бүхий бизнесменүүд нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдүүлдэг нь байдлыг улам хурцатгадаг сөрөг талтай. Үнэн бодит байдлыг нуун дарагдуулах, шүүмжлэлээс өөрсдийгөө хамгаалахын тулд эдгээр хүмүүс хуулийн заалтыг буруугаар хэрэглэхийг оролддог.
- Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг эсэргүүцэх гол түлхүүр нь хувь хүний нэр хүндийг хамгаалах зорилготой иргэний хуулийг үр дүнтэй хэрэглэх явдал юм. Энэ нь нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг хүчингүй болгосон ба цаашид хэрэглэхээ больсон орнуудын туршлагаас үүдэлтэй. Нэр төр гутаахтай холбоотой хууль нь мөн чанараараа төрийн “төмөр нудрага” болохоос үл хамааран, дээр дурдсанчлан хамгийн төвөг чирэгдэл багатай, үр нөлөө бүхий хязгаарлалт заавал байх ёстой гэсэн үндэслэлээр энэ нь ноцтой эргэлзээ дагуулдаг.
- Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг бас өөр өнцгөөс шүүмжлэх нь бий. Нэр төр гутаах асуудал нь маргаангүй хүний хувийн харилцаанаас үүсдэг байхад төр үүнд оролцох хэрэггүй хэмээн шүүмжилдэг. Түүнээс гадна, эрүүгийн хуулийн хариуцлагын дагуу нэр төр нь гутаагдсан хүн ямар нэгэн нөхөн төлбөр авдаггүй харин ихэнхдээ тогтсон хуулийн системийн хүрээнд торгууль Төрийн халаасанд шууд ордог.

Хэлэлцүүлгийн асуултууд: Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн талаарх эдгээр шүүмжлэлийг та юу гэж үзэж байна? Нэр төр гутаасан үйлдлийг эрүүгийн бус иргэний хуулиар шийдвэрлэхэд эдгээр нь хангалттай дэмжлэг болж чадах уу? Эсвэл таны бодлоор, энэ үйлдлийг эрүүгийн хуулиар шийдвэрлэх хэрэгцээ байсаар байна уу? Яагаад шийдвэрлэх ёстой эсвэл яагаад үгүй гэж?

Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиуд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт болох нь

- Сонгосон хууль ёсны зорилгоо биелүүлэхийн тулд хамгийн төвөг чирэгдэл багатай мөртөө үр нөлөөтэй арга хэрэглэн Төр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах шаардлагатай гэдэг нь нэгэнт нотлогдсон юм. Хэтэрхий хязгаарласан нэг нь хэрэггүй, арай чирэгдэл багатай нэг нь үр нөлөөтэй, гэхдээ аливаа нэгэн хязгаарлалт зайлшгүй хэрэгтэй гэсэн хэрэгцээ шаардлагуудаас энэ

нь өөрөө урган гарсан юм. Испанийн Кастелд Европын Хүний эрхийн Шүүхээс гаргасан тогтоолоор нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн заалтыг хасахдаа, нэр төр гутаасан үйлдлийг эрүүгийн хуулиар шийдэхээс зайлсхийх ёстойг дурдаад “ Ялангуяа эсрэг этгээд ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр дайрсан зөвтгөх аргагүй халдлага, шүүмжлэлд өөр бусад аргаар хариу өгөх боломжтой үед” гэж тайлбарлажээ. (тодруулга хийв)

- Хүний эрхийн Америк дундын Шүүх энэхүү асуудлыг илүү тодорхой гарган тавьсан юм. Үүнд:

[Хэрвээ хэрэглэж болох төрөл бүрийн сонголт байгаа бол [засгийн газрын ашиг сонирхлыг албадан] хязгаарлалт тавихыг хүссэн хамгаалах эрхийг сонгох ёстой.

- Үр дүнд нь, энэ асуудлын хүрээнд, нэр хүндэд хор хохирол учруулсан хэргийг нэр төр гутаасан тухай иргэний хуулиар шийдвэрлэх нь үр нөлөөтэй байгаа бол үүнийг нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар авч үзэх үндэслэл байхгүй юм. Хэдийгээр нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч, энэ зорилгыг нэр төр гутаасан тухай иргэний хуулиар шийдвэрлэх нь хангалттай болохыг баталсан шилдэг нотолгоо нь мэдээж асуудлыг дахин авч үзэх эсвэл өсөн нэмэгдэж буй давуу талыг бодолцох мөн улс орнуудын өдрөөс өдөрт нэмэгдэж буй шинэчилсэн хууль тогтоомжоос үүдэлтэй юм.
- Хувь хүний нэр хүндэд зохих ёсны хамгаалалт бүрдүүлэхэд ийм төрлийн хууль шаардлагагүй болох нь нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг шүүхийн тогтоолоор хассан олон улс орнуудын туршлага, шийдвэр гаргагчдын зүгээс хүчингүй болгосон эсвэл балмад хэлбэрээр урвуулан ашигласан зэрэг харуулж байна гэсэн дүгнэлт хийж болох юм. Эдгээр улс орнуудад энэхүү асуудлыг нэр төр гутаасан тухай иргэний хуулиар шийдвэрлэх нь хангалттай болох нь нотлогдсон юм. Нэмж хэлэхэд, энэ туршлага зөвхөн ардчилал хөгжсөн орнуудаар хязгаарлагдахгүй, ардчилалд шилжиж буй улс орнууд болон дэлхийн өнцөг булан бүрээс гаралтай юм.
- Учирсан хохирлын хувьд нөхөн төлбөр өгөх замаар алдар нэр нь сэвтсэн хохирогч этгээдийн хохирлыг арилгах арга замтай боловсруулсан байдаг учраас иргэний хууль эрх зүй нэр төр гутаасан үйлдлийн хор уршгийг арилгахад аливаа нэгэн хэрэг дээр, эрүүгийн хуулиас илүү давуу талтай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Эсрэгээрээ, эрүүгийн хуулийн шийтгэлийн ихэнх хохирогчид учирсан хор хөнөөлийг арилгахыг зорьдоггүй ба харин гэм буруутныг шийтгэхийг илүүтэй авч үздэг.
- Ихэнх улс орнуудад эрүүгийн хэрэгт татагдсан гэмт буруутанд нотолгоо баримт бүрдүүлэх үүрэг ногдуулж буруутныг өөрсдийн хийсэн мэдэгдэлийн үнэн зөв болохыг, мөн түүнээс хэлсэн ярьсан зүйлийнхээ “ул үндэстэй“ болохыг, эсвэл олон нийтийн эрх ашгийн төлөө хэвлэн нийтлэсэн болохоо нотлохыг шаарддаг нь нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хууль нь төвөг чирэгдэлгүй хязгаарлалт бүхий арга барил болж чадахгүйн бас нэг баримт юм.
- Хэдийгээр эрхээ хэтрүүлэн ашигласан хэрэгт ял шийтгэл ногдуулсныг нөхцөл байдалтай холбон зөвтгөж болох ч хэт хатуу шийтгэл нь өөрөө хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчдөг нь одоо нэгэнгт батлагдсан билээ. Үүнээс өмнө, нэр төр гутаасан үйлдлийг үүсэн анхны хэрэг дээр Шүүхээс тогтоохдоо:

Зохиогчид ногдуулсан шийтгэл... ирээдүйд ахиад энэ талаар шүүмж хэлэхгүй болтол нь зүрх зоригийг нь мохоох гэсэн мэт олон төрлийн хориг тавьж... Улс төрийн хэлэлцүүлгийн үед ийм төрлийн өгүүлбэр нь сэтгүүлчийг иргэдийн амьдралтай холбоотой асуудлын талаар олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ

оруулах хүслийг нь хязгаарлан боож болох юм. Үүнтэй адил шалтгаанаар ийм төрлийн ял шийтгэл нь чөлөөт хэвлэл олон нийтийг мэдээллээр хангах, олон нийтийн хоточ нохой байх үүргээ биелүүлэхэд саад болох хариуцлага үүрүүлж байгаа мэт...

- Нэр төр гутаасан үйлдлийн төлөө ногдуулсан эрүүгийн ял шийтгэл энэ дүрэмтэй зөрчилдөх бөгөөд ийм ч учраас учруулсан хор хохиролыг нь авч үзвэл, шийтгэл нь хэтэрхий хатуу юм. Эрүүгийн хэрэг үүсгэх заналхийлэл, эрүүгийн хуулийн ял шийтгэл эсвэл тэнсэн харгалзах шийтгэл бүгд ул суурьтай шүүмжлэлд хэрэгцээгүй хэрнээ маш их дарамт болдог. Энд мөн эрүүгийн ял шийтгэл авсны төлөө төлдөг торгууль багтана.
 - *Жишээ:* Коста Рикагийн шүүхээс нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар шийтгүүлсэн Ноён Херрера Уллоагийн хэргийг Хүний эрхийн Америк дундын Шүүхээр хянан хэлэлцээд түүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчин, нэр төр гутаасан үйлдлийн төлөө түүнд дахин давтан үйлдсэн хэрэгт нь тэнсэн харгалзах ял оноох, төрд албан тушаал хаших эсвэл мэргэжлээрээ ажиллахыг хориглож мөн хүүхэд үрчлэн авах эрхийг нь хасах зэрэг байж боломгүй эрүүгийн шийтгэл оногдуулсныг тогтоожээ.
- Доорхи хэрэг дээр, Европын Хүний эрхийн Шүүх нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн буруутгасан заалтыг хэвээр үлдээхдээ тэнцвэрт байдлын шалгуурыг хангасан, бага хэмжээний шийтгэл байх ёстойг онцлон дурдсан юм. Жишээлбэл, Эстоны Таммерт болсон хэрэг дээр Шүүх буруутгасан заалтыг баримтлан “оногдуулсан торгууль бага хэмжээтэй байхыг” онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ хэрэгт оноосон торгуулийн нийт хэмжээ өдрийн цалингийн хамгийн бага хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэж байв.

Хэлэлцүүлэг: Монголд нэр төр гутаасан үйлдлийн төлөө оноодог шийтгэл хэтэрхий хатуу гэж та үзэж байна уу? Таны бодлоор ямар төрлийн ял шийтгэл оноох ёстой вэ?

Олон улсын хэм хэмжээ

- НҮБ-ын төрөл бүрийн байгууллагууд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хууль айдас хүйдэс дагуулдаг болохыг хүлээн зөвшөөрдөг ба хуулиас татгалзахыг зөвлөдөг билээ.
 - НҮБ-ын Хүний Эрхийн Хороо нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн талаар санаа зовниж буйгаа дахин давтан илэрхийлж, Улс орнуудад хандан “ нэр төр гутаасан үйлдлийг хорих ялаар шийтгэхээс татгалзахыг “ уриалсан юм. (Италийн тухай ажиглалтын дүгнэлт, 2006 он, 4-р сарын 24, 19 бүлэг). Гүтгэлэг, доромжлолыг эрүүгийн хуулиас хасах уриалгыг тус улс нааштайгаар хүлээн авсан билээ.
 - НҮБ-ын Хүний Эрхийн Комиссоос 2011 онд гаргасан Ерөнхий тайлбарын 19 дүгээр зүйлд дурдахдаа:

Засгийн газрын дэмжлэгтэй нийгэм улс төрийн систем, шийдвэр гаргагчдын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгчид, сэтгүүлчдэд оноосон шийтгэлийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавих зайлшгүй хязгаарлалт гэж тооцож хэзээ ч болохгүй.....

Улс орнууд нэр төр гутаахтай холбоотой хэрэгтэй тэмцэхдээ зөвхөн онц ноцтой тохиолдлыг эрүүгийн хуулиар авч үзэж болох ч ямар ч тохиолдолд хорих ял ногдуулах нь зохисгүй юм.

- НҮБ-ын Тусгай Илтгэгч Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар 1999 онд гаргасан жилийн тайланд дурдахдаа:

Нэр төр гутаасан үйлдэлд оноох шийтгэл нь хувь хүний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрх ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг үр дагавар үзүүлэх их хэмжээний эсвэл хатуу байх ёсгүй бөгөөд эрүүгийн хуулийн ял шийтгэл, нэн ялангуяа хорих ялыг хэзээ ч хэрэглэх ёсгүй.

- Тусгай Илтгэгч дараагийн хоёр жилийн тайландаа илүү тодорхой тусгаж улмаар Улс орнуудыг гүтгэлэг доромжлолын тухай эрүүгийн хуулийн заалтаа хүчингүй болгож, асуудлыг иргэний рэх зүйн хүрээнд шийдэхийг уриалсан билээ.
- НҮБ-ын Тусгай Илтгэгч энэхүү асуудлыг мөн өөрийн хамтрагч нар болох Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ) ба Америкийн Муж улсуудын байгууллага (АМБ) хамтран дэвшүүлсэн юм. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөө тусгай үүрэг гүйцэтгэгч гурван байгууллага 1999 оны 11 дүгээр сар, 2000 оны 11 дүгээр сар ба 2002 оны 12 дугаар сард гаргасан Хамтарсан Тунхаглалдаа улс орнуудыг нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиа хүчингүй болгохыг уриалсан билээ. 2002 оны тунхаглалд дурдахдаа:

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой нэр төр гутаасан явдалд эрүүгийн хэрэг үүсгэн хуулийн хязгаарлалт тавих ёсгүй ба нэр төр гутаасан талаархи эрүүгийн бүх хуулийг халж өөрчлөн шаардлагатай тохиолдолд иргэний хуулиар асуудлыг шийдвэрлэх нь зохимжтой.

- ЮНЕСКО-гийн санхүүжилтээр 1996 онд зохиогдсон Саха-гийн Тунхаглалд дурдахдаа: “ Мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэж байгаа хэвлэл мэдээллийн ажилтнууд... хэвлэл мэдээллийн хэрэгсэл оролцсон маргааныг эрүүгийн хууль ба дүрмээр бус иргэний эрх зүйн хүрээнд шийдвэрлэхийг оролдох хэрэгтэй...” гэжээ.
- Европын Хүний Эрхийн Шүүх нэр төр гутаахтай холбоотой олон тохиолдол дээр “ Засгийн газар давуу байр суурь эзэлж байгаагийн хувьд зайлшгүй эрүүгийн хэрэг үүсгэн асуудлыг шийдэхэд “ хүргэж байна хэмээн сануулсан юм. Энэ нь нэр төр гутаасан үйлдлийг эрүүгийн хуулиар огт шийдэж болохгүй гэсэн үг биш харин “Нийгмийн хэв журмыг батлан сахиулагчийн хувьд Төр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ” зөвхөн ийм төрлийн арга хэмжээг батлан хэрэгжүүлэх ба “Нэр төр гутаасан аливаа үйлдэлд төрийн зүгээс хэтрүүлэггүй, үндэслэлтэй, эсвэл далд явцуу санаархалгүй, зохистой хэлбэрээр хандан шийдвэрлэх” ёстойг дахин давтан онцолдог.
- Олон нийтийн ашиг сонирхолын асуудлаар хийсэн мэдэгдэлийг нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар шийдсэн хоёр томоохон хэрэг дээр Хүний Эрхийн Америк дундын Шүүх хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчсөнийг нотлоод, энэ төрлийн хэрэгт ихэнхдээ хэрэглэх ёсгүйг сануулсан байна.
- Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга гишүүн бүх Улсуудад хандан нэр төр гутаасан аливаа үйлдлийг шийтгэдэг “эрүүгийн хуулийн заалтыг үгүй болгохыг” уриалсан юм. (2006 оны 5 дугаар сарын 3, Дэлхийн Хэвлэлийн Эрх чөлөөний өдөр).

Эрүүгийн хуулиас хасах хүртэлх түр арга хэмжээ

- Нэр төр гутаахтай холбоотой заалтыг эрүүгийн хуулиас бүрэн хасах хандлага улам бүр давамгайлж байгаа ч олон оронд энэ үйл явцыг хүчтэй эсэргүүцсээр байгаа юм. Энэ төрлийн хуулийг бүрэн устгах боломж бүрдээгүй эсвэл улс төрийн хувьд боломжгүй байгаа үед гүтгэлэг, доромжлолыг эрүүгийн хуулиар шийдвэрлэхэд үүсдэг сөрөг үр дагаварыг бууруулж чадах олон тооны түр арга хэмжээг авч болно. Үүнд дараах хүчин зүйлийг багтааж болох ба:
 - Аливаа ажил эрхлэх ба сэтгүүлчийн үүргээ гүйцэтгэх эрхийг нь түтгэлзүүлэх, их хэмжээний торгууль, түр хугацаагаар хорих, шоронд хорих зэрэг хүнд хатуу шийтгэлийг устгах
 - Төрийн албан хаагчид, төрийн байгууллагууд, туг далбаа гэх мэт Төрийн бэлэг тэмдэгийг илэрхийлдэг аливаа зүйлд нэр төр гутаасан үйлдлээр шийтгэл оноохгүй байх
 - Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хэрэг үүсгэх, эсвэл шүүхээр хянан шийдвэрлэхдээ, ялангуяа хувь хүний нэр төрийг гутаасан хэргийг авч үзэхдээ боломжтой бол цагдаа ба прокурор зэрэг албан тушаалтнуудыг оролцуулахгүй байх,
 - Гомдол мэдүүлэгч этгээд буруутайг нь нотолсоноос бусад нөхцөлд хэн ч гүтгэлэг доромжлолын хэргээр шийтгүүлэхгүй байна. Эргэлзээ төрүүлсэн үндэслэлтэй доорхи нөхцлүүд хамаарахгүй. Үүнд:
 1. Мэдэгдэлийн асуудал нь хуурамч байх;
 2. Мэдэгдэл хийж буй хүн хуурамч гэдгийг нь мэдсэн эсвэл мэдсэн хэрнээ үл тоомсорлосон өнгөөр хандах; ба
 3. Гомдол мэдүүлэгч хүний нэр төрд сөв суулгах мэдэгдэл санаатайгаар хийх.
 - Гэм буруугийн талаарх ойлголттой холбогдуулан, нэр төр гутаасан үйлдлийг бусад гэмт хэргийн адилаар шийдвэрлэх шаардлагатай гэсэн ойлголтын хүрээнд авч үзвэл зөвхөн эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нь шударга юм.

Дасгал ажил 2: Монгол Улсын эрүүгийн хуулинд байдаг нэр төр гутаахтай холбоотой заалтууд

Модуль 3: Нэр төр гутаах: Өмгөөлөл

- Нэр төр гутаахтай холбоотой нэхэмжлэлийн эсрэг өмгөөлөх систем нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бө нэр төрөө хамгаалах эрхийн тэнцвэрийг олох түлхүүр ойлголтын нэг юм. Нэр төр гутаахтай холбоотой нэхэмжлэлийн эсрэг янз бүрийн өмгөөлөл байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг.
- Өмгөөлөл бол хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн мэтгэлцээн бөгөөд, хэрвээ амжилттай бол шүүгдэгч тал хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэсэн үг ба өмгөөлөгчгүй яллах нь өөрөө буруутай үйлдэл юм. Жишээлбэл, ихэнх орны хуулийн систем “ санал нийлсэн” буюу зарга мэдүүлэгч тал зөвшөөрсөн тохиолдолд шүүгдэгч тал хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэггүй өмгөөллийн аргыг хүлээн зөвшөөрдөг. Жишээ нь, хэрвээ тухайн этгээд өөрөө мэдээллээ нийтлэхийг зөвшөөрсөн бол тэр хүний хувийн мэдээллийг олонд дэлгэн нийтлэсэн нь хувийн нууцын эрхийг зөрчөөгүйд тооцогдоно.
- 2011 онд баталсан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Ерөнхий тайлбарт эдгээр өмгөөлөх аргын заримаас дурдахдаа:

Нэр төр гутаахтай холбоотой хуулиудыг хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зорилгоор практикт хэрэглэхгүй гэсэн 3 дугаар заалттай уялдсан эсэхийг нягтлан боловсруулах ёстой. Энэ төрлийн хуулиуд, ялангуяа нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд үнэнийг хамгаалах гэсэн өмгөөлөх хэсгийг оруулах хэрэгтэй ба мэдээллийн уг сурвалж, сэдвийг нягтлах, илэрхийлсэн хэлбэрийг дурдан хэрэглэх ёсгүй. Төрийн албан тушаалтнуудын тухай мэдээлэлтэй холбоотой тохиолдолд дор хаяж, торгууль ноогдуулахаас зайлсхийх, эсвэл өөр аргаар өш хонзон саналгүй хууль бус, худал хуурмаг мэдээлэл алдаатай хэвлэгдсэнийг залруулж болох юм. Ямар ч тохиолдолд олон нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүмжлэл нь өмгөөлөх арга гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. [ишлэл орхигдуулсан, тайлбар нэмсэн]

- 2000 оны Хамтарсан Тунхаглалын олон улсын тусгай илтгэлд өмгөөлөлийн талаар илүү нарийвчилсан, тодорхой мэдээлэл тусгагдсан байна. Үүнд :

Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд хамгийн багаар бодоход, дараах хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

- Төрийн байгууллагатай холбоотой асуудлыг нээлттэй хэлэлцүүлэх нь чухал болохыг нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд тусгаж, мөн албан тушаалтнууд жирийн иргэдийг бодвол шүүмжлэлд илүү өртдөг зарчимтайг дурдаж, ялангуяа албан тушаалтнуудад тусгай хамгаалалт эдлүүлдэг хуулиуд тухайлбал, үл тоомсорлосон, хүндэтгээгүй тухай хуулийг хүчингүй болгох хэрэгтэй.
 - Төрийн байгууллагын тухай мэдээлсэн баримтын худал хуурмаг болохыг нотлоход гарах зардлыг зарга мэдүүлэгч тал гаргана.
 - Санал бодлоо илэрхийлсэн хэн ч болов нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх ёсгүй.
 - Төрийн байгууллагын талаархи мэдээлэлтэй холбоотойгоор уг мэдээлэл бүх талаараа үндэслэлтэй болохыг үзүүлэх нь өмгөөлөл болно.
- Бусдын сайн туршлага ба олон улсын хэм хэмжээгээр өмгөөллийн дараах хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөхийг уриалдаг. Үүнд: Үнэнийг өмгөөлөх, санал бодлыг өмгөөлөх, үндэслэлтэй нийтлэлийг өмгөөлөх, ба өмгөөллийн бусад хэлбэр болох (бусдын хэлсэн үг ба давуу эрхтэй нөхцөлүүд) орно.

Хэлэлцүүлэг: Монголд үүнтэй төстэй өмгөөллийн хэлбэрүүд байдаг уу? Өмгөөллийн өөр төрлийн хэлбэр байдаг уу? Нэр төр гутаахтай холбоотой ийм төрлийн өмгөөллийн хэлбэр Монголын нөхцөлд нийцнэ гэж та бодож байна уу? Хэрвээ үгүй бол, та бүхэн өмгөөллийн бусад ямар хэлбэрийг байвал зохистой гэж бодож байна ?

1. Үнэнийг өмгөөлөх нь

- Үнэнийг хамгаалах нь нэр төр гутаахтай холбоотой хууль ба үзэл бодлын эрх чөлөөний тэнцвэрийн төв гэж хэлж болно. Олонх оронд бодит баримтыг гуйвуулаагүй тохиолдолд нэр төр гутаасан асуудлаар хувь хүн хариуцлага хүлээдэггүй. Өөрөөр хэлбэл, үнэн гэдэг нь нэр төр гутаасан мэдэгдлээс бүрэн хамгаална гэсэн үг.
- Үнэнийг өмгөөлөх үндэслэлд нэр төр гутаахтай холбоотой хууль нь хүмүүс сайн нэрээ хадгалж чадсан эсэхээс илүү хувь хүн, тэдний нэр хүндийг үндэслэлгүй худал дайралтаас хамгаалахад үйлчлэх ёстой гэдэг нь багтдаг. Асуудлыг өөрөөр тавибал, чи өөрөө сайн нэрээ хадгалж чадаагүй бол түүнийгээ хамгаалж чадахгүй гэсэн үг. Хувь хүн буруутай хэрнээ өөрийнх нь тухай илэн далангүй бичиж нийтлүүлсэнийг эсэргүүцдэг гэсэн хэдий ч нэрэнд нь толбо суулгасан нийтлэлийн эсрэг заргалдаж чадахгүй. Энэ нөхцөлд харин хувь хүн өөрийнхөө хувийн амьдралын нууцыг дэлгэсэн нийтлэлийн эсрэг хувийн нууцад халдсан гэдгээр зарга мэдүүлэх эрх нь нээлттэй байдаг.
- Олон улсын байгууллагуудаас гаргасан олон тооны нэр хүндтэй мэдэгдлүүд үүнийг дэмждэг. Жишээлбэл, Хүний ба иргэдийн эрхийн тухай Африкийн Комиссын Зарчим XII-ийн дагуу баталсан Африк дахь Үзэл бодлын эрх чөлөөний талаарх зарчмуудын Тунхаглалд тусгахдаа:

Улс орнууд нэр төр гутаахтай холбоотой хууль батлахдаа дараах хэм хэмжээг баталгаажуулсан байх ёстой ба үүнд:

Нөхцөл байдлаас урган гарсан үндэслэлтэй, үнэн бодит мэдээлэл ба санал бодол эсвэл төрийн албан тушаалтантай холбоотой бодитой мэдэгдэлийн төлөө хэн ч хариуцлага хүлээх ёсгүй;

- Үүнтэй нэгэн адил, *Нэр төр гутаах үйлдлийг тодорхойлох нь: Үзэл бодлын эрх чөлөө ба Нэр хүндийг хамгаалах тухай (Нэр төр гутаах үйлдлийг тодорхойлох нь), Зарчим 7(a)*, мөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай олон улсын ТББ-ын энэ салбарт зориулан баталсан хэм хэмжээний 19 дүгээр зүйлд дурдахдаа:

Баримтын талаарх маргаантай мэдэгдэл үнэн бодитой нь тогтоогдсон бүх тохиолдолд шүүгдэгч тал аливаа нэгэн хариуцлага хүлээхгүй.

- Зарим улс орнуудад, үнэнийг батлах нь хараахан хангалтгүй ба шүүгдэгч тал сайхан сэтгэллийн үүднээс эсвэл олон нийтийн эрх ашгийн төлөө мэдэгдэл хийснээ батлах хэрэгтэй болдог. Гэвч, олон улсын хэм хэмжээгээр үүнийг шүүгдэгч талд хэтэрхий их үүрэг ногдуулж байна гэж үздэг. Сайхан сэтгэлийн үүднээс үг хэлсэнээ нотлохгүй бол та хэзээ ч үг дуугарч чадахгүй байх үр дагаврыг та бүхэн төсөөлөөд үз дээ.
 - *Жишээ:* Англид болсон Глеавес ба Деакиний хэрэг, Шүүгдэгч талаас зөвхөн үнэнийг батлаад зогсохгүй, тэдний хийсэн мэдэгдэл

олон нийтийн эрх ашгийн төлөө байсан гэдгийг нотлохыг шаардсан энэхүү гүтгэсэн тухай эрүүгийн хэрэг нь Хүний эрхийн тухай Европын конвенцийн 10 дугаар зүйлийг зөрчсөн тухай Лорд Диплок саналаа хэлжээ. Тэрээр, энэ нь үнэн хэрэгтээ 10 дугаар зүйлийг “хөл толгойг нь алдагдуулсан” гэж үзээд хэлэхдээ:

Хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх нь манай эрүүгийн хуулиар бол олон нийтийн эрх ашгийн төлөө үг хэлэх эрхээ эдэлсэн гэдгээ тангартны шүүхэд баримтаар нотолж чадаагүй л бол бусад хүнийг эвгүй байдалд оруулан нэр төрд нь сэв суулгасан нөхцөлд төрийн эрх мэдэлтнүүд хориг тавьж болиулдаг, харин 10 дугаар зүйлд олон нийтийн эрх ашгийг хамгаалан үг хэлсэн нөхцөлд төрийн эрх мэдэлтнүүд хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хорьж цагдах боломжгүй хэмээн заасан байдаг гэсэн байна.

Хэлэлцүүлэг: Үүнийг та бүхэн юу гэж үзэж байна? Үнэний баталгаа нэр төр гутаасан хэргээр заргалдахад хангалттай юу эсвэл шүүгдэгч талаас өөр ямар нэг зүйлийг батлахыг шаардах нь үндэслэлтэй юу? Хэрвээ тийм бол өөр юу асуух вэ?

➤ Энэ нь олон улсын хуулийн дагуу мэдээллийн үнэнийг нотлох асуудал хэний ч өмнө нээлттэй байхаар сайтар зохицуулагдсан гэж хэлж болно.

- *Жишээлбэл:* 1992 онд болсон Испанийн Кэстлийн хэрэг дээр дотоодын шүүх байгууллага нь салан тусгаарлах үзэлтнүүдийн хөдөлгөөнд харьяалагддаг байсан хүмүүсийн амь үрэгдсэн хэргийг Засгийн газар санаатайгаар мөрдөн шалгах аас зайлсхийж байгаа талаархи зарга мэдүүлэгчийн шүүх хурал дээр үнэнийг нотлох оролдлогод зөвшөөрөл өгөхөөс татгалзсан. Европын Хүний эрхийн шүүхээс дурдахдаа:

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүн ямар байсан, зарга мэдүүлэгчийн хайж олсон баримтуудыг Дээд шүүх хэргийн нотлох баримт хэмээн хавсаргахыг зөвшөөрөөгүйг тогтоох боломжгүй ба харин Манай шүүх тухайн хэрэгт ийм төрлийн баримтуудыг хавсаргах боломжгүй хэмээн үгүйсгэсэн асуудалд чухал ач холбогдол өгч байна.

- Нотлох баримттай холбоотой нарийн уялдаатай асуудал урган гарч байгаа бөгөөд худал хуурмаг зүйл энд байгаа эсэх, асуудлыг өөрөөр тавибал, үнэнийг нотлох асуудал дээр хэн нь үнэн ярьж байгааг мэдэх: шүүгдэгч тал үнэнийг нотлох уу эсвэл зарга мэдүүлэгч тал худлаа гэдгийг батлах уу. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа нь энэ эрхийн аливаа нэгэн хязгаарлалтыг зөвтгөхийг оролдох ихээхэн хүнд хариуцлагыг Төрд үүрүүлдэг. Энэхүү хариуцлага хамгийн наад зах нь олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн асуудлаар худал хуурмаг болох нь тогтоогдтол тухайн зүйл үнэн гэдгийг үгүйсгэхэд хүргэдэг гэж хэлж болох юм.
- Мөн үүнтэй уялдсан илүү олон прагматик ба хууль эрхийн хүчин зүйлүүд байсаар байна. Нэр төр гутаасан асуудалд мэдээлэл хуурамч болохыг тодорхойлох нь чухал тул зарга мэдүүлэгч гомдол гаргасны хувьд зайлшгүй батлах ёстой болдог. Улмаар зарга мэдүүлэгч гомдол гаргасан хүний хувиар ихэнхдээ худал хуурмагийг нотлох баримтыг илүү амархан олдог. Эцэст нь хэлэхэд, шүүгдэгчээс гаргасан гомдлын дагуу үнэнийг нотлохыг шаардах нь өөрийн цагдан хяналтыг бий болгодог. Хувь хүн худал хуурмаг болох эсвэл худал гэж итгэж байгаа маргаантай асуудлаар бичихээс татгалзах нь шүүх хурал дээр үнэнийг нотолж чадахгүй байх гэсэн айдас, эсвэл нэр төр гутаахтай холбоотой хэргийн өмгөөллийн хөлс өндөр байдагтай холбоотой байдаг.
- Олон шүүх байгууллагууд үнэнийг нотлох шаардлагын “гашуун” нөлөөг нэр төр гутаахтай холбоотой хэргийг иргэний хуулиар шийдэхдээ дурддаг.

- *Жишээ:* Лордуудын Танхим орон нутгийн эрх баригчид нэр төр гутаасан үйлдлийн төлөө зарга мэдүүлэх, нөхөн төлбөр нэхэх эрхгүйг дурдан тэмдэглэхдээ:

Гүтгэлгийг иргэний хуулиар шийдэх заналхийлэл үг хэлэх эрхэд заавал саад тоггор учруулна. ... Нотлох шаардлагын “гашуун нөлөө” гэж юуг тодорхойлох нь ... маш чухал. Гүтгэсэн нийтлэл гэж үзсэн баримт ихэнх тохиолдолд үнэн байж таардаг ч энэ үнэн баримтыг байж болох аргаар үнэн гэдгийг нь нотлох боломж байдаггүй. Энэ нь эргээд олон нийтийн сонорт зайлшгүй хүрэх ёстой асуудлыг хөндөхөөс зайлсхийхэд хүргэж болох юм.

- *Жишээлбэл:* АНУ-ын Дээд шүүхээс 1964 онд шийдвэрлэсэн Нью-Йорк Таймс Ко.в.Силиваны хэрэг дээр зарга мэдүүлэгч нь цагдаагийн комиссар байсан ба Нью-Йорк Таймс сонины зар мэдээлэлд цагдаа нар хэтэрхий хүч хэрэглэж байна хэмээн бичсэн нь нэр төрд сэв суулгасан гэж үзсэн. Хэдийгээр сонины зар мэдээнд зөрүүтэй баримт тусгагдсан байсан ч шүүгч Бриан зарга мэдүүлэгчийн гаргасан гомдол нь үзэл бодлоо илэрхийлэхийг баталгаажуулсан хуулийн Нэгдүгээр нэмэлтийг зөрчсөн гэж үзээд шүүх хурал дээр үнэнээ нотлохыг шаардсан. Шүүхээс дурдахдаа:

Шүүгдэгч талаас үнэнийг нотлохыг шаардах, үнэнийг өмгөөлөх үнэ цэнэ зэрэг нь зөвхөн худал хуурмаг яриа дэмжигдэнэ гэсэн үг биш. Гаргаж тавьсан гүтгэлэг нь бүх талаараа үнэн хэдий ч хууль ёсны нотолгоо олоход хэцүү энэ өмгөөллийг хангалттай хамгаалалт гэдгийг тэр байтугай Шүүх хүлээн зөвшөөрдөг... Ийм төрлийн хуулийг удирдлага болговоос, шүүх хурал дээр үнэнийг нотолж чадахгүй гэсэн айдас, эсвэл нотлохын тулд гарах зардлаас эмээсэндээ үнэн гэж итгэж болохоор, эсвэл үнэн хэрэгтэй болсон баримтыг албаны хүмүүс ил гаргаж шүүмжлэхийг боогдуулах тал бий.

- Олон улсад мөрдөгдөж буй хэм хэмжээний дагуу төрийн ашиг сонирхлын талаар буюу тухайлбал, төрийн албан хаагчид, улс төрчдийн үйл ажиллагааны талаархи гомдлыг хэлэлцэх үед үнэнийг нотлох зардлыг ихэнхдээ зарга мэдүүлэгч гаргах болдог. Энэ нь төрийн ашиг сонирхолтой холбоотой асуудал нээлттэй байхын чухлыг хуулиар баталгаажуулж байгаа хэрэг юм.
- Олон улсын түвшинд үүнийг дэмжсэн олон тооны албан мэдэгдэл байдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих тусгай мандат бүхий гурван байгууллагын 2000 онд гаргасан Хамтарсан Тунхаглалд: “ Олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн аливаа мэдэгдэлийн худал хуурмаг болохыг батлах үүргийг зарга мэдүүлэгч тал хариуцах ёстой” хэмээн тэмдэглэсэн юм. Үүний нэгэн адил, *Нэр төр гутаах үйлдлийг тодорхойлох нь* баримт бичигт дурдахдаа:
Зарга үүсгэсэн тал олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн мэдэгдэлтэй холбоотой тохиолдолд аливаа мэдэгдэлийн худал хуурмаг болохыг батлах үүрэг эсвэл нэр төр гутаасан үйлдэлд буруутгасан баримтыг хариуцах ёстой.

2. Үзэл бодол

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх ба баримтын талаар мэдэгдэл хийхийн хооронд ямар гол ялгаа байна гэж та бодож байна ? Энэ хоёрыг хооронд нь андуурсан нөхцөлд ямар байхыг та төсөөлж байна уу? Бодож үзэцгээе.

- Олон улсын хуулийн хүрээнд үнэн худлыг нь нотлож болох бодит баримтын талаар мэдэгдэл хийх ба нотлох боломжгүй зөвхөн үзэл бодлоо илэрхийлэх хоёрыг ялган зааглан шаардлага тулгардаг. Нэгдүгээр асуудлын хувьд үнэнийг

нотлох нь гол хамгаалалт болдог бол үзэл бодолтой холбогдохоор асуудал илүү төвөгтэй болдог.

- Олон улсын хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлэх нь хуулийн хатуу хамгаалалтанд байхаар зохицуулсан ба зарим оронд үзэл бодлоо илэрхийлсний төлөө хэн ч нэр төр гутаасан хэргээр хуулийн хариуцлага хүлээдэггүй. Энэ нь олон улсын хууль үзэл бодлын илэрхийллийг хуулийн хатуу хамгаалалтанд авсантай холбоотой.
 - *Жишээ:* Үүнийг Нэгдсэн Улсад олон нийтийн эрх ашгийн төлөө хэлсэн үзэл бодлын илэрхийлэлд аливаа нэгэн арга хэмжээ авахгүй, өөрөөр хэлбэл энэ үйлдэл үндсэн хуулийн хүрээнд бүрэн хамгаалагдсан байдлаар сайтар зохицуулсан байдаг. Энэ төрлийн хамгаалалтад хоёр хэлбэрийн мэдэгдэл хамаарах ба үүнд: “ баталж болох хуурамч далд санаа агуулаагүй” ба “ бодит баримтыг үндэслэлтэй тусгасан тайлбарлах боломжгүй” мэдэгдэлүүд юм. Энэ төрөлд мөн баримтыг дурдсан ч энэ нь маш энгийн хэлбэртэй, егөөдсөн, тухайлбал хошин элэглэлийн өнгө аястай мэдэгдэлийг хамгаалахаар оруулсан байдаг.
 - *Жишээ:* Нэгдсэн вант улсын Лордуудын Танхим үзэл бодлоо илэрхийлэхтэй холбогдуулан мэдэгдэл хийхдээ: “Хэтрүүлсэн, зөрүүдэлсэн, ялгаварлан гадуурхсан үг мөн эсэхийг нь үг хэлсэн хүний үйлдлээр шинжих нь хамгийн бодитой арга юм”. Үг хэлэх эрхийг нэг талаар хаасан юм шиг хэрнээ энэ нь эрхийг улам баталгаажуулсан дээд зэргийн хамгаалалт болсон юм.
- Олон улсын шүүхүүд, олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн асуудлаар үг хэлэх эрхийг хөнддөг хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хязгаарлалтанд ихээхэн анхаарал хандуулж, асуудлыг өргөн хүрээнд, хууль эрх зүйн тусгайлан авч үзэх сэдэв гэж үздэг. Үүнтэй холбоотойгоор, Европын Хүний Эрхийн Шүүхээс мэдэгдэхдээ: “Улс төрийн өнгө аястай үг хэлэх эсвэл нийтийн эрх ашгийг хөндөхөд хязгаарлалт тавих ...хамрах хүрээ нь хэт явцуу байгаа...” Ардчилалын тулгын чулуу бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээлэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал.
- Улс төрчдийн талаарх мэдэгдэлд зөвхөн зайлшгүй чухал тохиолдолд хязгаарлалт тавих ёстой.
 - *Жишээ:* Нэр төр гутаахтай холбоотой хэрэг дээр Евходын Хүний Эрхийн Шүүхээс мэдэгдэхдээ:

Хүлээн зөвшөөрөх шүүмжлэлд хязгаарлалт хийх нь ... хувь хүний хувьд авч үзэлгүй улс төрчийн хувьд өргөн утгаар нь уян хатан хандах ёстой юм. Хувь хүнийг бодвол улс төрч хэлсэн үг, хийсэн үйлдэл бүрийг нь шинжинэ гэдгийг мэдсэн мөртөө сайн дураараа, сэтгүүлчийн дуран улмаар олон нийтийн өмнө гарч ирсэн болохоор дээд зэргийн тэвчээр хүлээцтой байх ёстой.

- *Жишээ:* Европын Хүний Эрхийн Шүүх мөн Засгийн газар шүүмжлэлд улс төрчдөөс ч илүү хүлээцтой байх ёстойг сануулан мэдэгдэхдээ:

Хүлээж авахуйц шүүмжлэлд хязгаарлалт хийхдээ Засгийн газар хувь хүн, тэр ч байтугай улс төрчдөөс ч илүү өргөн утгаар нь уян хатан хандах ёстой юм. Ардчилсан нийгэмд Засгийн газрын үйл ажиллагаа, алдаа дутагдал нь зөвхөн хууль тогтоох ба шүүх засаглалаар хязгаарлахгүй хэвлэл мэдээлэл, олон нийтийн хараа хяналтад орших ёстой сэдэв юм.

- *Жишээ:* Улс төрчтэй холбоотой хэрэг өмнө нь гарч байсан хэдий ч Европын Хүний Эрхийн Шүүх “сайжруулсан хамгаалалт” төрийн албаныханд хамаатай болохыг мөн тодорхой болгосж өгсөн юм. 2001

онд, Люксембургт гарсан Тхомагийн хэрэг дээр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчийн ажлын ур чадварын талаар өрнүүлсэн хэлэлцүүлэгт энэ нь мөн дээрхи хэм хэмжээнд хамааралтай болохыг Шүүхээс мэдэгдэхдээ:

Албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид, улс төрчдийн адил, хүлээн зөвшөөрөхуйц шүүмжлэлд хувь хүнийг бодвол илүүтэй өртдөг юм.

- Энэхүү онцгойлсон хамгаалалтын зэрэг зөвхөн улс төрийн хэлэлцүүлгийн үед хамаараад зогсохгүй нийтийн эрх ашиг хөндөгдсөн бүх тохиолдолд хамаарах юм. Европын Хүний Эрхийн Шүүх энэ хоёрыг ялган зааглах “ ямар ч баталгаа байхгүй ” гэдгийг тодорхойлон мэдэгдсэн юм.
 - *Жишээ:* 2009 онд Туркэд болсон Синан Озтуркийн хэрэг, зарга мэдүүлэгч өөрөө менежерээр нь ажиллаж байсан түүхэн дурсгалт барилгын хамгаалах талаар шүүмжлэлт нийтлэл нийтлүүлэхдээ, сэргээн засварлах төсөл ямар ч амжилтгүй болж үр дүнд нь түүхэн дурсгалт барилга хэсэгчлэн нурсан, татвар төлөгчдийн мөнгийг нууцаар, үр ашиггүй үрэн таран хийснийг онцлон дурдсан байна. Европын Хүний Эрхийн Шүүх албаны хүмүүсийн буруутай үйлдэл эсвэл авилгал авсаныг илчилсэн энэхүү мэдэгдлийг маш хүчтэй өмгөөлж шийдвэр гаргахдаа:

Энэхүү нөхцөл байдалд, Шүүх дүгнэлтээ гаргахдаа, Конвенцийн 10 дугаар зүйлийн 2 дугаар бүлэгт бусад хүмүүсийн нэр хүндийг хамгаалах зорилгоор хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхэд хязгаарлалт хийж болохыг дурдсан байдаг ч, нэр төр гутаахтай холбоотой хууль, журмын зорилго эсвэл үр нөлөө нь хэрвээ төрийн эрх мэдэлтнүүдийг хууль ёсны шүүмжлэл эсвэл албан хаагчдын буруутай үйлдэл эсвэл авилгыг илчлэхээс урьчилан хамгаалах бол зөвтгөн үзэх аргагүй юм гэжээ

- Томоохон корпорациуд мөн хайр найргүй, хатуу шүүмжлэлд хүлээцтэй хандах ёстойг Европын Хүний Эрхийн Шүүхээс тэмдэглэсэн байдаг. Үүнд:

Төрийн өмчит [Томоохон] компаниудын явуулж буй үйл ажиллагаа олны нүдний өмнө нээлттэй байхыг мэдэж байгаа, тэдгээрийн удирдлагад ажиллаж байгаа эрэгтэй эмэгтэй бизнесменүүд компанийн нэртэй холбоотой хүлээн зөвшөөрөхуйц шүүмжлэлд хязгаарлалт хийлгүй, өргөн утгаар нь хандах ёстой.

- Улс төрийн мэтгэлцээн ба цаг үеийн асуудлаар өрнөдөг мэтгэлцээн нь олон нийтийн эрх ашиг хөндөгддөг хэлэлцүүлэгийн хамгийн түгээмэл хэлбэр байдаг ч олон улсын шүүхээс түүхэн сэдэвтэй мэтгэлцээнд мөн чухал ач холбогдол өгдөг.
 - *Жишээ:* 2010 онд Азербайджанд болсон Фатиллаевын хэрэг, Шүүгдэгчийг Нагорный- Карабахад болсон мөргөлдөөний үйл явдлын талаар албаны эх сурвалжаас өөр мэдээлэл гаргаж тавьсан, ингэхдээ Азербайджан Армийн цэргүүдийг гутаан доромжилсон хэргээр орон нутгийн шүүх ялангуяа хоёр хувь хүний гаргасан гомдлыг үндэслэн түүнд нэр төр гутаасан хэргээр ял тулгасан байна. Европын Хүний Эрхийн Шүүх мэдэгдэхдээ:

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний салшгүй хэсэг нь түүхэн үнэнийг мэдэх явдал болохыг Шүүх тэмдэглэж байна. Үүний зэрэгцээ, болсон хэрэг явдлын талаар олон өнцгөөс бичих, тайлбарлах зэргээр өнөө хэр нь түүхчдийн дунд маргаан дагуулсаар байгаа түүхэн үйл явдлын зөв бурууг тогтоох нь Шүүхийн үүрэг биш юм.

Хэлэлцүүлэг: Тусгайлан хамгаалах ёстой нийгмийн мэтгэлцээний хамрах хүрээ хэр зэрэг өргөн байх ёстой гэж та үзэж байна? Ёс суртхууны дутагдал гаргасан улс төрчдийн хувийн амьдралын талаар ярих ёстой юу? Залууст нөлөөлөх зорилгоор зохион байгуулдаг төрөл бүрийн ёслолын арга хэмжээг яах ёстой вэ?

- Уран сайхны аргаар үзэл бодлоо илэрхийлэх олгогдсон эрхийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл тухайн мэдээллийг дагалдуулан хэтрүүлэг, егөөдөл, хүчтэй үг хэллэг эсвэл өнгөөр дүрсэлсэн зураглалыг чөлөөтэй ашиглаж болдог.
 - *Жишээ нь:* 1997 онд Австрид болсон Оберчиликийн хэрэг (№. 2), Европын Хүний Эрхийн Шүүх улс төрчийг тэнэг гэж дуудсан явдал нь тухайн улс төрчийн өмнө нь хийж байсан өдөөн хатгасан өнгө аястай мэдэгдэлээс үүдэлтэй учраас түүнд барьсан хууль ёсны хариу гэж үзсэн. Үүнд:

Шүүхийн зүгээс, гомдол мэдүүлэгчийн бичсэн нийтлэл, ялангуяа “ тэнэг” гэсэн үгийг шүүмжлэлтэй өнгө аясаар хэрэглэсэн, хувь хүн рүү дайрсан гэж тооцох аргагүй, учир нь нийтлэгч энэ үгийг ноён Хайдерийн өмнө нь өдөөн хатгасан өнгөөр хэлсэн үгнээс иш татсан болох нь өөрөө тодорхой ойлгомжтой тайлбар болж байна.

- Үүнтэй нэгэн адил, 2000 онд Португалид гарсан Лопес Гомес да Силвагийн хэрэг дээр Европын Хүний Эрхийн Шүүх мэдэгдэхдээ: Ноён Ресендегийн илэрхийлсэн үзэл бодол ба үүний зэрэгцээ редакцийн маргаж байгаа санаа, үг хэллэг, егөөдсөн, өдөөн хатгасан үнэн хэрэгтээ хэтрүүлсэн өнгө аястай байна. Иймээс зарга мэдүүлэгчийн нийтлэлийн хэлбэр ноён Ресендегийн нөлөөнд автсан гэсэн дүгнэлт хийх нь үндэслэлгүй биш байна.
- Олон улсын хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлсний төлөө хэн ч шүүх дээр үнэнийг нотлох шаардлагагүй байхаар хэм хэмжээг зохицуулсан байдаг.
 - *Жишээ нь:* 1986 онд Австрид гарсан нэр төр гутаахтай холбоотой анхны хэргүүдийн нэг болох Лингений хэрэг, Европын Хүний Эрхийн Шүүх анх удаа шүүгдэгч сэтгүүлч, улсынхаа Ерөнхий Канцлерыг хайр найргүй, хатуу үг хэллэг хэрэглэн элдвээр буруутгахдаа тухайлбал “адгийн оппортунист “ёс суртхуунгүй этгээд” “нэр төрөө уландаа гишгэсэн” гэх мэтээр шүүмжилсэн хэрэгтэй тулгарсан юм. Австрийн дотоодын шүүх сэтгүүлч хийсэн мэдэгдэлийнхээ үнэн бодитойг баталж чадахгүй байсан зэргээс үүдэн түүнийг шийтгэсэн юм. Шүүх бодит баримтын талаарх мэдэгдэл ба үзэл бодлын илэрхийлэл эсвэл шүүхийн шийдвэрийн үнэ цэнийн хооронд ялгаа байх ёстойг дурдахдаа:

Бодит баримт ба шүүхийн шийдвэрийн ач холбогдолын хооронд тодорхой ялгаа хийх шаардлагатай гэж Шүүх үзэж байна. Баримт байгааг үзүүлж нотолж болдог бол, шүүхийн шийдвэр үнэн болох нь аливаа нотолгоог шаарддаггүй. ... Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийн 3 дугаар бүлгийн заалтын дагуу 2 дугаар бүлгийг холбогдуулан уншвал сэтгүүлч ийм хэрэг тохиолдох үед 1 дүгээр бүлэгт тусгайлан заасан заалтын дагуу хэлсэн, нийтэлсэн баримтынхаа үнэн бодитойг нотолж чадахгүй бол шийтгэлээс мултрах аргагүй (дээр дурдсан 20 догол мөрийг анхааралтай уншина уу).

Шүүхийн шийдвэрийн үнэ цэнэтэй энэхүү шаардлагыг холбон үзвэл, биелүүлэх боломжгүй ба ингэснээр Конвенцийн 10 дугаар зүйлээр (бүлэг 10) хамгаалсан үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг боогдуулж байна.

- *Жишээ нь:* 1999 онд Румынд болсон Далбанны хэрэг, Залилангийн хэд хэдэн удаагийн хэргийн талаархи нийтлэлтэй холбогдуулан Европын Хүний Эрхийн Шүүхээс мэдэгдэхдээ:

Сэтгүүлч үнэнийг нотлож чадахгүйн улмаас асуудалд шүүмжлэлтэй хандаж, улмаар бичиж нийтлэх эрхээ хасуулах нь хүлээн зөвшөөрч болохгүй зүйл юм.

- Хувь хүний хийсэн мэдэгдлийг үзэл бодлын илэрхийлэл гэж тодорхойлох эсэх нь заримдаа хэцүү асуултыг дагуулдаг. Хэн нэгэн хүнийг “ сайн “ эсвэл “ муу” гэж саналаа чөлөөтэй илэрхийлсэн байлаа гэхэд өөр нэг хүнийг “ гэмт хэрэгтэн” хэмээн мэдэгдсэн тохиолдлыг яаж авч үзэх вэ? Зарим үед үзэл бодлын илэрхийлэл гэж санаатайгаар ойлгогдохуйц тодорхой шинжийг агуулсан мэдэгдэл хийсэн нь байдаг. Энэ нь ихэнхдээ дэвэргэсэн аястай үг хэллэг тухайлбал, егөөдөл, хошигнол, байдлыг хэтрүүлсэн үг ярианд тохиолддог. Ерөнхийдөө, шүүх эргэлзээ төрүүлсэн мэдэгдлийн уг чанар, үзэл бодлын илэрхийлэл гэж болохоор тодорхойгүй мэдэгдлийн уршиг дагаврыг тооцоолж шүүгдэгчийн саналтай уялдуулан хэргийг шийдэх хандлага баримталдаг. Бодит баримтын талаар хийсэн мэдэгдэл болох нийтлэлийг тухайн улс орны дотоодын шүүх нэр төр гутаасан хэргээр буруу шийдвэрлэсэн олон хэргийг Европын Хүний Эрхийн Шүүх хянан хэлэлцсэн юм.

- *Жишээ:* 2009 онд Сербид болсон Водрозик ба Вүжинний хэрэгт Европын Хүний Эрхийн Шүүх нийтлэгдсэн зүйлийн асуулга нь хошин аястай байгааг харгалзан үзэж шийдвэрлэсэн. Үүнд дурдахдаа:

2-р зарга мэдүүлэгчийн дурдсан, сонины “Зугаа цэнгэл” буланд нийтлэгдсэн текстийн агуулга хэлбэр нь хошин аястай, С.К-гийн нэр хүндэд хонзогнон халдах зорилготой дайрсан мэдэгдэл гэж үзэхээс илүүтэй хошигнол гэж ойлгогдож буй тул Шүүхийн зүгээс буруутгах боломжгүй гэж үзсэн.

- Жишээ нь 2001 онд Словакийн Фелдект гарсан хэрэг. Европын Хүний Эрхийн Комисс зарга мэдүүлэгчийн гаргасан гомдолд “ фашистын үлдэгдэл” гэсэн үг нь тухайн хүнийг фашист үзлийг сурталчилсан үйл ажиллагаанд оролцдог хэмээн доромжилсон гэж үзсэнтэй санал нийлээгүй. Үүнийг тухайн хэллэг нь түгээмэл хэрэглэгддэг, өөр утга агуулж байж болох талтайг тайлбарласан ба энэ нь тухайн хүнийг фашист үзлийг сурталчилсан үйл ажиллагаанд оролцдог, цахимт бүлгийн гишүүдийн нэг гэж үзэх боломжгүй хэмээн тайлбарлажээ. хэмээн доромжилсон

3. Үндэслэлтэй нийтлэл

- Одоогийн байдлаар тодорхой нөхцөлтэй уялдуулан худал хуурмаг мөн бодит баримтын талаархи нэр төр гутаасан мэдэгдэл нь хариуцлага хүлээхээс хамгаалагдсан байхыг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ. Хүмүүсийн мэдэх эрхийг хангахын төлөө ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд заримдаа мэдээ, мэдээлэл бүрийн бодит эсэхийг тодруултал хүлээн байж нийтлэх, нэвтрүүлэх боломжгүй байдаг атал тэдэнд худал хуурмаг мэдээллийн төлөө хариуцлага хүлээлгэх дүрэмтэй байдаг нь шударга бус юм. Шилдэг сэтгүүлч нар ч бодлогогүй алдаа гаргах явдал тохиолддог тул мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүлээн авах эрхтэй олон нийтийн ашиг сонирхлыг бодолцон худал мэдээлэл түгээсэн алдааг нээлтэй орхидог. Мэдээллийг үндэслэлтэйгээр нийтлэхийн төлөө ажилласан хүмүүсийг хамгаалах мөртөө үүнд хамаарахгүй хүмүүсийн эсрэг зарга мэдүүлэхийг зөвшөөрөх нь зохистой тэнцвэрийг хадгалсан, үндэслэлтэй нийтлэлийг хамгаалах арга гэж тодорхойлж болох юм.

- Сэтгүүлч хүн худал мэдээлэл түгээсэн алдаа бүрийг нээлттэй орхидог нь мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүлээн авах эрхтэй олон нийтийн ашиг сонирхлыг бодолцсон хэрэг билээ.

- *Жишээ нь:* Европын Хүний Эрхийн Шүүхээс 1991 онд Их Британийн (№2) “Ням гаригийн мэдээ” сонины хэргийн талаар тэмдэглэхдээ:

Цаг үеийн мэдээ нь шинэ сэргэг байхыг шаарддаг учраас мэдээллийг нийтлэхээс түр татгалзах, хугацаа нь хичнээн богино байлаа ч энэ нь эргээд мэдээний үнэ цэнэ, сонирхол татах байдлыг үгүй болгож байна.

- *Жишээ нь:* Норвегид гарсан Тромсо ба Стенсасын хэрэг, Норвегийн шүүхээс худал хуурмаг, нэр төр гутаасан мэдэгдэл хийсэн хэмээн шийдвэрлэсэн хэргийг Европын Хүний Эрхийн Комиссоос дүгнэхдээ:

Хэрвээ зөвхөн үнэн [бодит] гэдэг нь батлагдсан мэдээллийг олны сонорт хүргэнэ гэж үзвэл хэвлэл мэдээлэлийн эрх чөлөө маш хатуу хязгаарлалтанд орно. Хэрвээ зөвхөн ийм төрлийн мэдээлэл нийтлэхийг зөвшөөрвөл хэвлэл мэдээллийн удирдлага ба сэтгүүлчдийн ажиллах нөхцөлд томоохон гарз хохирол учруулах болно.

- *Жишээ нь:* Шүүхийн Хорооны Зөвлөхүүдийн Зөвлөл үүнтэй адил, үнэн бодит болох нь тогтоогдоогүй мэдээ мэдээлэл нийтэлсэн үйлдэлд шийтгэл оноох тухай дүрмийн “гашуун” нөлөөг цохон тэмдэглэхдээ:

[Энэ нь] үнэн худлыг нь шалгая гэж өчүүхэн ч санаа тавилгүй хэлсэн үгний төлөө хүнийг буруутгаж байгаатай маргахын аргагүй адил юм. ... Энэ нь ямар хэлбэртэй байлаа ч хэвлэлийн эрх чөлөөнд томоохон садаа тотгор болно. Хэрвээ хэвлэл нийтэлдэг эсвэл түгээн тараадаг ХМХ ажилтнууд шүүмжлэлтэй холбоотой бүх мэдэгдлийн үнэн бодитой эсэхийг эхэлж шалгаж чаддаг бол, эрх мэдэлтэнтэй холбоотой асуудлыг аливаа гэм шийтгэлгүйгээр дараа нь гаргаж тавих ёстой болох нь ... гэжээ.

- *Жишээ нь:* Богочид болсон Үндэсний хэвлэл мэдээлэлийн байгууллагын хэрэг, Өмнөд Африкийн давж заалдах шатны Дээд Шүүх алдаатай мэдээ мэдээллийн төлөө хариуцлага хүлээлгэх дүрмийг хүлээн зөвшөөрөх аргагүйг дурдаад, “Өчүүхэн жижиг алдааны төлөө хор хохирол амсахаас эмээх шиг гашуун үр дагавар үгүй” гэжээ.
- Үүнтэй адилаар, Америкийн Нэгдсэн Улсын Дээд Шүүх Нью Йорк Таймс ба Силиваны хэрэг дээр дүгнэлтээ гаргахдаа:

Ийм төрлийн хуулийг удирдлага болговоос, шүүх хурал дээр үнэнийг нотолж чадахгүй гэсэн айдас, эсвэл нотлохын тулд гарах зардлаас эмээсэндээ үнэн гэж итгэж болохоор, эсвэл үнэн хэрэгтээ болсон баримтыг албаны хүмүүс ил гаргаж шүүмжлэхийг боогдуулах тал бий. “Хууль бус бүсээс хамаагүй хол” байх өөрөөр хэлбэл зөвхөн гэм зэмгүй өнгөрөх зүйлийн талаар л ам нээдэг болно.

- Дэлхийн олон орны шүүх ба хууль тогтоогч нар дээрхи асуудлыг хүлээн зөвшөөрч, үнэнийг нотлохыг өмгөөлөх янз бүрийн хувилбарыг боловсруулсан юм. Өмгөөлөлийн хэлбэр бүр шинж чанараараа өөр байдгийг тэмдэглэхийн зэрэгцээ ерөнхийд нь “ул үндэслэлтэй хамгаалалт” хэмээн нэрлэж, заримдаа иш татан хэрэглэх нь бий. Өмгөөлөлийн эдгээр бүх хэлбэр, эсвэл хариуцлагын дүрэм нь хийсэн мэдэгдэл худал хуурмаг, гүтгэж доромжилсон байсан ч хамаагүй бүгд баримттай мэдэгдэлд түшиглэдэг. Сайхан сэтгэлийн үүднээс эсвэл санаатайгаар шүүгдэгч тал мэдэгдэл хийснээс үл хамааран түүнийг нэр

төр гутаасан үйлдэлд ямарваа нэгэн хариуцлага хүлээлгүй өмгөөлснөөр эдгээрийн үр дүнг тооцдог.

- *Европ*: Европын Шүүхээс 1999 онд Норвегид болсон Владет Тромсо ба Стенсеесийн хэрэгт” сэтгүүлчийн ёс зүйгээ баримтлан олон нийтийг тодорхой, найдвартай мэдээллээр хангахыг дээдлэн ажиллах” учраас олон нийтийн сонирхлыг татаж буй сэдвээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийтэлж нэвтрүүлж болохыг зөвшөөрнө гэж үзсэн.
- *Энэтхэг*: Энэтхэгт 1994 онд гарсан Р.Ражагүпал ба Тамил Наду муж хэрэг дээр Энэтхэгийн Дээд шүүх шоронгийн хоригдлын бичсэн намтрыг төрийн албан хаагч нар нийтлүүлэхгүй байж болох мөртөө долоо хоног тутмын сэтгүүлд нийтлүүлсэн хойноо өөрсдийнх нь нэр төрийг гутаасан гэж зарга мэдүүлсэнд хэргийн гол учир байна гэж үзсэн. Дээд шүүхээс мэдэгдэхдээ:

Төрийн албан хаагчдын хэргийн тухайд... тэдний хийсэн үйлдлийг авч үзвэл албан үүргээс нь чөлөөлөх арга хэмжээ авбал зохистой болохоос нэр хүндэд нь сэв суулгасан үйлдэл гэж үзэх аргагүй байна. Шүүгдэгч нь нийтлэлдээ үнэнийг зориудаар гуйвуулсан гэдгийг дээрх албан хаагч нар нотолсон гэж байгаа ч уг нийтлэл нь худал хуурмаг мэдээлэл дээр үндэслэн бичигдсан байлаа ч нэр төр гутаасан гэж дүгнэх аргагүй юм гэж үзсэн.

Өмнөд Африк: 1998 оны Үндэсний хэвлэл мэдээлэл ХХК Богочи хэрэг дээр Өмнөд Африкийн давж заалдах шатны Дээд Шүүх мөн тэнцвэрийг баримталсан хэлбэрийг баталсан. Шүүх нэр төр гутаахтай холбоотой хэргээр хатуу хариуцлага тооцохыг эсэргүүцэж, мэдэгдэхдээ “ өчүүхэн алдааны төлөө гэм хохирлын хариуцлага хүлээх нөхцлийг бүрдүүлэхээс илүү хор уршигтай зүйл байхгүй” гэжээ. Улмаар “ Хэрвээ хэргийн нөхцөл байдлыг авч үзэхэд, цаг хугацааг зориуд тааруулан, бодит баримтыг илтээр гуйвуулан, үндэслэлтэйгээр хэвлэн нийтэлснээс бусад тохиолдолд үнэнийг гуйвуулсан, нэр төр гутаахтай холбоотой хуурамч мэдээлэл хэвлэлд гаргасныг хууль бус гэж үзэхгүй “ гэсэн.

- *Америкийн Нэгдсэн Улс*: АНУ-д тухайн салбартаа шуугиан дэгдээсэн Нью Йорк Таймс ба Силиваны хэрэг. Алдаатай мэдээлэл агуулсан нотолгоо бүхий энэ хэрэгт, үнэн худал эсэхийг нь үл тоомсорлосон эсвэл худал гэдгийг мэдсээр байсан ч зөвхөн “ хорон санааны” үүднээс санаатайгаар уг мэдэгдэлийг хийсэн гэдгийг төрийн албан хаагч нотолж чадсан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлж болно гэсэн дүгнэлтийг Шүүх гаргасан байна.

Хэлэлцүүлэг: Үндэслэлтэй нийтлэлийг өмгөөлөх талаар таны саналыг сонсож болох уу? Энэ Монголын нөхцөлд таарах болов уу? Энэ тохиолдолд, мэргэжлийн ёс зүй, тухайлбал хэвлэл мэдээлэлийн байгууллагад тогтсон ёс зүйн үндэслэлтэй, тодорхой хэм хэмжээ байдаг бол түүнд найдаж болох уу?

- Нэгдсэн Вант улсад гарсан хэрэг. Рейнолдын Цаг үеийн мэдээ ХХК ба бусад. (1999 он) Английн Лордуудын танхим нийтлэл үндэслэлтэй эсэхийг шийдэх жагсаалт гаргаж арван хүчин зүйлийг тодорхойлон заасан. Үүнд:

1. Мэдээлэл ноцтой эсэх. Хуурамч мэдээ мэдээллийн улмаас хувь хүн хохирсон эсэх, олон нийт буруу мэдээлэл авсан эсэх, хор хохиролтой эсэх
2. Мэдээллийн агуулгыг тодорхойлох, сэдэв нь ямар асуудлыг хөндсөн олон нийтэд холбоотой асуудал байгаа эсэх,
3. Мэдээллийн эх сурвалж. Зарим шүгэл үлээгч болсон явдлын талаар шууд бус эх сурвалжаас мэдээлдэг. Зарим нь өөрийн өнцгөөс асуудалд хандсан, зарим нь мэдээллийнхээ төлөө мөнгө авсан байдаг.
4. Эх сурвалжаа нягтлах талаар ямар алхам хийснийг мэдэх
5. Мэдээллийн уг байдал. Мэдэгдэл нь заримдаа эрэн сурвалжлах ажиллагааны сэдэв болж нөхцөл байдлыг нь сайтар тодруулсан байдаг.
6. Мэдээлэл яаралтай эсэх. Цаг үеийн мэдээ нь дорхиноо ач холбогдолоо алддаг.
7. Зарга мэдүүлэгчийн талаас тайлбар хүссэн эсэх. Тухайн хүнд өөр мэдээллэл байсан эсвэл түүнийгээ задруулахыг хүсээгүй байж болох. Зарга мэдүүлэгчид заавал хандах албагүй байж болно.
8. Зарга мэдүүлэгчийн өнцгөөс асуудалд хандсан агуулга байгаа эсэх
9. Мэдээллийн өнгө аяс. Сонины газар асуулга явуулсан эсвэл эрэн сурвалжлага хийн утасдсан байж болно. Энэ нь мэдээллийг баримтын талаархи мэдэгдэл гэж хүлээж авах эсэхийг тодруулдаг.
10. Нийтлэлийн нөхцөл байдал үүнд цаг хугацаа орно.

Хэлэлцүүлэг: Энэ жагсаалтыг та юу гэж үзэж байна ? Үүн дээр өөр нэмэх эсвэл хасах зүйл байна уу?

4. Өмгөөллийн бусад хэлбэрүүд

Бусдын хэлсэн үгс

- Доорхи гурван нөхцөл бүрдсэн үед хувь хүн бусдын нэр төрийг гутаахтай холбоотой мэдээдэл тараасан, дамжуулан тараасан бол хариуцлага хүлээхгүй гэж үзэх ба: үүнд нэгдүгээрт, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хэлэлцүүлэгээс хэсэгчлэн авсан мэдээлэл, хоёрдугаарт, хувь хүн мэдээллийг баталгаажуулахаас татгалзсан, гуравдугаарт, бусдын хийсэн мэдээллийг дамжуулсан нь тодорхой байгаа нөхцөлд хариуцлага хүлээхгүй.
 - *Жишээ нь:* 2002 онд Францад гарсан Коломбанийн хэрэг, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл албан ёсны тоо баримтад түшиглэн, баримтын үнэн бодитыг шалгалгүй дамжуулах эрхтэйг Европын Хүний Эрхийн Шүүхээс тогтоон мэдэгдэхдээ:
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бие даасан судалгаа хийлгүйгээр, албан ёсны тоо баримтаас иш татан, хууль ёсны асуудлаар олон нийтийн мэтгэлцээнд хувь нэмрээ оруулах эрхтэй гэж Шүүх үзэж байна. Эс бөгөөс, хэвлэл мэдээлэл өөрөө олон нийтийн хоточ нохой байх үүргээ алдахад хүрнэ. Иймээс, Шүүх Ле Монде сонин өөрсдөө мэдээллийн үнэн бодит эсэхийг шалгах шаардлагагүйгээр Нээлттэй Засгийн газрын тоо баримтыг ашигласныг Шүүх үндэслэлтэй гэж үзэж байна. [ишлэлийг орхигдуулсан]
- Энэхүү өмгөөлөл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл цаг үеийн мэдээ дамжуулах үүрэгтэйн улмаас мэдээн дотроо бусдын нэр хүндэд халдсан мэдээ мэдээллэл

оруулж болзошгүйг хүлээн зөвшөөрдөг. Улмаар, сэтгүүлчид өөрсдийгөө эвгүй байдалд оруулах мэдээ дамжуулахаас зайлсхийх ёсгүй, эсвэл мэдээ бүрийн үнэн зөвийг шалгах ёсгүйг хүлээн зөвшөөрнө.

- *Жишээ нь:* 2001 онд Люксембургт гарсан Томагийн хэрэгт радиогийн сэтгүүлч Люксембургийн наян ойн байцаагчдаас зөвхөн нэг хүн авилга аваагүй тухай мэдээлсэн сонинны нийтлэлийг иш татан дурдсан. Шүүхээс сэтгүүлчийг шийтгэсэн нь тухайн хүний үзэл бодлын илэрхийллийг боогдуулж байна гэж үзэн мэдэгдэхдээ:

Өөр хүний хийсэн мэдээллийг дамжуулахад тусалсны төлөө сэтгүүлчид шийтгэл ноогдуулжээ. .. Үндэслэлтэй шалтгааны улмаас энэ хэргийг хийгээгүй нь тодорхой бол энэ нь олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хэлэлцүүлэгт хэвлэл мэдээлэл хувь нэмрээ оруулах боломжийг ноцтойгоор боогдуулсан хэрэг болно.. гэж үзсэн

- Мөн энэ хэрэг дээр, олон нийтэд хүргэсэн мэдээллээ сониноос иш татсан гэдгээ анхааруулаагүй, мэдээллийг өөрөөсөө албан ёсоор холдуулсан гэсэн агуулгатай заргыг Шүүх хэрэгсэхгүй болгон мэдэгдэхдээ:

Цаг үеийн үйл явдал, үзэл бодол, санаа онооны талаар мэдээ мэдээлэл хүргэдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн үүрэг нь бусдыг доромжлох эсвэл өдөөн хатгах эсвэл тэдний нэр төрийг гутааж болзошгүй ишлэлийн агуулгаас системтэйгээр ба албан ёсоор өөрийгөө ангид байлгах ёстой гэсэн сэтгүүлчид тавьдаг ерөнхий шаардлагатай нийцэхгүй байна.

Давуу эрхтэй нөхцлүүд

- Чөлөөтэй ярих нь зайлшгүй шаардлагатай тодорхой хэд хэдэн нөхцөлд хийсэн мэдэгдлийнхээ төлөө нэр төр гутаасан хэргээр хэзээ ч хариуцлага хүлээдэггүй. Иймэрхүү “давуу эрхтэй” нөхцөлд жишээлбэл, шүүхийн өмнө хийсэн мэдэгдэл, сонгогдсон гишүүдийн өмнө хэлсэн үг, энэ төрлийн мэдээллийн тухай тайлан тооцогдоно. Өөр бусад, хэд хэдэн төрлийн мэдэгдэл “ давуу эрх” эдлэх ба үүнд, хүнд өвчтэй, гомдсон үедээ хэлсэн үг болох нь батлагдвал хариуцлага хүлээхгүй өнгөрдөг. Энэ төрөлд мөн үг хэлсэн этгээд хуулийн, ёс суртхууны, нийгмийн хариуцлагаа ухамсарлан хийсэн мэдэгдэл багтдаг. Жишээ нь хэн нэгнийг гэмт хэрэгт сэжиглэн цагдаагийн газарт мэдэгдсэн байж болно.
- *Жишээ нь:* Европын Хүний Эрхийн Шүүх хууль тогтоох байгууллага, парламент дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрч, энэхүү дархан эрхийн зорилгыг доорхи байдлаар дурдсан. Үүнд: Эдгээр гишүүдэд шүүх, түүнтэй дүйцэх эрх мэдэл бүхий байгууллагын өмнө буруутан болох аюулаас зайлсхийхийн тулд өөрсдийн хэлэх үгийг найруулан засах, дүгнэлтээ хянаж цэнэлгүйгээр олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудалд шүүмжлэлтэй хандах, учир утгыг тунгаасан хэлэлцүүлэгт оролцох боломжийг олгох хэмээн тодорхойлсон.(2002, Нэгдсэн Вант Улс)
- Орчин үеийн ардчилалын мөн чанар нь парламентын хэлэлцүүлэг хийх эрх чөлөө байдаг учраас парламент дээр хэлсэн үг үнэмлэхүй дархан эрхтэй байх үндэстэй билээ. 2001 онд Австрид болсон Иерусалим Сузаннагийн хэрэг, Европын Хүний Эрхийн Шүүх зөвхөн хязгаарлагдмал дархан эрх эдлэх ёстой эмэгтэй улс төрч форумын үеэр хийсэн мэдэгдэлийн талаарх асуудлыг хянан хэлэлцээд, сонгогдсон улс төрчийн үг хэлэх эрхийг онцлон авч үзэхдээ шүүгдэгч хязгаарлагдмал дархан эрх эдлэх ёстой байсан өөр форумын үеэр мэдэгдэл хийсэн болохыг тэмдэглэсэн байна.
- Энэ нь мөн адил дээд зэргийн хамгаалалт эдлэх ёстой шүүх хурлын хянан шийдвэрлэх үйл ажиллагааны үеэр хийсэн мэдэгдэлд хамаардаг. Шүүх дээр

ялангуяа өмгөөлөгчийн хийсэн мэдэгдэл хамгаалалт эдлэх ёстой ба учир нь өмгөөлөгч хүн “олон нийт ба шүүх хоёрын дунд зуучлагч”-ын чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд өөрийн өмгөөлж буй үйлчлүүлэгчийг өмгөөлөхийн тулд ур чадвараа ашиглан чадах бүхнээ чөлөөтэй хийдэг юм.

- *Жишээ нь:* 2002 онд Финландад болсон Никулагийн хэрэг дээр Европын Хүний Эрхийн Шүүхээс мэдэгдэхдээ:

Тийм ч учраас зөвхөн онцгой тохилдолд хязгаарлалт тавьдаг – тэр ч байтугай эрүүгийн ял шийтгэлийг зөөлрүүлэх замаар – өмгөөлөгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ардчилсан нийгэмд зайлшгүй байх ёстойг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй... Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэхэд нөгөө талыг өмгөөлөгч шүүмжилсэн баримтад дүн шинжилгээ хийхээр заналхийлэхийг – прокурор мөн эргэлзэлгүй бодолцох ёстой – үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхлыг үнэн сэтгэлээсээ хамгаалах өмгөөлийнхөө үүргийг биелүүлэх хоёрыг нэгтгэхэд хэцүү. Гаргасан зардалаа төлөх, эсвэл учруулсан хохирлын төлөө нөхөн төлбөр өгөх, эсвэл эрүүгийн хуулийн хамгийн хөнгөн шийтгэл оноосны “гашуун нөлөөнд” орохгүйн тулд өмгөөлөллийн маргаан үр ашиггүй, цагаа олоогүй байгааг үнэлэлгүй, хэрэгтний суудалд буруутан болж суух асуудалд өмгөөлөгчид өөрт нь эхлээд тулгарах үр дүн эндээс урган гарч байна.

- 2008 онд Финляндад болсон Жубалагийн хэрэгт зарга мэдүүлэгч нь эмчийг хүүхдийн хүчирхийлэлд сэжиглэж байгаагаа мэдээлсний улмаас нэр төр гутаасан хэрэгт холбогдсон. Шүүхээс хувь хүний үг хэлэх эрхийг өмгөөлөх үүднээс буулт хийж, уг мэдээллийг сайн сэтгэлийн үүднээс хийсэн гэж үзсэн.

Торгуулийн өр төлбөрт орох, эсвэл, нэр төрд сэв суулгасны төлөө нөхөн төлбөр төлөх, эрүүгийн хэрэгт холбогдох зэргээс эмээлгүй аливаа нэгэн хувь хүн иймэрхүү төрлийн мэдээлэл өгөх боломжийг нээлттэй байлгах үүднээс хүүхдийн хүчирхийлэлд буруутгасан дээрх мэдээллийг сайхан сэтгэлийн үүднээс хийсэн гэж үзсэн байна.

Гэм хоргүй нийтлэл

- Хийсэн мэдэгдэлийн төлөө аливаа нэгэн хариуцлага хүлээхгүй эсвэл санаандгүй байдлаар нэр төр гутаасан мэдэгдэлийг тараахад оролцсон эсвэл хэн нэгэн учрыг мэдэлгүйгээр нийтэлсэн байдаг “гэм хоргүй нийтлэлийг” өмгөөлөх эрхийг ихэнх орнууд хүлээн зөвшөөрдөг. Гэм хоргүй нийтлэлийг өмгөөлөхдөө ихэнхдээ график дизайны компаниуд эсвэл сонин тараагч хүүхдүүд зэрэг агуулгад огт санаа тавьдаггүй хүмүүс хэдий ч нийтлэлийг тараах эсвэл бичихэд оролцдог хувь хүмүүсийг хамгаалах болдог. Өмгөөлөл мөн орчин үеийн аппликейшн үйлдвэрлэгч нарт ч хамаарна. Жишээлбэл, Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд өөрөдийн захиалгач нарт зориулан интернетээр мэдээлэл түгээдэг, гэхдээ тараасан материал нэр төр гутаасан эсэхийг тодорхойлох нь шүүхийн үүрэг болохоос интернет үйлчилгээ үзүүлэгч нарт хамааралгүй асуудал билээ. Хэрвээ интернет үйлчилгээ үзүүлэгч нар мэдээллийн төлөө хариуцлага хүлээх бол тэд түгээх материалыг өөрсдөө шалгаж эхэлсний үндсэн дээр хориг цензур тавихад оролцон байдал тодорхой хэмжээгээр муудна. Ингэснээр тэд ч мөн өмгөөлөл хүсэх болно.

Модуль 4: Нэр төр гутаах : Шийтгэл, Бусад асуудал ба Өмгөөллийн үйл ажиллагаа

1. Шийтгэх арга хэмжээ

- Мэдэгдлийг нэгэнтээ нэр төр гутаасан гэж үзээд шийтгэл ногдуулахаар заах нь эргээд үзэл бодлын илэрхийлэлд заналхийлж эхэлдэг. Хэт хатуу шийтгэл нь зөвхөн хориотой материал нийтлэсэн тохиолдолд нөлөөлөөд зогсохгүй сэтгүүлчид ба бусад хүмүүсийн хэлэх эрхийг хязгаарлаж үүгээрээ хууль зөрчихөд хүргэж болох юм. Олон улсын хуулийн дагуу хэт хатуу шийтгэл ногдуулах нь өөрөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчиж байгаа хэрэг гэж үздэг.

- *Жишээ нь:* НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос 2011 онд гаргасан Ерөнхий тайлбарт дурдахдаа:

Улс орнууд хэт хатуу шийтгэл ногдуулах, мөн их хэмжээний торгууль төлүүлэхээс зайлсхийх талаар санаа тавих хэрэгтэй. Үүний дагуу, улс орнууд шүүгдэгчээс ялсан талд төлөх торгуулийн хэмжээнд үндэслэлтэй хязгаарлалт тавих ёстой.

- Үүгээр нэр төр гутаахтай холбоотой хэргүүдийн хор хохиролыг тооцох тухай нарийвчлан заасан ба олон улсын хуулийн дагуу үүнийг дэмжсэн мэдэгдэлүүд олон байдаг.

- *Жишээ нь:* Хүний ба иргэдийн эрхийн тухай Африкийн Комиссын Зарчим XII-ийн дагуу баталсан Африк дахь Үзэл бодлын эрх чөлөөний талаарх зарчмуудын Тунхаглалд хэсэгчлэн тусгахдаа:

Улс орнууд нэр төр гутаахтай холбоотой хууль батлахдаа дараах хэм хэмжээг баталгаажуулсан байх ёстой ба үүнд:

Оноох шийтгэл нь хэт хатуу бус, бусад заалтыг оролцуулан үзэл бодлоо илэрийлэх эрх чөлөөг хэзээ ч хязгаарлаагүй байх нь зүйтэй.

- *Жишээ нь:* 2000 оны Хамтарсан Тунхаглалын олон улсын тусгай илтгэлд дурдахдаа:

[Иргэний] хуулийн нэр төр гутаасан хэргийн шийтгэл нь үзэл бодлын илэрхийлэлд сөрөг нөлөө үзүүлэхээр дааж давшгүй их байх ёсгүй, гутаагдсан нэр хүндийг сэргээх боломжийг бүрдүүлсэн, зөвхөн зарга мэдүүлэгчид нөхөн төлбөр олгохын тулд хийгдээгүй, торгуулийн хэмжээг учруулсан хохирлын хэмжээтэй уялдуулан нарийн тооцоолсон байх ёстой.

- *Жишээ нь:* Нэгдсэн вант улсад 1995 онд гарсан Толстой Милославскийн хэрэг, Түүнийг нэр төр гутаасан хэргээр буруутгаж, Английн шүүхээс түүнд өмнө нь тавигдаж байсан торгуулийн хэмжээнээс гурав дахин их мөнгийг зарга мэдүүлэгч талд төлөх торгууль ногдуулсан. Европын Хүний Эрхийн Шүүх мэдэгдэхдээ:

“Нэр төр гутаасан үйлдэлд хэт их торгууль ногдуулсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн байна”. Иймээс, нэр төр гутаасан үйлдэлд оноох шийтгэл нь “нэр хүндэд учруулсан хохирлын хэмжээтэй боломжийн хэмжээнд нийцсэн тэнцвэртэй” байх ба үүнийг нэр төр гутаахтай холбоотой

дотоодын хууль тогтоомжид тусгахыг зөвлөсөн. Үүнээс үүдэн Нэгдсэн Вант улс хор хохирол барагдуулахтай холбоотой дүрмэндээ чухал нэмэлт өөрчлөлт оруулсан юм. Ингэснээр давж заалдах шатны шүүхэд хандан хохирлыг тодорхойлохыг зөвшөөрч, хувь хүний нэр төрийг гутаасан хэргийн хохирлын мөнгөн дүнтэй холбоотойгоор ялангуяа шүүгчээс шаардан удирдан чиглүүлснээр, шүүгчийн үнэлсний дагуу хохирлыг барагдуулах болов. Эдгээр өөрчлөлтийн дүнд, Нэгдсэн Вант улсад мөнгөөр барагдуулдаг хохирлын түвшин эрс буурсан байна.

➤ *Нэр төр гутаасан үйлдлийг тодорхойлох нь*, 19 дүгээр зүйлийн зарчимд Ихээхэн хэмжээний хор хохирол учруулж болох “гашуун” нөлөө үзүүлдэгийг харгалзан нэр төр гутаасан үйлдлийн хариуд нөхөн төлбөр олгох асуудлыг олон талаас нь авч үзсэн. 15 дугаар зарчим: Эд материалын нөхөн төлбөрийн талаар мэдэгдэхдээ:

- (а) Нэр төр гутаасан мэдэгдлийн уршгаар учирсан хохирлыг барагдуулахад эд материалын бус арга хэмжээ боломжгүй үед зөвхөн материалын нөхөн төлбөр олгох ёстой.
- (б) Материалын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо, бусад олон зүйлсийн дундаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд үзүүлэх “гашуун” нөлөөг бодолцох ёстой. Материалын нөхөн төлбөр, гарз хохиролын хэмжээтэй дүйцсэн байхаас гадна материалаг бус арга хэмжээ ба иргэний хэргийн буруутай үйлдэлд барагдуулсан нөхөн төлбөрийг мөн харьцуулан авч үзсэн байх ёстой.
- (в) Нэр төр гутаасан үйлдлээс үүдэлтэй санхүүгийн алдагдал эсвэл эд материалын хохирлын нөхөн төлбөрийг гарз хохиролын хэмжээг тусгайлан тогтоосон нөхцөлд зөвхөн олгох ёстой.
- (г) Нэр хүндэд сэв суулгасны төлөө төлж барагдуулах материалаг бус нөхөн төлбөрийн хэмжээ – энэ нь мөнгөөр тооцож болохгүй гарз хохирол бөгөөд–асуудлын хөдөлшгүй сэдэв байх ёстой. Зөвхөн онцгой чухал тохиолдолд энэ сэдвийг хөндөн ярьдаг.
- (д) Нэр хүндэд сэв суулгасны төлөө эд материалын нөхөн төлбөр төлөхдөө тухайн шүүгчдэгч, гомдол гаргасан талд санаатайгаар хор хохирол учруулсан ба мэдэгдэл худал хуурмаг болохыг мэдсээр байж хийсэн зэргийн гомдол гаргасан тал батласан тохиолдолд зөвхөн онц чухал энэ арга хэмжээг авдаг.

➤ Эд материалын нөхөн төлбөр олгохоос гадна ялангуяа материалаг бус хэлбэрээр хохирол барагдуулах ба түвэг чирэгдэл багатай арга хэмжээ авахыг шаарддаг нь гарз хохиролын тэнцвэрийг олохын нэг шалгуур хүчин зүйл юм. Өөр нэг зүйлийг дурдахад, тухайлбал, сайн дураараа эсвэл өөрийгөө хянасны үндсэн дээр аливаа нэгэн арга хэмжээ авсныг шүүх хохирлыг барагдуулахдаа авч үзэх хэрэгтэй. Арга хэмжээ авч учруулсан хохирлынхоо хор уршгийг аль хэдийн багасгасан бол үүнийг аливаа нэгэн материалаг хохирлыг барагдуулахдаа тооцох ёстой.

▪ *Жишээ нь: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай олон улсын тусгай илтгэлийн 2000 онд гаргасан хамтарсан Тунхаглалд “төрөл бүрийн торгууль ногдуулах шийтгэлээс зайлсхийсан хуулийг хэвшүүлж мөрдөх тухай” дурдсан байдаг.*

➤ Нийтлэл бичсэн хүнээр залруулга хийлгэх, ялангуяа хариу няцаалт хийх эрхийг нээлттэй үлдээх нь торгуультай дүйцэхүйц хямд зардалтай, түвэг чирэгдэл багатай, материалаг бус бусад төрлийн шийтгэлийн боломжтой хувилбар гэж ойлгож болох юм. Хүний Эрхийн тухай Америкийн Конвенцийн 14 дүгээр зүйлийн дагуу Улс орнууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан мэдэгдлийн улмаас хохирсон аливаа хүнд хариу няцаалт эрхийг олгох ёстой хэмээн шаарддаг нь маш чухал асуудал юм. Хор уршигтай мэдэгдэлийн эсрэг арга хэмжээ авахад энэхүү заалт бусад аливаа нэгэн хууль зүйн арга хэмжээнээс илүүтэй хувь хүнд

тохиромжтой, хор хохирол, торгууль эсвэл бусад хатуу чанга шийтгэлийг бодвол түвэг багатай хэдий ч, үүнийг практик нөхцөлд хүн бүр хэрэглэж болох арга хэмжээ гэж ойлгож болохгүй юм.

- Дээр дурдсанчлан, нэр төр гутаасан үйлдлийг хэвлэл мэдээллийн өөрийгөө зохицуулах журмаар шийдвэрлэх нь бас нэгэн чухал боломжит хандлага юм.

Хэлэлцүүлэг: Нэр төр гутаасан хэргийн нөхөн төлбөр эсвэл ял шийтгэл Монголд хэтэрхий өндөр байдаг уу? Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд “гашуун” нөлөө үзүүлдэг гэж та боддог уу? Үүнийг хэрхэн болиулах вэ?

- Шүүхийн хянан хэлэлцэх хугацаа буюу түр хориг нь нэр төр гутаах үйлдэлтэй холбоотой бас нэгэн маргаантай асуудал юм. Шүүхээс нийтлэлд нэр төр гутаасан агуулга байгаа эсэхийг хянан хэлэлцэж дуустал тухайн нэр дурдагдсан нийтэл эсвэл цаашид гарах нийтлэлийг хэвлэхийг хориглодог түр хориг юм. Түр хориг – ялангуяа эхний хувилбарын – цаг хугацаанд нь ээлжит дугаараа уншигчдад хүргэдэг сонины хувьд маш их сөрөг үр дагавартай байдаг. Ерөнхийд нь дүгнэж хэлбэл, хянан хэлэлцэх хугацаа буюу түр хориг нь урьдчилсан цагдан хяналтын нэг хэлбэр бөгөөд, эрт дээр үеэсээ байнга л хяналтад орох эрсдэлтэй байсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боогдуулдаг учраас эрс сэрэмжтэй хандах ёстой зүйл юм.
 - *Жишээ нь:* Хүний Эрхийн тухай Америк дундын Конвенци урьдчилсан цагдан хяналтыг тусгайлан хориглодог. Үүнтэй мөн адил, НҮБ-ын Тусгай Илтгэгч урьдчилсан цагдан хяналтыг эрс буруушааж, Бүгд Найрамдах Солонгос улсын талаарх илтгэлд “үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд урьдчилсан цагдан хяналт тавьж буй улс орон хүний эрхийн тухай олон улсын хуулийн заалтыг огт биелүүлэхгүй байгаа” гэж дурджээ.
- Урьдчилсан цагдан хяналтын асуудал нь нэр төр гутаасан хэргүүдийг шийдвэрлэхэд түр хориг болон ерөнхий байдлаараа урьдчилсан цагдан хяналтад нөлөөлж байна.
 - *Жишээ нь:* Ражагодалд болсон хэрг дээр Энэтхэгийн Дээд Шүүх, шоронгийн удирдлага хориглож буй этгээдийн намтрыг сонинд хэвлэгдэхээс өмнө саатуулж чадаагүйг тэмдэглэн: “Төрийн албан хаагчид/ албан тушаалтнууд хэрвээ ямар нэг арга хэмжээ авсан бол, зөвхөн нийтлэл хэвлэгдсэнээс хойш үүсэх ба энд дурдсан зарчмын дагуу шийдвэрлэнэ” гэжээ.
 - *Жишээ нь:* Нэгдсэн Вант улсын шүүх түр хориг тавихын өмнө биелүүлэх ёстой тун өндөр хэм хэмжээ тогтоосон байна. Британийн Боксчдын зэрэглэлийн талаарх тоо баримт сонин, Давж Заалдах шатны шүүх нийтлэл хэвлэхийг зогсоох түр хориг тавих талаар хүсэлт гаргахдаа, зарга мэдүүлэгч нэр төр гутаасан үгсийн талаар “ үндэслэлтэй тайлбар” бичих, “энэ нь ердөө ярианд хэрэглэгдэх үгсийг тайлбарлах эсвэл ижил утгатай үгсийг тайлбарлахтай адил” шаардсан юм. Хэдийгээр энэ өндөр хэм хэмжээг нийтлэл хэвлэгдэхээс өмнө баримтлахад хэцүү байдаг ч, энэ нь шүүгдэгч талд “ тухайн хүний заргалдаж байгаа хэргийг ойлгуулах ” гэсэн шаардлагаас үүдэлтэй ба мөн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг чухлыг таниулах зорилготой.
 - *Жишээ нь:* *Лотодо ба Стар Публишерсийн хэрэг*, Кени улсын Дээд Шүүх шүүгдэгч тал тухайн нийтлэл нэр төр гутаасан агуулгагүй хэмээн маргалдсан, нөгөө талаар, мэргэжлийн давуу

эрхээ эдлэн нийтлүүлсэн гэх зарга мэдүүлэгчийн түр хориг тавих хүсэлтийг хүлээж аваагүй байна. Шүүгч Кхамони түр хориг тавих хүсэлтэд гурван талт шалгуурыг хэрэглэжээ. Үүнд: 1) Зарга мэдүүлэгч өөрийн зөв болхыг нотлох, 2) Зарга мэдүүлэгч нийтлэлээс болж хэрхэн хохирохоо үзүүлэх өөрөөр хэлбэл “хор хохирлыг нөхөн төлбөрөөр барагдуулах аргагүй нөхөж боломгүй гарз хохирол амсахаа” нотлох ба 3) хэрвээ эргэлзээ төрүүлэх бол шүүх “ давуу эрхийн тэнцвэрийг” харах болно гэжээ. Эцэстээ, шүүгч Кхамони гурван талт шалгуурыг үндэслэн, олон нийтийн эрх ашгийн төлөө үг хэлэх эрх, Лотодогийн хувийн ашиг сонирхолоос дээгүүр байх болно гэж үзсэн байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх “түр хориггоос үүдэлтэй хөндлөнгийн аливаа оролцооноос ангид байх ёстой ... үгүй бол энд шударга бус байдал ноёрхох эрсдэл үүсэх ба хувь хүний ашиг сонирхол олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн хэлэлцүүлэгийг зогсооход хүргэнэ”. Шүүгч Кхамони нэр төр гутаахтай холбоотой хэрэг дээр түр хориг тавихыг өөрчилснөөр энэ хэрэг түр хориг тавихтай холбоотой зарга дээр олон нийтийн эрх ашгийг дээдлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрөхөд гол түлхэц болсон юм.

- Байнгын хориг тавих нь хэргийг бүтэн эхээр нь, үнэн зөв хувилбараар нь сонссоны дараа, нэр төр гутаасан хэргийг шүүхээр шийдвэрлэсний дараа шийддэг учраас арай бага маргаан дагуулдаг. Шүүхийн нээлттэй хуралдаанын үйл явц шийдвэр гаргагчдад мэдэгдэлийг цаашид хориглох сэдэл, шалтгааныг мэдэх боломж олгодог. Гэхдээ байнгын хоригийг шаардлагагүй үед үргэлжлүүлэх ёсгүй ба: тухайлбал, энэ нь зөвхөн нэр төр гутаасан агуулгатай болох нь тогтоогдсон нийтлэлд хамаарах ёстой юм.

2. Хууль эрх зүйн тусламж

- 2005 онд Нэгдсэн Вант улсад болсон Стеел ба Моррисийн хэрэг, Түргэн хоолны сүлжээний аварга том компани Макдоналдсыг эрс шүүмжилсэн энэ хэрэг дээр тус компани Британийн шүүх дээр нэр төр гутаасан хэргээр заргалдаж, ялалт байгуулсан юм. Европын Хүний Эрхийн Шүүх томоохон компанитай холбоотой нэр төр гутаасан хэргийн талаарх дүрмийг баримтлан энэ хэргийн талаар тэмдэглэхдээ:

Зарга мэдүүлэгч хийсэн мэдэгдэлийнхээ үнэн бодитыг нотлох шаардлага тавих эсвэл зарчмын хувьд нэр төр гутаасан мэдэгдэлийн эсрэг өөрийгөө хамгаалах эрхээс татгалзах ёстой үндэстэн дамнасан том компаниуд энэ хэрэг дээр зарга мэдүүлсэн тул Шүүх баримтыг авч хэлэлцэхгүй.

- Гэхдээ, боломжтой бол ийм төрлийн арга хэмжээ авах, эдгээр томоохон компаниудын үйл ажиллагааны талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах орон зайг хамгаалах шаардлага байна. Нэгдсэн Вант Улсын нэр төр гутаахтай холбоотой хуулийн цоорхойг харгалзан үзвэл, эндээс Улс орнууд зарга мэдүүлэгч нарт хууль эрх зүйн үр дүнтэй тусламж үзүүлэх шаардлага байгаа нь харагдаж байгаа юм. Тухайлбал:

Хэрвээ, хэдийгээр, Төр томоохон корпорацид ийм төрлийн арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлж өгөхөөр шийдсэн бол, үзэл бодлоо илэрхийлэх эрх ба нээлттэй мэтгэлцээн явуулах ашиг сонирхолыг хангах үүднээс маргалдаж байгаа талуудад тэгш ба шударга нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авах нь

зайлшгүй чухал... Маргалдагч талуудын харилцан адилгүй байдал ба зарга мэдүүлэгч талд тулгарч буй хүндрэлийг тооцон 10 дугаар зүйлийн дагуу тэнцвэртэй байдлыг алдагдуулахгүй хадгалах нь мөн чухал.... Энэ хэргийн үйл явцад тэгш байдал ба шударга ёс дутагдалтай байгаа нь 10 зүйлийн заалтыг зөрчих нөхцөл үүсгэж байна.

3. Нэр төр гутаасан үйлдлийг өмгөөлөх нь

- Шаардлага тулгарсан үед, нэр төр гутаасан хэргийн буруутныг хэрхэн өмгөөлөх нь нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай, эдгээр хэргүүд нь олон талтай учраас хэргийг тогтсон томъёололоор шийдэх боломжгүй. Гэхдээ уг асуудлыг шийдэхэд дагаж мөрдөх хэд хэдэн зөвлөмж бас байдаг.
- Нэгдүеэр асуудал нь зарга мэдүүлэгчийн гаргасан гомдол үндэслэлтэй эсэхийг тодруулах өөрөөр хэлбэл, зарга мэдүүлэгчийн хэлж байгааг үнэхээр нэр төр гутаасан агуулгатай мэдээлэл мөн эсэхийг нягтлах хэрэгтэй. Шүүгдэгч мэдээлэл яагаад тааламжгүй байгаагийн учрыг зарга мэдүүлэгчээс тодруулах, улмаар энэ нь нэр төр гутаахаас өөр ангид утга агуулсан гэдгийг хэлж болно. Үүнтэй холбоотой хэд хэдэн асуудлууд байдаг.
 - Үүнд: шүүгдэгчийн тараасан мэдээлэл нь зарга мэдүүлэгчийн хэлж байгаа санааг агуулаагүй, жишээ нь, шүүгдэгчийн тараасан мэдээллийг учир ойлгох бусад хүмүүс егөөдөл, хошигнол гэж ойлгосон хэмээн эсэргүүцэх, эсвэл зарга мэдүүлэгчийн ойлгосноос өөр утгатай, үг өөрөө салаа утгатай байдаг учраас ихэнх тохиолдолд буруу ойлголцох явдал гардаг гэх мэт.
 - Шүүгдэгч нь мөн зарга мэдүүлэгч талд алдах нэр хүнд байгаагүй хэмээн эсэргүүцэх, тухайлбал хаа яваа газраа худлаа ярьж явдаг хүнийг худалч гэж хэлсний төлөө тухайн хүний нэрд сэв суулгасан гэж үзэх аргагүй
 - Шүүгдэгч мөн тараасан мэдээлэлд нэр төр гутаасан асуулга байгаагүй хэмээн эсэргүүцэж болно.
 - *Жишээ нь:* Тайландад гарсан хэргийн тухайд, эхэндээ Ерөнхий сайдын өмчид байсан биенесийг дараа нь эхнэр болон бусад хамаатнууд нь эзэмшиж улмаар Ерөнхий сайдын ивээл дор улам их ашиг олсон тухай мэдээлэл тараасан хүнийг шүүхэд өгсөн. Гэхдээ Ерөнхий сайд биш харин нэр дурдагдсан компани нь заргалдсан. Шүүгдэгч компанийн нэр хүнд гэдэг нь бизнесийн нэр хүнд учраас (мөнгө олох чадвартай холбоотой) Ерөнхий сайдын гар хөл болсон тухай мэдээлэл харин ч компанид ашигтай байсан хэмээн эсэргүүцсэн. Нэр төр гутаасан асуудал Ерөнхий сайдтай холбоотой учраас тэрээр өөрөө зарга үүсгэсэн бол байдал өөрөөр эргэх байлаа.
- Өмгөөлөгч мөн хэргийг өөр тийш нь залж болох бүх үндэслэлийг харгалзах хэрэгтэй. Төрийн байгууллага зарга мэдүүлсэн бол яахав? Шүүгдэгч үнэхээр тэр мэдээллийг хийснийг баталсан юм уу? Олны өмнө хэлсэн эсэх?
- Дараагийн асуудал бол асуудал бол шүүгдэгч өмгөөлөх аргад найдах явдал юм. Хамгийн боломжтой нийтлэг өмгөөлөх арга бол үнэнийг хамгаалах байдаг. Дахин хэлэхэд, үүнд ялгаатай асуудал бий. Тухайлбал:
 - Шүүгдэгч хэлсэн бүх зүйл нь үнэн гэдгийг батлах албагүй, зөвхөн нэр төр гутаасан асуудлыг л авч үзэх хэрэгтэй. Шүүгдэгчийн бичсэн түүх ор үндэсгүй байлаа ч зарга мэдүүлэгчийн нэр хүндэд халдсан мэдээлэл гутаасан агуулгагүй байж болох талтай.

- Төрийн ашиг сонирхол хөндөгдсөн мэдээлэл бүхий хэргийн тухайд ялангуяа зарга мэдүүлэгч нь нотлох баримт бүрдүүлэх боломжтой нөхцөлд байгаа бол мэдээлэл хуурмаг болохыг батлахыг шаардах
- Хэрвээ мэдээлэл бодитой үнэн бол батлахад амар. Жишээ нь шүүгдэгч 10000 ам.долларын бизнесийн гүйлгээ хийнэ гэсэн зарга мэдүүлэгчийг худалч хэмээн мэдэгдсэн бол нэр төр гутаасан хэргийн гол учиг нь зарга мэдүүлэгчийн худалч болохыг батлахад оршино. Зарга мэдүүлэгч нь хэрэг дээрээ худал хэлсэн байж болно. 8000 ам.долларын гүйлгээ хийсэн гэж ярьсан хүн (үнэн хэрэгтээ зөвхөн 5000 ам.доллар шилжүүлсэн) байвал үндсэн мэдэгдэл нь өөрөө эргээд зарга мэдүүлэгчийн хэлсэн үгийн бодитой эсэхэд эргэлзэхэд хүргэдэг.
- Өмгөөлөлийн өөр нэг арга нь мэдээлэл бодит байдлыг хөндөөгүй зөвхөн үзэл бодлын илэрхийлэл байсныг батлах юм. Нөхцөл байдал бүрхэг үед шүүхээс мэдээллийг үзэл бодлын илэрхийлэл гэж үзэх хандлага давамгайлдаг. Өмгөөлөгч бүх нөхцөл байдлыг харгалзан үзэж үүн дотроо тараасан мэдээлэл нь хошигносон, ёжлосон утгатай эсвэл утга зохиолын өөр хэлбэр ашигласан, утга шилжсэн үг, зүйрлэл ч байж болох талтайг нотлон харуулж болох юм.
 - *Жишээ нь:* 2001 онд Словакийн Фелдект гарсан хэрэг. Европын Хүний Эрхийн Комисс зарга мэдүүлэгчийн гаргасан гомдолд “ фашистын үлдэгдэл” гэсэн үг нь тухайн хүнийг фашист үзлийг сурталчилсан үйл ажиллагаанд оролцдог хэмээн доромжилсон гэж үзсэнтэй санал нийлээгүй. Үүнийг тухайн хэллэг нь түгээмэл хэрэглэгддэг, өөр утга агуулж байж болох талтайг тайлбарласан.
- Үндэслэлтэй нийтлэлийг өмгөөлөх нь тухайн нөхцөл байдлаас хамааралтай өмгөөллийн нэг биеэ даасан хэлбэр бөгөөд дээр дурдсан хэм хэмжээ үүнийг тодорхойлдог.

Нэр төр гутаахтай холбоотой лавлагаа

1. Toby Mendel, Putting Expression Behind Bars: Criminal Defamation and Freedom of Expression (London: ARTICLE 19, 2004). Available at: <https://www.article19.org/data/files/pdfs/conferences/criminal-def-eu-ngo-paper.pdf>.
2. Joint Declaration of the UN Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the OSCE Representative on Freedom of the Media and the OAS Special Rapporteur on Freedom of Expression of 30 November 2000. Available at: <http://www.unhchr.ch/hurricane/hurricane.nsf/view01/EFE58839B169CC09C12569AB002D02C0?opendocument>
3. Article 19, *Defining Defamation: Principles on Freedom of Expression and the Protection of Reputation* (London: ARTICLE 19, 2000). Available at: <http://www.article19.org/pdfs/standards/definingdefamation.pdf>
4. Defamation ABC: A Simple Introduction to Key Concepts of Defamation Law (London: ARTICLE 19, 2006). Available at: <http://www.article19.org/pdfs/tools/defamation-abc.pdf>
5. A. Jay Wagner and Anthony L. Fargo, Criminal Libel in the United States A Report for the International Press Institute. Available at:

http://www.freemedia.at/fileadmin/resources/application/IPI_Criminal_Libel_in_the_US.pdf.

6. Clive Walker, "Reforming the Crime of Libel" 50 N. Y. L. Sch. L. Rev. 169 2005-2006. Available at: <http://www.nylslawreview.com/wp-content/uploads/sites/16/2013/11/50-1.Walker.pdf>.
7. Monica Macovei, *Freedom of Expression: A Guide to the Interpretation and Meaning of Article 10 of the European Convention on Human Rights* (Strasbourg: Council of Europe, 2001). Available at: http://www.coe.org.rs/REPOSITORY/132_freedom-of-expression_1_1.pdf.
8. Elena Yanchukova, "Criminal Defamation and Insult Laws: An Infringement on the Freedom of Expression in European and Post-Communist Jurisdictions" 41 Colum. J. Transnat'l L. 861 2002-2003.

Модуль 5: Интернэтийн зохицуулалт

- Олон улсын хуулийн дагуу интернэтэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бусад мэдээллийн хэрэгслийн нэгэн адил хэрэгжих нь тодорхой.
- Харин интернэтийн хүртээмж нь хүний эрх мөн эсэх нь тодорхойгүй бөгөөд өнөөг хүртэл маргаан дагуулдаг. Энэ асуудал интернэтийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, бусад эрхийг эдлэх боломж олгодогтой холбоотой.
- Эдгээр бусад хүний эрхийг эдлэх боломж олгох интернэтийн үүрэг роль нь түүний нийгмийн хэрэгсэл болох түгээмэл шинж чанарыг тусгал юм. Интернэт нь худалдаа наймаа хийх, танилцах, харилцаа холбоо тогтоох, соёл, зугаа цэнгээний арга хэмжээ зохион байгуулах, түүнд оролцох, албан, албан бус боловсрол эзэмших, улс төрийн мэтгэлцээн хийх, оюун санаа, шашины үйл ажиллагаа явуулах, эрүүл мэндийн зөвлөгөө авах, бараг бүх чиглэлээр мэргэжил дээшлүүлэх боломж бүхий үндсэн талбар болж байна. Говчоор хэлбэл, дийлэнх хүмүүсийн өдөр тутмын амьдралын бүхий л талыг өөрчилж чадсан.
- Мэдээлэл харилцааны бусад шинэ технологийн нэгэн адил, сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн нэгэн адил, мэдээллийн энэ шинэ хэрэгслийг хэрхэн зохицуулах тухай олон хүн асуудаг.
- Интернэтийг хүүхэд оролцсон садар самуун сурталчилгаа үйлдэх гэх мэт хор уршигтай, хууль бус үйлдэл хийхэд ашиглах боломжтой гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэсэн хэдий ч сонин хэвлэл, өргөн нэвтрүүлэгт баримтлах журам, зохицуулалтыг интернэтэд хэрэглэх нь төдийлэн үр дүнд хүрэхгүй.
- Интернэтийн зохицуулалтын асуудал нь хэд хэдэн шинэ, төвөгтэй асуудлыг дагуулж байна. Жишээлбэл, интернэтэд нэрээ нууцлахын мөн чанар, онлайн нээлттэй хэлэлцүүлэгт нэрээ нууцлахын ач холбогдлыг харгалзан, хэт залхаахуйц хяналтын механизм нь үзэл бодлоо онлайн илэрхийлэхийн мөн чанар, нээлттэй байдлыг бууруулах замаар интернэтээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчихөд хүргэдэг. Интернэтийн бүх нийтийг хамрах шинж чанар нь шүүх эрх мэдлийн асуудалд хүндрэл учруулж байна. Мөн интернэтээр мэдээлэл солилцох амар хялбар байдал нь оюуны өмчийн талаарх уламжлалт хандлагад бэрхшээл дагуулж байна. Интернэт бусад хэрэгслээс ялгаатай нь бараг аль газраас хэн ч ашиглах боломжтой. Хэвлэлийн эрх чөлөө нь зөвхөн хэвлэл мэдээллийнхэнд л хамаатай асуудал гэдэг үзэл өдгөө тохирохгүй. Мэтгэлцээний ардчилсан, шинэ орон зай (олон нийтийн виртуал бодит талбай)-г дэмжих интернэтийн боломж үүнтэй нягт холбоотой. Ардчилсан нийгэмд эдгээр орон зайг хадгалахын чухал нь тэдгээрийн ажиллах боломжийг таслан зогсооход хүргэж болзошгүй зохицуулалтуудад анхаарал хандуулах нь зүйтэй.

Discussion: Интернэтийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хөдөлгөгч хүч болохынх нь хувьд Та хэрхэн ойлгож байна? Интернэт олон асуудал бэрхшээл дагуулдаг гэж бодож байна уу? Үүнд илүү их хяналт тавих шаардлагатай гэж үзэж байна уу?

1. Интернэтийн бүтцийн зохицуулалт

- Арга хэрэгсэл болохын хувьд интернэт нь эрх зүй, шүүн таслах эрхийн уламжлалт үзэл баримтлалтай нийцэх нь тааруу. Дэлхийн нэг өнцөгөөс нөгөө рүү мэдээллийг хормын төдийд түгээх боломжинд интернэтийн хил хязгааргүй

шинж чанар оришино. Харилцаа холбооны бусад хэлбэрээс ялгаатай нь интернэт жинхэнэ утгаараа бүх нийтийг хамарч чаддаг. Интернэт нь хуулинд захирагддаггүй, зохицуулалтгүй талбар байх ёсгүйн зэрэгцээ түүний хөгжлийн чухал зүйл бол олон улсын шинж чанарыг нь ханган, хадгалахын тулд зохицуулалтыг түүнд нийцүүлэх шаардлагатай.

- Улс орнуудын соёлын ялгаатай байдал өмнө нь аливаа нэгэн асуудалд хандах хандлагын зөрүүтэй байдлыг зөвтгөж болох байсан бол, интернэтийн бүх нийтийг хамарсан, нэгдмэл шинж нь үндэсний хэмжээнд зохицуулалт хийх оролдлого ихэнхдээ хор уршигтай бөгөөд үр нөлөөгүй гэсэн үг. Эдгээр зохицуулалтын үр нөлөөгүй байхын учир нь интернэт шүүх эрх мэдлийн талаарх уламжлалт ойлголтын хил хязгаараас давдаг. Аливаа улс ямар нэгэн тодорхой тогтсон дэг жаягийн эсрэг эрс арга хэмжээ авах оролдлого ихэнхдээ эсэргүүцэлтэй тулгардаг. Гэсэн хэдий ч эдгээр оролдлогууд интернэтийн эрх чөлөөнд халтай. Учир нь эрх зүйн таагүй орчин бүрдүүлж, хэн нэгний техникийн ур чадварын түвшнээс шалтгаалан ялгаатай стандарт бий болоход хүргэж болзошгүй. Зарчмын хувьд, нутаг дэвсгэрийн хувьд мөрдөх стандарт нь хил хязгааргүй онлайн ертөнцөд тохиромжгүй бөгөөд интернэтийн хөгжилд бүхэлдээ муугаар нөлөөлнө.
- Интернэтийг дэлхийн болон үндэсний гэсэн хоёр түвшинд зохицуулдаг. Дэлхийн хэмжээнд интернэтийг зохицуулах, тухайлбал ямар нэгэн саадгүй ажиллуулах зэрэг, шаардлага бий. Ихэнх улс орнууд интернэтийг үндэсний хэмжээнд янз бүрийн шалтгааны улмаас зохицуулах оролдлого хийж байна.

Олон улсын зохицуулалт

- Олон улсын хэмжээнд дээд түвшний домэйн (ДТД) нэр, өөрөөр хэлбэл улсын код, ерөнхий код (.com, .org г.м.), тоон код болон интернэтийг ачаалуулдаг техникийн протокол зэрэг үйлдлийн олон объектоор зохицуулахыг зөвтгөнө.
- Ихэнх интернэт хаяг, домэйн нэрийг Калифорнид байрлах ашгийн төлөө бус Олон улсын нэр, хаягийн байгууллага (ICANN)-аас олгодог. Энэ талаар нэлээн маргаан өрнөдөг. Тухайлбал, НҮБ-ын Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалт (WSIS)-ийн үеэр бий болсон төр, иргэний нийгэм болон бизнесийн Интернэтийн засаглалын форум (IGF)-аас шүүмжлэл өрнөж байв.
- Чухал ач холбогдол бүхий нөөц болох интернэтийг аль нэг улсад байрлалтай ашгийн төлөө бус байгууллага ачааллуулах нь зүйтэй юу, эсвэл НҮБ, жишээлбэл Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) буюу UNESCO хяналтдаа авах ёстой юу гэдэг асуудал нэлээн маргаан дагуулж байна. НҮБ интернэтийг хяналтандаа авах асуудал нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжигчдийн олонхийн санааг зовоож байна.
- Олон улсын хэмжээнд ихэнхдээ техникийн шинж чанартай зохицуулалтууд хийж байна. Гэсэн хэдий ч, энэ нь хэрэглэгчдэд хамаатай чухал зүйл. Зарим тохиолдолд, аливаа шийдвэр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд шууд нөлөөлдөг. Жишээлбэл, хэдэн жилийн өмнө порнографт зориулсан ххх ДТД нэр үүсгэх тухай кино гарсан байдаг. Үүнийг дэмжигчид интернэтэд аль хэдийн өргөн тархсан порнографт тусгайлан зориулагдсан талбартай болж, үзэхийг үл хүсэгчид тус домэйны орон зайнд нэвтрэхээс татгалзах боломжтой хэмээн маргаж байв. Зарим нэг нь порнографт зориулсан ДТД нэрийг ямар нэгэн байдлаар зөвтгөсний үндсэн дээр дэмжиж болох юм хэмээн эсэргүүцэж байв. Эцэст нь уг ДТД-ийг үүсгээгүй.

Хэлэлцүүлэг: Дээрх асуудлын талаар та юу гэж бодож байна? Интернэтийн ардчилсан менежментийн хэрэгцээ шаардлага болон дэлхий нийтийн энэхүү нөөцөд ардчилсан бус орнууд нөлөөлөхөөс сэргийлэх хэрэгцээ шаардлагын тэнцвэрт байдлыг бид хэрхэн хадгалах вэ?

Сүлжээний төвийг сахисан байдал

- Сүлжээний төвийг сахисан байдал нь дэлхийн хэмжээнд өргөн хүрээний маргаан дагуулдаг интернэтийн зохицуулалтын гол асуудал юм. Өндөр чанарын бичлэг цацах, том хэмжээтэй файл татаж авах зэргээр интернэтийн эрчимт шугамыг ачаалах нь үйлчилгээ үзүүлэгчдийн бололцоог хэт ачаалж, нийт хэрэглэгчдэд хүрэх интернэтийн хурдыг багасгаж байна гэсэн гомдлоос сүлжээний төвийг сахисан байдлыг тойрсон маргаан үүдэлтэй. Мөн чанартаа, энэ нь үндэсний болон олон улсын цар хүрээ бүхий интернэтээр дамжуулж буй урсгалын тухай асуудал юм.
- Интернэтийн эрх чөлөөг хамгаалагчид сүлжээний төвийг сахисан байдлын үзэл санааг дэмжих хандлагатай. Тусгай мандат бүхий илтгэгч, төлөөлөгчдийн 2011 онд гаргасан хамтарсан тунхаглалд зааснаар:

Тоног төхөөрөмж, контент, зохиогч, гарал үүсэл, контентын байршил, үйлчилгээ болоод хэрэглээнд үндэслэн интернэтийн өгөгдөл, урсгалын хандлагад ялгаварлан гадуурхалт байх ёсгүй.

- Гэсэн хэдий ч, интернэтийн ажиллагааг удирддаг техникийн протоколууд нь өгөгдлийн зарим хэлбэр, ялангуяа урсгалын удирдлагын талаас, хэдийнээ дараалал тогтоосон. (гэрлэн дохио нь ачаалалтай замын хөдөлгөөнд давуу эрх олгохтой ижил)
- Эргэлзээ бүхий энэ бөөгнөрөлийг шийдэх сонирхол татахуйц шийдлүүдийг дэвшүүлсэн. Үүнд өгөгдлийн багцын туулах зайнаас хамаарч хураамж тогтоох, шугамын том хэрэглэгчдийн тоог бууруулах, мөн түүнчлэн, хамгийн маргаантай нь хэрэглэгчид өгөгдөлдөө давуу эрх авахын тулд хураамж төлдөг “олон үет” интернэтийг бий болгох зэрэг шийдлүүд багтана. Эдгээр саналыг интернэтийн бүх урсгалд ялгаварлан гадуурхалгүй хандах сүлжээний төвийг сахисан байдлын зарчмын эсрэг хэмээн шүүмжилж байна.
- Улс орнууд зохицуулалтын энэ асуудалд янз бүрээр хандаж байна.
 - *Жишээ:* 2010 оны 7-р сард Чили улс сүлжээний төвийг сахисан байдлыг хуулиар баталгаажуулсан анхны орон болсон. 2010 оны 6-аас 9-р сарын хооронд Европын Холбоо сүлжээний төвийг сахисан байдлын зохицуулалтын асуудлаар олон нийтийн зөвлөгөөн зохион байгуулсан. Гэвч интернэтийг чөлөөтэй, нээлттэй хэвээр хадгалахын тулд ил тод байдал, хэвлэл мэдээллийн хяналт байхад хангалттай хэмээн тогтоосноор энэ асуудлыг хуульчлахын эсрэг шийдвэр гаргасан.
 - *Жишээ:* Сүлжээний төвийг сахисан байдлын талаар АНУ-д улс төрийн маргаан үргэлжилсээр байна. Өдгөө уг асуудлыг Харилцаа холбооны хорооны (FCC) Нээлттэй интернэтийн журам зохицуулж байна. Тус журам нь сүлжээний менежментийн үйл ажиллагаанд ил тод байдлыг сахих, хууль ёсны контентод хаалт тавихыг хориглох, хууль ёсны контентыг “үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхах”-ыг хориглох (зохистой сүлжээний менежментээс гадуур авч үзэх ялгаа зааг хэмээн тодорхойлогддог) гэсэн үндсэн 3 дүрэмтэй. Үүний нарийн утга нь тодорхойгүй боловч Журмын тайлбарт бөөгнөрлийг сулруулах, багасгах урсгалын зарим менежментийг зөвтгөж болох ч,

ялангуяа, том хэрэглэгчдийн бусдыг хавчих, өргөнөөр хязгаарлах арга хэмжээ авах, хөтөлбөр төлөвлөгөөний тэргүүн дарааллыг зөвшөөрөхгүй.

- Үүний зохицуулалтын төгс томъёолол нь интернэтийн хүртээмжтэй байдал бол хүний эрх бөгөөд үр дүнд хамгийн шилдэг, боломжтой хүртээмжийг бий болгох загвар батлах шаардлагатай гэсэн үзэл санааг анхаарах шаардлагатай. Олон үет интернэтийг дэмжигчдийн үзэж буйгаар, үйлчилгээ үзүүлэгчдийн ашгийг нэмэгдүүлэх нь эргээд нийт хэрэглэгчдийг илүү хурдан интернэтээр хангахад зарцуулагдах цаашдын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэхэд чухал шаардлагатай. Уг санааг бусад саналын хамт шалган тогтоох нь зүйтэй. Интернэт хүний эрх болохынх хувьд нь онлайн ертөнцөөс орлого багатай хэсгийг шахан зайлуулах, холболтын хурдыг багасгах, хөдөөний болон ядуусын хэрэглээг бууруулахад хүргэх аливаа зохицуулалтаас татгалзах нь зүйтэй.
- Интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид (ISP) төрөл бүрийн үйлчилгээг янз бүрийн үнээр санал болгож, илүү төлсөн хэрэглэгчдэд урсгалын давуу байдал ологодог нь ихэнх улсад хэдийнээ бодит байдал болжээ. Ихэнх үйлчилгээ үзүүлэгчид илүү хурдан холболт буюу илүү өгөгдлийг боломжтой болгох холболтын төлөө үнээ өсгөдөг.
- Тусгай мандат бүхий илтгэгч, төлөөлөгчдийн 2011 онд гаргасан хамтарсан тунхаглалд:

Интернэтэд дамжуулагчийн үүрэг гүйцэтгэгч нь аливаа урсгал, мэдээллийн менежментийн үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангаж, уг үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг бүхий л оролцогч талуудад хүртээмжтэй байдлаар ил тодорхой болговол зохино.

Хэлэлцүүлэг: Интернэтийн бүтцийн ямар нэгэн зохицуулалт байх шаардлагатай гэж Та бодож байна уу? Ямар зорилгоор? Үүнийг хэрхэн боловсруулж болох вэ?

Үндэсний зохицуулалт

- Интернэт дэх үндэсний зохицуулалт шаардсан хэд хэдэн талбар бий. Жишээлбэл, үндэсний домэйн нэр олгох. Нөгөө талаар энэ нь шаардагдахуйц хэмжээнээс хальдаг.

Домэйн нэр

- Улс орон бүр улсын код бүхий дээд түвшний домэйн нэр (ccTLD буюу ДТД) олгож, үүнийг удирдах үүрэг хариуцлага хүлээдэг. Монголын хувьд .mn домэйн нэр байна. Олон улсын эрх зүйн үндсэн зарчмын дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нөлөөлөх бүх зохицуулалтыг хараат бус байгууллага хийх ёстой. Энэ нь улсын домэйн нэр олгох үйл ажиллагаанд мөн хамаарна.
- Сайн туршлага нь улсын домэйн нэр олгох ажлыг ашгийн бус буюу засгийн газраас хараат бус байгууллагад хариуцуулах. Ихэнх оронд, эсрэгээрээ, домэйн нэрийн зохицуулалтыг засгийн газрын яам, засгийн газрын бусад байгууллага хийж байна.
- Энэ нь маш харалган үйлдэл бөгөөд үндэсний домэйн нэрийн хөгжилд саад тотгор болсноор сөрөг үр дагавартай. Жишээлбэл, улсын домэйн нэрийн талбарт хайлт хийхэд хялбар болгох үүднээс контентийг үндэсний хэл дээр төвлөрүүлэх нь ашигтай. Энэ нь ялангуяа Монгол шиг улс оронд чухал.
- Интернэтийн нээлттэй шинж нь улс орнууд түүнд домэйн нэрийн дагуу хяналт тавих боломжгүй гэсэн үг. Улсын код бүхий дээд түвшний домэйн ccTLD нэр

авахад хүндрэлтэй тулгарсан хэн боловч .com буюу .org олон улсын домэйн нэр авах боломжтой. Гиймээс домэйн нэрийн хяналтын урт хугацааны үр дагавар нь хэрэглэгчдийг ДТД-ээс татгалзахад хүргэнэ. Мөн түүнчлэн, ДТД нэр олгоход өндөр хэмжээний хураамж тогтоох нь үүний адил үр дүнд хүрнэ. (олон улсын домэйн нэрийг жилийн 10 орчим ам.долларын хураамж төлөн, авч болно)

Хэлэлцүүлэг: Монголд домэйн нэрийг хэрхэн олгодог вэ? Энэ систем хэр ажиллаж байна? Эсвэл ихэнх монголчууд .org буюу .com гэх мэт бусад домэйн нэр ашиглахыг илүүд үзэж байна уу?

Үндэсний бүтцийн зохицуулалтын бусад асуудлууд

- Зарим хүмүүс интернэтэд өргөн нэвтрүүлгийн нэгэн адил (зарим улс оронд сонин хэвлэл) тусгай зөвшөөрөл олгох нь зүйтэй гэж үздэг. Ингэх олон арга байна. Зарим оронд бие даасан цахим хуудас эсвэл тодорхой төрлийн цахим хуудсанд (жишээлбэл, мэдээний) лиценз олгох арга зам эрэлхийлж байна.
 - *Жишээ:* 2012 онд Йордан улс сонин хэвлэлийн нэгэн адил мэдээний бүх төрлийн цахим хуудсыг үйл ажиллагаа явуулахын тулд тусгай зөвшөөрөл авахыг шаардсан шинэ хууль баталсан. Уг тогтолцоо нь асар их бэрхшээл дагуулсан. Нэгдүгээрт, мэдээний цахим хуудасны тодорхойлолт ойлгомжгүй байсан. Хоёрдугаарт, ихэнх ийм төрлийн цахим хуудасны зүгээс уг арга хэмжээг байж боломгүй хянах оролдлого хэмээн үзээд бүртгэлд хамрагдахаас татгалзсан. Үүний хариуд засгийн газраас 200 орчим цахим хуудсыг хаасан байна. Зарим нэг нь хилийн чанадаас үйл ажиллагаагаа явуулсан боловч ийм арга хэрэглэхийн гол үр нөлөө нь улс оронд онлайн мэдээний эх сурвалжийн хөгжилд саад болох, ардчилал болон олон нийтийн эрх ашгийн асуудлын талаарх нээлттэй мэтгэлцээнд хор уршиг үзүүлэх үр дагавартай.
- Бусад улс оронд интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдээс сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн нэгэн адил тусгай бүртгэлд хамрагдахыг шаарддаг. Олон улсын хэм хэмжээгээр интернэт нь аливаа бусад мэдээллийн хэрэгслээс бүрэн ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд бусад системд тохируулагдсан зохицуулалтыг үүнд мөрдөх боломжгүй. Тусгай мандат бүхий илтгэгч, төлөөлөгчдийн 2011 онд гаргасан хамтарсан тунхаглалд:

Утсан харилцаа, өргөн нэвтрүүлэг зэрэг харилцаа холбооны бусад арга хэрэгсэлд зориулан боловсруулсан зохицуулалтыг интернэтийн зохицуулалтад шууд нэвтрүүлж болохгүй бөгөөд тусгайлан тохируулах хэрэгтэй.
- Олон улсын хуулийн дагуу, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний аливаа хязгаарлалт зөвтгөгдсөн байх ёстой. Жишээлбэл, өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох асуудлыг давтамжийн хэмжээ хязгаартай тул өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх хүсэлтэй хүмүүсийн зөвхөн цөөн хэсэгт олгох боломжтойгоор тайлбарлана. Интернэтэд дээрх асуудал тулгарахгүй бөгөөд түүний тусгай зөвшөөрлийн асуудал нь зөвтгөгдөх боломжгүй. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдээс бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл авахыг шаардах зэргээр тэднийг зохицуулах асуудал нь хууль бус хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн. Ардчилал хөгжсөн улс оронд, интернэтээр, тухайлбал цахим хуудсаар дамжуулан мэдээ түгээх нь ямар ч хэлбэрийн зохицуулалтад захирагдах ёсгүй.

2. Зохиогчийн эрх болон оюуны өмч

- Зохицуулалтын хамгийн их маргаантай асуудлын дунд онлайн оюуны өмчийн хамгаалалтыг тойрсон асуудал байдаг. Оюуны өмчийн эрхийг эзэмшигчид нь эрхээ хамгаалуулах хууль ёсны ашиг сонирхолтой байвч хэд хэдэн улс оронд онлайнд зохиогчийн эрх зөрчих асуудалд хэт хатуу хандсан хууль тогтоомж батлах буюу хэлэлцүүлгийн үе шатандаа явж байна.
- Онлайн дахь зохиогчийн эрхийн зөрчлийг зохицуулахад АНУ-ын Мянганы цахим зохиогчийн эрхийн тухай хууль буюу Digital Millennium Copyright Act (DMCA), мөн Европын холбооноос баталсан Электрон худалдааны директивд заасанчлан “мэдэгдэх болон устгах” (“notice and takedown”) тухай заалтын дагуу зохицуулах хандлага давамгайлж байна. Мөн чанарын хувьд, мэдэгдэх болон устгах систем нь мэдэгдэл хүлээн авмагц контентийг шуурхай устгах ажиллагаа явуулдаг тул контентийг хост дээрээ байрлуулагчдыг хэрэглэгчдийн зүгээс гаргасан зохиогчийн эрхийн зөрчлийн төлөө ноогдуулах хариуцлагаас чөлөөлдөг. Практик талаас авч үзвэл, DMCA-ын процедур нь зохиогчийн эрхийг эзэмшигч нь өөрийн мэдээ материалыг интернэтэд байрлуулсныг олж тогтоосон нөхцөлд контентийг хост дээрээ байрлуулагчид мэдэгдэх, ингэхдээ, мэдээ материалыг хэрхэн олж, тодорхойлох талаарх мэдээлэл, уг бүтээлийг ашиглах эрх зүйн үндэслэлгүй гэдгийг тодорхойлох, мөн түүнчлэн гомдол гаргагч нь зохиогчийн эрхийг эзэмшигч буюу түүний өмнөөс ажиллах итгэмжлэл хүлээсэн этгээд болохыг тодорхойлно. Үүний дараа хостын зүгээс тухайн контентийг устгаж, зөрчил үйлдэгч этгээдэд мэдэгдэл хүргүүлнэ.
- “Мэдэгдэх болон устгах” систем нь контентийг хост дээрээ байрлуулагч зохиогчийн эрхийн талаарх гомдлын дагуу аливаа шүүн таслах ажиллагаагүйгээр хариуцлага хүлээлгэж буй нь шүүмжлэл дагуулж байна. Контентийг хост дээрээ байрлуулагчид нь ихэвчлэн зохиогчийн эрхийн шаардлага нь хууль ёсны эсэх, асуудал дагуулсан материал нь зохиогчийн эрхийн асуудлаас гадуур эсэх зэргийг нягтлан шалгадаггүй. Учир нь тэдний хамгаалагдсан байдал гүйцэтгэлийн хурдаас хамаарах бөгөөд тэд аливаа хариуцлага өөр дээрээ үүрэх эрсдэл хүлээхийг хүсдэггүй. Эрх зүйн талаасаа, тэдний хувьд хүлээн авсан аливаа мэдэгдлийг дагах нь аюул багатай. DMCA-ын дагуу худал мэдэгдлийн эсрэг механизм үйлчилдэг. Үүний үр дүнд сэжиг бүхий зөрчигч контентийг хост дээрээ байрлуулагчид асуудал дагуулсан материал устгахыг эсэргүүцэх тухай саналаа хүргүүлэх, мөн тэдний зөвшөөрөлтэйгээр шүүхийн зохих байгууллагаар асуудлаа шийдүүлэх боломжтой. Зохиогчийн эрхийг эзэмшигч нь сөрөг мэдэгдэлд 14 хоногийн дотор зохиогчийн эрх зөрчсөний төлөө шүүхэд хандаж, хариу үйлдэл үзүүлээгүй бол интернэтийн үйлчилгээ үзүүлэгчээс материалыг буцаан сэргээхийг шаардана.
- Эдгээр хамгаалалтыг үл харгалзан, DMCA-ын зүйл заалтыг урвуулан ашиглаж байна.
 - *Жишээ:* 2008 онд Саентологийн сүмийг төлөөлсөн нэгэн байгууллага саентологийн талаар шүүмжилсэн 12 цаг үргэлжлэх бичлэгийг устгах тухай мэдэгдлийг YouTube компанид 4000 гаруй удаагийн давтамжтайгаар гаргасан байна. Ихэнх хэрэглэгчид хариуд нь сөрөг мэдэгдэл хийсэн хэдий ч бусдын үүсгэсэн контент эзэмшиж байсан бөгөөд тэдний хаяг бүртгэлүүд YouTube хэрэг шийдвэрлүүлж байх явцад хаагдсан тохиолдол гарсан. Саентологийн сүм нь DMCA ашиглан Гүүгд, хэдийгээр цор ганц зөрчил гаргагч биш ч гэлээ, шүүмжлэл бүхий вэбсайтуудыг жагсаалтаас хасахыг тулгаж байв. Креационист бүлгүүд дээрх төрлийн аргыг өрсөлдөгчдөө дуугүй болгохын тулд ашиглаж

байсан гэдэг. 2008 онд АНУ-ын Калифорнийн Хойт тойргийн шүүхээс Универсал хөгжмийн корпораци нь YouTube-д байрлуулсан видео бичлэгийг устгах хүсэлт гаргаснаараа DMCA-ыг урвуулан ашигласан гэж үзсэн. Видео бичлэгэд Принсийн дууны аянд бүжиглэж буй хүүхдүүд гардаг ба аудио хэсэг нь маш чанар муутай бөгөөд 20 секунд орчмын хугацаанд л сонсогдохоор байжээ. Шүүхээс видео бичлэгийг илэрхий хууль ёсоор ашигласан хэмээн үзэж, Универсалын зүгээс бичлэг устгах тухай хүсэлт гаргасан үйлдлийг буруутгасан.

- “Мэдэгдэх болон устгах” системийг шүүмжлэгчид нь мэдэгдэл хүлээн авсан вэб хэрэглэгчдийг тухайн материалыг устгахаас өмнө хариу үйлдэл үзүүлэх боломжоор хангах зохих ёсны ажиллагаа шаардахуйц системд шилжихийг дэмжиж байна. Гэсэн хэдий ч контент эзэмшигчид одоогийн процедуртай санал нийлэхгүй байгаагаа илэрхийлж, цаашид системийг тэдний эрх ашигт нийцүүлэн бэхжүүлж, шуурхай болгох талаар санал дэвшүүлж байна.
- Хэрэглэгчдийн интернэтэд нэвтрэх боломжийг хязгаарлахад хүргэж болзошгүй зохиогчийн эрхийн зөрчилд холбогдох хариуцлагын тогтолцоо мөн асуудалтай тулгарч байна.
 - *Жишээ:* Францад Бүтээл ба Интернэтийн тухай хуулиар зохиогчийн эрх зөрчсөний төлөө гаргасан гомдлыг гувалсан арга барилаар шийдэх талаар тогтоосон. Тодорхой IP хаягийн талаар хүлээн авсан гурав дахь гомдлын дараа, вэбийн үйлчилгээ үзүүлэгч тухайн хэрэглэгчийн интернэтэд нэвтрэх эрхийг түр хязгаарлахад хүрсэн. Уг хэрэглэгч мөн нэг жилийн хугацаанд аль ч компаниас интернэтийн үйлчилгээ авах эрхээ хязгаарлуулсан. Интернэтэд нэвтрэх эрхийг хаах талаар дээрхтэй адил гурвалсан арга барил бүхий хандлага Өмнөд Солонгосын Зохиогчийн эрхийн тухай хуулийн 2009 оны нэмэлт өөрчлөлтөд туссан. Нэгдсэн Вант Улсад 2010 онд батлагдсан Цахим эдийн засгийн тухай хуулиар зохиогчийн эрхийг зөрчсөн, ийм төрлийн зөрчлийг дэмжсэн үйлдэл гаргасан байршлаас интернэтэд нэвтрэх эрхийг хаах эрх мэдлийг засгийн газарт олгосон. АНУ-ын Онлайн дахь зохиогчийн эрхийн зөрчлийг таслан зогсоох тухай хуулийн (SOPA Stop Online Piracy Act) төслийн дагуу зар сурталчилгаа гаргагчдыг зохиогчийн эрхийг зөрчсөн, ийм үйлдлийг дэмжсэн вэб сайтуудтай хамтран ажиллахыг хориглосон талаарх шүүгчийн захирамжийг оюуны өмчийн эрх эзэмшигчдийн талд гаргуулах, хайлтын систем, домэйн нэр бүртгэгчдийг эдгээр вэсайтуудыг жагсаалтаас хасах тухай заасан.
- Интернэтийн хүртээмжээр хангагдах эрхийн талаарх үзэл санаа нь хувь хүмүүсийг интернэтэд нэвтрэхэд саад хийсэн арга хэмжээ авах үйл явцад чухал үр дагавар үзүүлнэ. Учир нь эдгээр арга хэмжээг дээр дурдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний гурван талт шалгуурын дагуу зөвтгөх шаардлагатай. Эдгээр хориг арга хэмжээний онцгой шинжийн улмаас зохих ёсны ажиллагаа багатайгаар буюу огт хийхгүйгээр нэвтрэлтийг хаах, хэрэглэгчдэд интернэтийн хэрэглээгээ эргээд өөрсдөө зөвтгөх үүрэг хариуцлага ноогдуулах арга хэмжээ нь дээрх хяналтыг хэрхэн давахыг ойлгоход бэрх.
- Оюуны өмчийн эрхийг цуцлахыг дэмжигч байхгүй хэдий ч өнөөгийн мөрдөгдөж буй журам, түүний дотор үргэлжлэх хугацаа (олон улсын хуулийн дагуу зохиогч нь нас барснаас хойш 50 жилийн дараа, ихэнх улс оронд түүнээс олон жил),

хамрах хүрээ (жишээлбэл, Мартин Лютерийн “Надад мөрөөдөл бий” хэмээх хэлсэн үг нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах нь хууль бус)-тэй холбоотой хэд хэдэн ярвигтай асуудал байна.

Хэлэлцүүлэг: Монголчуудын хувьд оюуны өмчийн хор хохиролтой журмын талаар та бодож байна уу? Дотоодын хууль тогтоомжид монголын болон гадаадын контент гэж зааглах шаардлага бий юу? Олон тооны бүтээгчдийг хүлээн авагч Франц, АНУ зэрэг улсууд үүнийг хэрхэн авч үзэх байсан бол гэж та бодож байна?

3. Контентийн асуудал

- Дээр дурдсанчлан, харилцаа холбооны онлайн бус хэлбэрт тохируулагдсан контентийн журмыг хэн нэг нь интернэтэд мөрдөж болохгүй. Энэ нь зарим тохиолдолд ноцтой асуудалд хүргэнэ. Харин интернэтийн тухайлсан нөхцөлд тохируулагдсан журам шаардлагатай.

Шүүх эрх мэдлийн асуудлууд

- Аливаа нэгэн газар мэдээ нийтлэл гарсан бол түүнийг хаа сайгүй байрлуулах боломжтой байдаг нь интернэтийн онцлог. Үүнтэй холбоотой, интернэт дэх мэдээ нийтлэл нь онлайн бус буюу хэвлэн нийтлэгч бүтээлээ түгээхдээ дор хаяж хяналт тавьдаг бусад төрлөөс ялгаатай. Зарим ном зохиол, тэр байтугай сонин хэвлэл, сэтгүүлийг газар зүйн хувьд өргөн хүрээнд биетээр түгээж болно. Гэвч энэ нь томоохон хэмжээний бүтээлээр хязгаарлагддаг бөгөөд түгээлт нь тусгай, санаа зорилгын шинжтэй.
- Эрүүгийн хэрэг дэх шүүх эрх мэдлийн журам боловсронгуй болох хандлагатай байна. Үүнд гэмт хэргийн бүрэлдэхүүн бүхий тухайн үйлдэл өрнөсөн байрлал, буруутай этгээдийн үндэс угсаа зэргийг харгалзан хэргийг шүүн тасална. Нөгөө талаар, нэр төр гутаах зэрэг иргэний хэрэгтэй холбоотой, хууль зөрчсөн буруу үйлдлийг уламжлал ёсоор “нийгмийн зөв бодолтой гишүүдийн үнэлгээгээр гомдол гаргагчийг гутаах” хандлагатай нийтлэл хэмээн ойлгоно. Уг шалгуурт нийцүүлэхэд шаардагдах зүйл нь гомдол гаргагчийг таньдаг, хэлэлцэгдэж буй нийтлэлийг нь уншсан, сонссон хувь хүмүүст зориулагдсан. Тиймээс уламжлалт энэ журмын дагуу тодорхой шүүх эрх мэдлийн хүрээнд гомдол гаргагчийн нэр төр гутаасан гэх нийтлэлийг зөвхөн ганц хүн уншсан байсан ч хариуцлага хүлээлгэж болно. Хувь хүмүүсийг хаана ч хариуцлагад татах боломжтойгоороо энэ нь маш асуудалтай.
 - *Жишээ:* Их Британи, Австрали зэрэг улсын шүүх нэр төр гутаасан гэх хэргийг шүүх эрх мэдлийн уялдаа холбоо сул байсан ч хамаагүй хэлэлцэхийг зөвшөөрсөн. *Нью Йоркийн зохиолч Рейчел Эренфельдийг Саудын Арабын хөрөнгөтэй бизнесмэн Шейх Халид бин Махфузыг, “Хорыг санхүүжүүлэх нь. Терроризмыг хэрхэн санхүүжүүлдэг вэ? Үүнийг хэрхэн таслан зогсоох вэ?” ном нь дөнгөж 23 хувь зарагдсан хэдий ч, гүтгэсэн асуудлаар Их Британид шүүгдсэн.* Бин Махфуз шүүх дээр ялалт байгуулж, шүүхээс уучлал гуйх, уг номыг устгах, торгууль төлөх шийдвэр гаргасан. АНУ-ын зүгээс үндсэн хуульд харшлах шийдвэрийг дагахаас татгалзах эрх мэдэл тус улсын шүүхүүдэд олгож, хариу үйлдэл үзүүлсэн. Холбооны түвшинд, жишээлбэл, засгийн газраас Тогтвортой бэхэжсэн үндсэн хуулийн өв уламжлалыг хамгаалах тухай тогтоол гаргасан. Хожим нь Их Британид үүний дагуу хуулиндаа нэмэлт өөрлөлт оруулсан.

- Шүүх эрх мэдлийн уялдаа холбоог бэхжүүлэхийн тулд үйл ажиллагаа, журмуудыг сайжруулах шаардлагатай. Тусгай эрх бүхий илтгэгч, төлөөлөгчдийн 2011 онд гаргасан хамтарсан тунхаглалд:

Интернэтийн контенттой холбогдох хэргийг эдгээр хэрэгт шууд, бодит хамаарах улсын шүүхээр шийдвэрлэх нь зүйтэй. Учир нь ихэнх тохиолдолд хэрэгт холбоотой тухайн улсад контент бүтээгч оршин суух, контентийг байршуулах, эсвэл уг контент тухайн улс руу тусгайлан чиглэсэн байдаг. Хувь хүмүүс бодит хохирол амссан тухай мэдэгдэл хүргүүлэх боломж бүхий шүүхийн тодорхой эрх мэдлийн хүрээнд хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргаж болно. (“libel tourism” буюу нэр төр гутаасан асуудлаар гомдол гаргагчид өөрт ээлтэй бусад улсын шүүхээр хэргээ шийдүүлэх ийн эсрэг журам)

- *Жишээ:* АНУ-д шүүх эрх мэдэлтэй холбогдох ихэнх журмууд нь Дээд шүүхийн *Calder v. Jones* хэргээс үүдэлтэй байдаг. “Хэргийг шийдвэрлэхэд шударга бөгөөд үнэн зөв шүүн таслах ажиллагааны уламжлалт ойлголтыг авч үзэхээс илүү ... шүүгдэгчийн хамгийн бага хамааралтай байдлыг” тогтоосон шүүх эрх мэдэл аль ч нөхцөлд үнэн бодит байсан гэсэн тогтсон шалгуурыг Дээд шүүхээс дахин баталсан. Калифорни мужийн зохих шүүх эрх мэдлийг хадгалах талаар шүүхээс: “Калифорни бол түүхэн үйл явдал өрнөсөн гол цэг” хэмээн тэмдэглэсэн. Түүнчлэн, мэдэгдлүүд нь зорилготойгоор Калифорни руу чиглэгдсэн бөгөөд шүүгдэгчид “тэндэхийн шүүхэд дуудагдахаа урьдчилан мэдэх” шаардлагатай.
- *Bangoura v. Washington Post* хэргийг хэлэлцсэн Канад дахь Онтариогийн давж заалдах шүүх нь нэр төр гутаахтай хэргийн шүүх эрх мэдлийн үндсэн журмуудыг тогтоосон. Энэ хэрэгт, гомдол гаргагч Бангура Онтариод 2000 онд суурьшсан бөгөөд 2003 онд Вашингтон Постын эсрэг 1997 оны хоёр нийтлэлийн эсрэг шүүхээр заргалдсан. Нийтлэлүүдийг бүрэн эхээр нь Вашингтон Постын вэбсайтад төлбөртэй захиалгын дагуу, харин хураангуйг төлбөргүйгээр унших боломжтой байв. Шүүхээс шүүх эрх мэдлийн шалгуурт “бодит холбоо”-г мөрдлөг болгосон. Ингэхдээ, гомдол гаргагч нь нийтлэлүүд хэвлэгдсэнээс хойш Онтарио руу шилжин суурьшсан бөгөөд хэвлэн нийтлэгч нь ийм алхамыг нийтлэлүүдийг хэвлэгдэх үед урьдчилан харах боломж байгаагүй нөхцөл байдлыг тогтоосон.

Хэлэлцүүлэг: Монголд “libel tourism” буюу нэр төр гутаах хэргээр гомдол гаргагчид өөрт ээлтэй шүүхээр хэргээ шийдүүлэх, ашигтай хувилбар сонгох эрсдэл бий гэж та үзэж байна уу? Үүнд ямар шийдэл байж болох вэ?

Дамжлуулагчийн хүлээх хариуцлага

- Уламжлалт журмын дагуу, мэдэгдлийг тараахад оролцсон хэн боловч хариуцлага хүлээнэ. Зарим улс орнууд гэм буруугүй нийтлэлүүдийг хамгаалахыг хүлээн зөвшөөрдөг. Ингэснээр түгээсэн этгээд гагцхүү нийтлэлийн нэр төр гутаасан агуулгын талаар мэдээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй. Гэсэн хэдий ч газар болгонд байдал өөр.
 - *Жишээ:* Италийн шүүхээс Гүүглийн ахлах ажилтан өдгөө татан буугдсан Гүүглийн видео сервист бичлэг байрлуулсан хэрэгт буруутгагдсан. Өсвөр насны 4 хүүхэд ангийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гутаан доромжилж байгаа бичлэгээ сервист

байруулсан явдлаас уг хэрэг үүдэлтэй. Италийн цагдаагийн газраас сануулга авснаас хойш хэдхэн цагийн дараа Гүүгл уг бичлэгийг устгасан. Гэсэн хэдий ч удирдлагуудад нэр төр гутаасан, хувийн нууцад халдсан хэргээр эрүүгийн хэрэг үүсгэсэн. Нэр төр гутаасан гэх үндэслэлийг хэрэгсэхгүй болгосон хэдий ч хувийн нууцад халдсаны төлөө хариуцлага хүлээлгэсэн.

- Зарим улс орнууд интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийг хамгаалах тусгай журам баталсан байдаг.
 - *Жишээ:* АНУ-д 1996 оны Цахилгаан холбооны тухай хуулиар (Харилцаа холбооны ёс зүйн заалт хэмээн нэршсэн) үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн аль алинд хамгаалалт үзүүлдэг. “Харилцан үйлчлэл бүхий компьютерийн үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн аль алиныг бусад мэдээллийн контент хангагчийн бэлдсэн аливаа мэдээллийн нийтлэгч, нэвтрүүлэгч хэмээн тооцохгүй.”
 - Их Британид журманд нэмэлт өөрчлөлт оруулахдаа, интернэтийг анхааралдаа авах, электрон нийтлэлд холбогдох хэд хэдэн үйлдлийн төлөө хариуцлага хүлээлгэх, түүний дотор “аливаа электрон мэдээллийг боловсруулах, хувилах, түгээх, борлуулах, аливаа төхөөрөмж, систем, сервисийг ажиллуулах, ханган нийлүүлэх аргаар мэдээллийг сэргээх, хувилах, түгээх эсвэл электрон хэлбэрт оруулах” үйлдэл нь хамгаалагдана. Эдгээр үйлдлүүд интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид болон бусад дамжуулагчдын үйл ажиллагаанд давамгайлдаг. Гэсэн хэдий ч, зохистой арга хэмжээ аваагүй буюу материалыг гүтгэлэгийн шинжтэй гэдгийг мэдэж байсан тохиолдолд хариуцлага хүлээсэн хэвээр байна.
- Европын холбооны гэх мэт бусад шүүх эрх мэдлийн хүрээнд, контентийг хост дээрээ байрлуулах үйлчилгээ үзүүлэгчид хууль бус ажиллагааны талаар мэдээгүй, мэдээллийг устгах талаар шуурхай арга хэмжээ аваагүйгээс бусад тохиолдолд хамгаалагдана. Үүнд “мэдэгдэх болон устгах” заалтын утга оршино. Үүний асуудалтай тал нь дан ганц мэдэгдэх явдал нь ихэнх тохиолдолд, үнэхээр хууль бус мөн эсэхээс үл хамааран материалыг устгахад хүргэдэг (дээр дурдсан зохиогчийн эрхийн журамтай ижил асуудалтай). Жишээлбэл, хэрэглэгчийн үүсгэсэн контентийг байрлуулсан мэдээллийн хэрэгслийн хувьд мэдэгдэх болон устгах хандлага нь уг хэрэгсэлд нэр төр гутаасан гэх гомдол нэгэнт гаргасан бол уг гомдлын шаардлагыг дагах үүрэг хүлээнэ гэсэн үг. Ихэнх орны нэр төр гутаахтай холбоотой хуулиудын нарийн төвөгтэй байдлын улмаас хэрэгт ялагдал хүлээх магадлал өндөр, мөн зарим тохиолдолд хэрэглэгчийн үүсгэсэн контентийг мэдээллийн хэрэгсэл өөртөө хүлээснээр учрах бага хэмжээний эрсдэл, гарал үүслийг нь болгоож чадахгүй байх нь элбэг болохыг харгалзан, ихэнх тохиолдолд дан ганц мэдэгдэх нь тухайн материалыг хууль ёсны мөн эсэхээс үл хамааран устгахад хүргэдэг.
- Тусгай илтгэгч, төлөөлөгчид нь мэдэгдэх, устгах асуудлын маргаантай талд анхаарлаа хандуулан, 2005 оны Хамтарсан тунхаглалдаа:
 - Интернетэд байрлуулсан аливаа контентийн зохиогч, түүнийг эзэмшсэн этгээд буюу уг контентийг интернетээс устгах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан этгээдээс бусад аливаа этгээд интернэт дэх контентийн асуудлаар хариуцлага хүлээхгүй.
- Цаашид судалбал зохих боломжийн хувьд *мэдэгдэх ба дахин мэдэгдэх (notice and notice)* гэсэн арга байж болох юм. Үүний үр дүнд үйлчилгээ үзүүлэгч нэр төр

гутаасан байх магадлалтай мэдээ нийтлэлийн талаар мэдэгдэл хүлээн авмагц, энэ тухай анхдагч түгээлтийг хариуцсан хүнд мэдэгдэнэ. Үүний дараа тэр хүн үзэл бодлоо хамгаалах (ингэхдээ нэрээ нууцалж болно), аль эсвэл материалыг устгахыг зөвшөөрөхийн аль нэгийг сонгоно.

Хэлэлцүүлэг: Хариуцлага хүлээхтэй холбогдох ямар журам Монголд тохиромжтой вэ? Мэдэгдэх ба дахин мэдэгдэх санаа хэр боломжтой вэ, дагаж мөрдөхөд хүндрэлтэй юу?

Дасгал 3: Вэбсайтын зохицуулалт

Хаах, шүүлтүүр хэрэглэх, зогсоох

- Хаах буюу блоклох гэдэг нь тодорхой вэбсайтуудын үйл ажиллагааг таслах үйлдэл юм. Энэ нь сонин хэвлэлийг хаахтай нэгэн адил бөгөөд үүнийг ховор тохиолдолд, гагцхүү шүүгчийн захирамжийн үндсэн дээр хийгдэх ёстой.
- Шүүлтүүр хэрэглэх гэдэг нь тодорхой хязгаарлалттайгаар бусад ялгах шинж (зураг г.м) ашиглан “хүсээгүй” контентийг шүүхийг хэлнэ. Энэ нь эс зөвшөөрснөөс хамаагүй их мэдээллийг барьж авдаг, хэзээ ямагт сохор арга хэрэгсэл болдог. Олон улсын эрх зүйн дагуу, төрөөс үүрэгдсэн шүүлтүүр нь хууль ёсны буст тооцогддог.
- Хүмүүсийн хувьд маш чухал хэрэгсэл учраас эмх замбараагүй байдал үүсэн нөхцөлд хүртэл интернэтийг бүхэлд нь хаах үйлдэл хууль ёсны бус юм. Тусгай илтгэгч, төлөөлөгчид 2011 оны Хамтарсан тунхаглалдаа:
Интернэт, түүний аль нэг хэсгийн хандалтыг нийт хүн амд буюу нийгмийн хэсэг бүлгийн хувьд хязгаарлах (интернэт таслах) нь нийгмийн хэв журам, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үндэслэлтэй байвч, ямар ч тохиолдолд зөвтгөшгүй үйлдэл юм. Энэ нь интернэтийн хурдыг бүхэлд нь буюу хэсэгчлэн сааруулах үйлдэлд адил хамааралтай.

Хэлэлцүүлэг: Улс орнуудын хувьд интернэт дэх контентийг хянах нь бараг боломжгүй зүйл. Бид хүүхдүүдээ болон бусад иргэдээ интернэт дэх ёс бус контентоос хэрхэн хамгаалах вэ? Боловсрол олгох нь хангалттай юу?

Модуль 6: Интернэтийн хүртээмжтэй байдал

1. Эрх зүйн дэвшил

- Интернэт нь дан ганц өөрийгээ илэрхийлэх хэрэгсэл болохоос гадна нийгмийн маш олон үйл ажиллагаанд (худалдаа наймаа, нийгмийн харилцаа, соёл боловсрол, улс төрийн мэтгэлцээн г.м.) чухал үүрэг гүйцэтгэх болсноор хүртээмж хүний эрх мөн эсэх талаарх маргаан үүсч эхлэв. Интернэт нь бүх нийтэд хүртээмжтэй бус. Хөгжингүй орнуудын хүн амын 73.8% нь, харин хөгжиж буй орнуудын дөнгөж 26.3% нь интернэтийн хүртээмжээр хангагдаж байна.
- Дээрх асуудалд чиглэсэн магадгүй хамгийн тодорхой мэдэгдлийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх олон улсын тусгай эрх бүхий илтгэгчдийн 2011 оны Хамтарсан тунхаглалд заасан:
 - Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилт нь улс орнуудад интернэтийн бүх нийтийн хүртээмжтэй байдлыг хөхиүлэн дэмжих үүрэг ноогдуулна. Интернэтийн хүртээмжтэй байдал нь бусад эрхийг, тухайлбал сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх, эвлэлдэн нэгдэх болоод чөлөөт сонгуульд оролцох эрхүүдийг хүндэтгэн сахих явдлыг сайшаан дэмжихэд ач холбогдолтой.
- Мөн түүнчлэн үндэсний түвшний хөгжил дэвшилд чухал ач холбогдолтой.
 - *Жишээ:* 2001 онд Грек улс Үндсэн хуулиндаа 5А дугаар зүйлээр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд:

2. Бүх хүмүүс мэдээлэлжсэн нийгэмд оролцох эрхтэй. Электрон аргаар дамжуулагдсан мэдээллийн хүртээмжтэй байдал, мөн түүнчлэн боловсруулах, солилцох, тараахыг дэмжих үүрэг улсад ноогдоно.

- *Жишээ:* Франц улсад 2009 онд Үндсэн хуулийн зөвлөлөөс интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийг зохиогчийн эрхийн зөрчилд буруутгагдсан хэрэглэгчийн интернэтэд хандах хандалтыг байнгын хаахыг шаардсан маргаантай хуулийг түдгэлзүүлсэн. Учир нь онлайн харилцаа холбооны үйлчилгээнд хандах эрх чөлөөг 1789 оны Хүний болон иргэний эрхийн тунхаглалын дагуу хамгаалсан байдаг. Францын шийдвэр нь Грекийн үндсэн хуулийн нэгэн адил интернэтийг бие даасан эрх хэмээн илэрхийгээр хүлээн зөвшөөрөөгүй боловч тус шийдвэрийг хожим нь Коста Рикийн үндсэн хуулийн шүүхээс дараах шийдвэр гаргахдаа дурдсан байдаг:

Мэдлэг, мэдээлэлд суурилсан нийгмийн хүрээнд төрийн байгууллагад түүний удирдлага дор байгаа хүмүүсийн тусын тулд эдгээр шинэ технологийн бүх нийтийн хүртээмжтэй байдлыг хөхиүлэн дэмжих, ханган баталгаажуулах үүрэг ноогдуулна.

- *Жишээ:* Хэд хэдэн шүүх эрх мэдлийн хүрээнд бүх нийтийн үйлчилгээгээр хангах эрх зүйн шаардлага хүлээлгэснээр интернэтийн хүртээмжийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн. Энэ нь Эстони улсаас эхтэй. Тус улс 2000 онд онлайн хүртээмжтэй байдал нь “газар зүйн байрлалаас үл хамааран бүх хэрэглэгчдэд хүрэх боломжоор хангах” талаар заасан. Ижил шаардлагыг Финланд, Испани болон Канадын муж, Нова Скотиад нэвтрүүлсэн байна.

- *Жишээ:* Олон улсын түвшинд интернэтийн ач холбогдлыг 1999 оны эхээр Америк дундын Хүний эрхийн комиссоос дараах байдлаар хүлээн зөвшөөрсөн. Үүнд:

Интернэт бол ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, бүс нутгийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг бүрэн хэрэгжүүлэх чадвар бүхий механизм юм. Интернэт харилцаа холбооны түүхэнд урьд өмнө байгаагүй технологи, шуурхай дамжуулалт, дэлхийн төрөл бүрийн, олон өгөгдлийн сүлжээний хандалтыг дэмжих, интернэтийн хэрэглээгээр дамжигдан иргэдийн идэвхтэй оролцоог дээшлүүлэх, үндэстнүүдийн нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд хувь нэмэр оруулснаараа ардчилсан нийгмийг бэхжүүлдэг. Интернэт эргээд хүний эрх, ардчиллын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх түнш болох чадалтай бөгөөд хүний эрхийн байгууллагуудыг идэвхжүүлэх чухал хэрэгсэл болдог. Учир нь түүний хурд, хамрах хүрээ нь дэлхийн өнцөг булан бүрт буй иргэдийн хувь хүний үндсэн эрхэд нөлөөлөх мэдээллийг шуурхай илгээх, хүлээн авах боломжтой болгодог.

2. Үр дагавар

- Гэсэн хэдий ч, бүх улс орон бүх нийтийн хүртээмжтэй байдлыг нэн даруй хангах үүрэгтэй гэсэн үг биш. Интернэтийн бүх нийтийн хүртээмжтэй байдлыг хангах явдал өртөг өндөртэй бөгөөд техникийн хувьд бэрхшээлтэй. Үүнтэй холбогдуулан, интернэтээр хүртээмжтэй хангагдах эрх нь иргэний болон улс төрийн эрхээс ялгаатай. Ямар ч үндэстэн хэт ядуугийн улмаас ард түмнээ ардчилал, шашин шүтэх эрхээр хангаж чадахгүйд хүрдэггүй боловч ихэнх үндэстнүүдийн хувьд интернэтийн хүртээмжээр бүрэн хангаж чадахгүй байна. Тиймээс интернэтийн хүртээмжээр хангагдах эрхтэй холбогдон гарах үүрэг хариуцлагын хамрах хүрээ, мөн чанарыг, тэр дундаа улс орнуудад ноогдох хариуцлагын түвшинг ухааран ойлгох нь чухал.
- Интернэтийн хүртээмжээр хангагдах эрх улс орнуудад тодорхой эерэг үүрэг хариуцлага ногдуулах явдлыг нэмэгдүүлж, юуны түрүүнд, интернэтийн бүх нийтийн хүртээмжээр хангах чиглэлээр ажиллах үүрэг хүлээлгэж байна. Интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд улс орнуудын хөрөнгө чинээ, хөгжлийн түвшинг харгалзан, хуваарилах боломжтой шаардагдахуйц нөөц бололцоо тэдний мэдэлд буй арга замаас хамаарна. Өдгөө Европын ихэнх улс орон бүх нийтийн хүртээмжийн талаарх хөтөлбөр бий болгох боломжтойн хажуугаар дэлхийн ядуу буурай улс орнууд, ялангуяа хөдөөгийн хүн ам олонтой үндэстнүүдийн хувьд байдал өөр байна. Үүний үр дүнд, интернэтийн хүртээмжээр хангагдах эрх байгаа хэдий ч уг эрхийн хэрэгжилтийг аажмаар хэрэгжүүлвэл зохих асуудал мөн. Өөрөөр хэлбэл, бүх улс орнууд интернэтийн бүх нийтийн хүртээмжийг хөхиүлэн дэмжих үүрэг хүлээсэн хэдий ч уг эрхийн хэрэгжилт тухайн улсын хөгжлийн түвшин болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ялгаатай байна.
- Интернэтээр хүртээмжтэй хангагдах эрх болон аажмаар хэрэгжих өөр нэгэн эрх болох сурч боловсрох эрхийн хооронд адил төстэй байдлыг харж болно. Сурч боловсрох явдлыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар (ХЭТТ) хүний эрх хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэсэн хэдий ч, уг эрхийг хэрэгжүүлэх улс орны хүлээсэн үүрэг хариуцлагын түвшин нь хуваарилах боломжтой нөөц бололцооноос хамаардаг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)-ын 13(2) дугаар зүйлд сурч боловсрох эрхийн талаарх улс орны үүрэг хариуцлагын талаар заасан байдаг. Үүнд.

Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд:

- (a) хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох;
- (b) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, техник-мэргэжлийн дунд сургуулийн боловсролыг оролцуулан, дунд боловсролын төрөл бүрийн хэлбэрийг бүгдэд боломжтой, хүртээмжтэй болгох;
- (c) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, авъяас чадварыг нь харгалзан, дээд боловсролыг бүгдэд ижил хүртээмжтэй болгох;
- ...
- (e) бүх шатны сургуулийн тогтолцоог эрчимтэй хөгжүүлэх, хангалттай тэтгэлэгийн тогтолцоотой болох, багш нарын материаллаг нөхцлийг байнга сайжруулах арга хэмжээг авах ёстой.

- Тиймээс, бага боловсролыг заавал олгох, харин дунд болон дээд боловсролыг нөөц бололцоог харгалзан, ялгаварлан гадуурхалгүйгээр үе шаттайгаар нэвтрүүлэх шаардлагатай. Улс орон бүр иргэддээ нөөц боломжийнхоо хэрээр боловсрол олгох тодорхой үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, тус үүрэг нь заавал бүх нийтийн боловсрол эзэмшүүлэх бус харин бүх нийтийн боловсрол олгох чиглэлээр нөөц бололцоогоо хамгийн боломжит зөв аргаар ашиглан, хүний эрхийг зохих ёсоор хангах явдал юм.
- Интернэтийн хувьд үүнтэй ижил. Ихэнх улс орон бүх иргэдээ интернэтийн хүртээмжээр хангах боломжгүй байж болох ч интернэтийн хүртээмжээр хангагдах эрх нь бүх улс оронд уг зорилтыг дэвшилттэйгээр биелүүлэхийн тулд чармайх үүрэг хүлээлгэнэ.
- Үүний нэг асуудалтай тал нь холболтын хүрэлцэхүйц хурд нь хөдөлгөөнт бай болох тул интернэтээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд холболтын хурдын чухам ямар хэмжээ шаардлагатай гэдэ нь тодорхойгүй. Хурд ихтэй холболтууд нь норм болсон учраас вэбсайтуудыг нэвтрэхэд өндөр шаардлагатайгаар хөгжүүлж байна. Үүний үр дүнд 10 жилийн өмнө хангалттай байсан холболтын хурд орчин үеийн ихэнх вэбсайтуудыг ачаалахад хүрэлцэхгүй болоод байна.

Хэлэлцүүлэг: Дээрх санааны хувьд Монголын нөхцөлд холбогдуулж юу гэж бодож байна? Үүнд ямар практик ач холбогдол өгч болох вэ? Үүнийг хэрхэн хийх вэ?

3. Хүртээмжээр хангахад тулгарах асуудал бэрхшээл

- Өдгөө хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын хооронд интернэтэд нэвтрэхэд тодорхой зөрүү байна (гол төлөв тоон хуваагдал гэж нэршсэн). Гэсэн хэдий ч интернэт нь хөгжиж буй орнуудад боломжтой болж байгаа ч улс орнуудын хоорондын ялгаатай байдал нь дэлхийн баячууд болон хотын иргэд, ядуус болон хөдөөнийхэнний хооронд асар их зөрүү бий болгож байна. Ийм байдлаар, монголын дундаж давхаргын хэн боловч интернэтэд чөлөөтэй нэвтэрдэг бол харин ядууст тийм боломж олддоггүй.
- Интернэтийн бүх нийтийн хүртээмжтэй байдалд үндсэн гурван асуудал тулгарч байна. Нэгдүгээрт, дэд бүтцийн хомсдол. Уг бэрхшээл нь ихэвчлэн хөгжиж буй

орнуудад тулгардаг ч хөгжингүй орнуудын хөдөөний буюу алслагдмал, тусгаарлагдсан хүн амын интернэтийн хүртээмжтэй байдалд саад тотгор болдог хүчин зүйл юм. Хоёр дахь гол бэрхшээл нь боломжтой байдлын асуудал бөгөөд дэд бүтцээр хангагдсан хэдий ч интернэтийн хүртээмжээр хангагдаж чадахгүй байгаа байдал юм. Гурав дахь нь нийгмийн асуудал. Үүнд компьютерийн анхан шатны мэдэгдэхүүн бага, хүсэл сонирхолгүй байх, онлайнд холбогдох чадваргүй байх зэрэг интернэтийн үр ашгийн талаарх мэдлэг ойлголт сул зэрэг хүчин зүйл багтана.

Дэд бүтэц

- Үндэсний хэмжээнд технологийн дэвшил мөн түүнчлэн өндөр хэмжээний хөрөнгө оруулалт зэрэг нь дэлхийн бараг улс орон бүр интернэтэд холбогдоход нөлөөлсөн.
- Үүний зэрэгцээ, бүх нийтийн өргөн зурвасын хүртээмжээр хангахад суурин газрын түвшинд хүртэл, дэд бүтцийн хувьд асар их хүндрэл бэрхшээлтэй бөгөөд их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг.
- Ихэнх улс оронд дан ганц арилжааны шинжтэй арга зам “эцсийн бээр” хүртлэх өндөр зардлаас үүдээд хангалтгүй. Тиймээс төрөөс татаас авах аргыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хослуулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй. Зохицуулалтын арга замаар цахилгаан холбооны компаниудыг хотын нутаг дэвсгэрийн үйл ажиллагаанаас хөдөөний хүртээмжийг дэмжихэд шаардагдахуйц дэд бүтцийг санхүүжүүлэхэд түлхэц өгч болно.
- Хамгийн гол нь улс орнууд хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд нөөц хуваарилах, бусад арга, түүний дотор зохицуулалтын арга хэмжээ авахын хамт бодит төлөвлөгөөтэй байх ёстой.
- Хөгжингүй ертөнцөд, өдгөө хэд хэдэн улс орон бүх нийтийн хүртээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эцсийн шатандаа явж байна.
 - *Жишээ:* 2010 оны 7-р сард Финланд улс цахилгаан холбооны операторуудыг өргөн зурвасын бүх нийтийн хүртээмжийн дэд бүтцэд хувь нэмэр оруулахыг шаардсан хууль баталсан. Энэ нь 2015 он гэхэд үйлдвэр аж ахуйн болон байнгын оршин суух газрын 99% нь шилэн кабель болон кабель холболтоос 2-оос илүүгүй км-ийн зайтай болгох зорилготой. Хэрэв цахилгаан холбооны оператор нь “зохистой хураамж” төлөх замаар ийм хэмжээний дэд бүтцийг байгуулахад оролцож чадахгүйд хүрвэл тус хуулийн дагуу 120,000-аас 130,000 өрхийг төлөөлсөн хүн амын 5% нь татаас шаардана гэсэн тооцоотойгоор Зам тээвэр, харилцаа холбооны яаманд хандаж санхүүгийн туслалцаа хүсч болно. Татаас шаардлагатай бол цахилгаан холбооны операторууд зардлын 34%-ийг нөхөн төлнө. Үлдэгдсэн хувийг төрийн нөөц, тухайлбал засгийн газар болон Европын холбооноос гаргана.
- Бүх нийтийн хүртээмжийн хөтөлбөртэй холбогдон гарах өндөр зардлаас үүдэн зарим улс орнууд орон нутаг, суурин газруудыг интернэтэд холбох бодлого баримталж байна.

Боломжтой байдал

- Ихэвчлэн дэд бүтцийн хомсдолтой холбоотой тулгарч буй бас нэг асуудал бол хувийн болон гэр бүлийн хэрэглээний түвшинд интернэтийн хүртээмж өндөр үнэтэй байх явдал юм. Энэ нь хүртээмжийн үндсэн дэд бүтцэд тэрбум гаруй

долларын хөрөнгө оруулалт шаардагдаж байгаа хөгжиж буй орнуудын хувьд бодит байдал болж байна. Ийм хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа байгууллагууд нь гол төлөв консорциумууд буюу төр, хувийн хэвшлийн түншлэлүүд байдаг бөгөөд хэрэглэгчдээс хураамж авах замаар хөрөнгө оруулалтаа нөхдөг.

- Үүний асуудалтай тал нь цаг хугацааны явцад бараг хаа сайгүй хураамжийн хэмжээ буурч байхад, дэлхийн хамгийн буурай орнуудад өргөн зурвасын сүлжээний үнэ дэлхий дээр хамгийн өндөр байна.
- Өндөр үнэ газар зүйн байрлалаас ямар нэг хэмжээгээр хамаардаг. Хүртээмж илүү өндөр үнэтэй байдаг ихэнх улс орнууд далайд гарцгүй, эсвэл хүн ам багатай алслагдсан арлын орнууд байдаг.
- Зохицуулалтын дорой бүтэц, өрсөлдөөний хомсдол нь интернэтийн хүртээмжээр хангахад хэрэглэгчийн үнийн өсөлтөд нөлөөлдөг. Өргөн зурвасын сүлжээний үнийн өрсөлдөөний үр нөлөө ихээхэн анхаарал татна.
 - *Жишээ:* 2010 оны 7-р сард Нигерийн SAT-3 хангамжийг хянадаг Нител компани 1mb/s хурдын өргөн зурвасын сүлжээнд сард 800 ам.долларын хураамж авчээ. Тухайн сард түүний өргөн зурвасын зах зээл дэх өрсөлдөгч MainOne компани онлайнаар ижил үйлчилгээг сарын 500 ам.долларын хураамжийн төлбөртэйгээр санал болгосон. Nitel нь үүний хариуд хурамжаа 450 ам.доллар хүртэл бууруулсан. 2010 оны сүүлээр гэхэд Нигерт өргөн зурвасын сүлжээний үнэ сарын 54 ам.доллар хүртлээ буурсан байна.
 - *Жишээ:* Өрсөлдөөний үүргийн талаарх бас нэг жишээ дэлхийд интернэтийн нэвтрэлт хамгийн өндөр үзүүлэлттэй (нийт өрхийн 94% нь интернэт ашигладаг) Өмнөд Солонгост өрнөсөн. Энэ нь 2000-2002 оны хөгжлийн үеийн үр дүн юм. Тухайн үед интернэт хэрэглэгчдийн тоо 200%-иар нэмэгдэж, айл өрхийн интернэт ашиглалтын түвшин 27%-оос 69% хүртлээ өссөн. Цахимжуулалтыг дэмжихэд чиглэсэн засгийн газрын бодлого нь хэрэгцээ шаардлага нэмэгдэхэд нөлөөлсөн хэдий ч энэхүү хурдтай өсөлтийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь хувийн хэвшлийн эрчимтэй өрсөлдөөн байсан. Энэ нь эрчимтэй зар сурталчилгаа хийх, аль болох олон хэрэглэгч татахын тулд бага үнэ тогтоох аргаар өрнөж байв.
- Интернэт кафе зэрэг нийтийн цэгүүд мөн интернэтийг санхүүгийн хувьд хүртээмжтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Үүний сонирхолтой загварыг Перугаас харж болно. Тус улсын хэмжээнд өргөжин тэлэх 33,000 гаруй интернэт “кабин” байрлуулсан. Хараат бусаар ажилладаг эдгээр кабинудаас Перугийн интернэт хэрэглэгчдийн 85% нь онлайнаар орж байна.

Нийгмийн асуудлууд ба эрэлт хэрэгцээ

Хэлэлцүүлэг: Монголд интернэтэд нэвтрэхэд нийгмийн зүгээс ямар саад бэрхшээл байна гэж Та бодож байна? Эдгээрийг багасгахын тулд яах вэ?

- Бүх нийтийн хүртээмжид тулгарах гуравдагч гол асуудал нь интернэтийн хэрэгцээ буюу сонирхлын хомсдол юм. Энэ нь материалын буюу эдийн засгийн асуудал гэхээс илүүтэйгээр нийгмийн асуудал юм. Интернэтийн хүртээмжийг хязгаарлаж буй нийгмийн хамгийн түгээмэл асуудал бол интернэтийн анхан шатны мэдэгдэхүүний доогуур түвшин юм.

- Интернэтийн анхан шатны мэдэгдэхүүн буюу интернэтийн хэрэгцээндээ нийцүүлэн, үр нөлөөтэй ашиглах чадамж нь ихэнхдээ угсаа гарал болоод эдийн засгийн хүчин зүйлтэй холбоотой байдаг. Интернэтийг багаасаа ашиглаж сурах нь дээрх чадварыг эзэмших шилдэг арга хэмээн үздэг. Гэсэн хэдий ч, удмын болон эдийн засгийн хүчин зүйлүүдийг даван туулах боломжтой. Үүнийг Өмнөд Солонгосын интернэтийн хурдтай өргөжилт болон Энэтхэгийн компьютерийн үйлдвэрлэлийн амжилт зэргээс харж болно.
- Интернэтийн анхан шатны мэдэгдэхүүний хомсдолоос илүүтэйгээр ихэнх тохиолдолд бичиг үсэгт тайлагдах байдлын дутагдал саад тогтгор болж байна. Боловсролын хүртээмж нь эрхийн асуудал мөн боловч хэлэлцэгдэж буй асуудлын хамрах хүрээнээс гадна байна. Гэсэн хэдий ч дэлхийн орчин үеийн эдийн засаг дахь интернэтийн төвлөрөл нь улс орнуудыг боломжийнхоо хэрээр сургуулийн хөтөлбөрт вэбийн анхан шатны мэдэгдэхүүний асуудлыг оруулах талаар анхаарахыг шаардаж байна.
- Хүмүүсийг онлайнд нэвтрүүлэхийн тулд “хүссэн үр дүнд хүрэхэд хангалттай хэмжээ” чухал үүрэг гүйцэтгэнэ. Хүй олны дунд интернэт хэрэглэж буй хүмүүсийн тоо олон бол интернэтэд холбогдох нь илүү анхаарал татдаг. Нийгмийн сүлжээний платформ болох Фейсбүүкийн амжилт нь гол төлөв дээрх санаан дээр тулгуурласан. Ихэнх найз нөхөд, хамт ажиллагчид Фейсбүүкт байдаг учраас хэрэглэгчид Фейсбүүкт нэгдэхийг хүсдэг. Өөрөөр хэлбэл, тодорхой хүй олны дотроос хангалттай хэмжээний хэрэглэгчид бүртгүүлсэн тохиолдолд энэ эрч дээр суурилж үйлчилгээ цаашид өргөжсөөр байна. Гэвч тодорхой хүй олны дотор хэрэглэгчид хангалттай хэмжээнд хүрээгүй бол нийгмийн хязгаарлагдмал хэрэглээг санал болгох учраас тухайн хүйн бүлгийн хэрэглэгчдийг үйлчилгээгээр татах хэцүү.
- Интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх нийгмийн саад бэрхшээлийг олон хүчин зүйл бүрдүүлэхийн зэрэгцээ мөн арилгахад ч нөлөөлдөг. Хамгийн тод жишээ бол хэлний асуудал. Англи буюу Испани гэх мэт өргөн тархсан хэлээр ярьдаг хүй олны хувьд хүртээмжтэй контент олоход илүү амар. Ямаик зэрэг хөгжиж буй ертөнцийн англи хэлээр ярьдаг улс орнуудад интернэтийн хэрэглээ харьцангуй өндөр байгааг үүгээр тайлбарлаж болно. Дэлхийн хэмжээнд 15,5 саяд хүн амтай, ихэнх хэсэг нь Шри Ланкад амьдардаг Сингала хэлээр яригчдын анхаарлыг интернэтэд хандуулахад бэрхшээлтэй. Хэлний асуудал нь хүчин зүйл болох хэдий ч энэ асуудлыг хэтрүүлэх шаардлагагүй. Электрон сүлжээгээр хамгийн их холбогдсон Өмнөд Солонгос болон Эстони хоёр улсад өвөрмөц хэлээр ярьдаг.
- Амжилтын түүх бидэнд хангалттай хэмжээний хэрэглэгчдийг хэрхэн дэмжихийг ойлгоход тус болно. Хүн амаа онлайнд холбоход асар их амжилт гаргасан Эстонид засгийн газар өөрийн үйлчилгээг онлайнаар санал болгон, цахимжуулалтын арга замыг чиглүүлсэн. Эстонийн засгийн газар мөн цахимжуулалтын хөтөлбөрийн хүрээнд, төр ба хувийн хэвшлийн түншлэлүүдийг дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хөдөлгөгч хүчин болохынх нь хувьд байгуулсан. Дотоодын мэдээллийн технологийн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг бий болгох, мөн иргэдийн төртэй харилцах илүү хурдан, илүү үр дүнтэй арга болохын хувьд интернэт ашиглахыг дэмжсэнээр засгийн газар интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд хэрхэн манлайлж болохыг Эстонийн жишээ харуулсан.

Гар утасны хүртээмжтэй байдал: Нээлт?

- Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) үзэж буйгаар хөдөлгөөнт технологи нь “түүхэн дэх хамгийн хурдан нэвтрүүлсэн технологи” юм. 2011 оны

сүүлээр дэлхийн хэмжээнд 6 тэрбум гар утас хэрэглэгч бүртгэгдсэний дотроос 79% нь хөгжиж буй орнуудаас нэвтэрсэн байна. Эдгээрийн ихэнх нь өргөн зурвасын сүлжээнд холбогдох боломжгүй хэдий ч өнөөдрийн байдлаар хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээний хэрэглэгчид бусад өргөн зурвасын сүлжээнийхээс хоёр дахин илүү байна.

- Гар утас нь интернэтийн хэрэглээнд тулгардаг гурван асуудал бэрхшээлийн бүгдэд давуу талтай. Дэд бүтцийн мөн чанар хөдөлгөөнт интернэтээс хөдөөний буюу тархмал суурьшсан хүн ам бүхий бүс нутгийн интернэт дэд бүтцийг өргөжүүлэхтэй холбоотой олон асуудал бэрхшээлээс зайлсхийхийг шаардана. Хөдөлгөөнт интернэт ямар нэг хэмжээгээр дэд бүтэц шаардах боловч түүнийг бий болгох зардал, хүндрэл нь өргөн зурвасын хөдөлгөөнгүй сүлжээ бий болгохоос хялбар, ялангуяа “эцсийн бээр” хүртэлх зардлын хувьд бага. Үүнээс гадна, байгалийн гамшигт нэрвэгдэх хандлагатай орнуудын байдлаас харахад хөдөлгөөнт өргөн зурвасын дэд бүтэц илүү бат бөх шинжтэй байна.
- Дэд бүтцийн зардлыг бууруулах шалтгааныг дэлхийн ихэнх хэсэгт хөдөлгөөнт интернэт нь хэдийнээ онлайнд холбогдох илүү хямд сонголт болсоноор тайлбарлана. Хөгжиж буй орнуудад хөдөлгөөнт интернэтийн үнэ өндөр байгаа хэдий ч Кени, Шри Ланка, Вьетнам зэрэг улсуудад хөдөлгөөнт интернэтийн холболт хөдөлгөөнгүй өргөн зурвасын сүлжээний эхлэлийн түвшний төлөвлөлтөөс хавьгүй хямд. Үүнээс гадна, ихэнх улс оронд хөдөлгөөнт интернэтийн үндсэн төлөвлөлт өргөн зурвасын үндсэн багцаас илүү холболтын хурд санал болгодож байна.
- Хөдөлгөөнт интернэт нь нийгмийн хүртээмжтэй байдлаасаа шалтгаалан хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх чадвартай. Хүмүүст танил бус, шинэ бүтээгдэхүүн, тухайлбал компьютер санал болгохын оронд дэлхийн өнцөг бүрт тархсан гар утас нь хэрэглэгчдэд хэдийнээ танил төхөөрөмжөөр дамжуулан интернэтийн хүртээмжээр хангадаг. Энэ нь жижиг хүйн бүлгүүдэд интернэтийг дэлгэрүүлэхэд шаардагдахуйц хангалттай хэмжээний хэрэглэгчдийг бий болгоход нөлөөлөх боломжтой. Мөн анхан шатны мэдэгхүүний асуудалд мөн эерэгээр нөлөөлнө. Хэрэглэгчид цоо шинэ бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглах талаар сурахаас илүүтэйгээр үүнийг бага зэрэг нэмэлт мэдлэг ашиглан онлайнд холбогдоход хялбар байна.

Хэлэлцүүлэг: Интернэтэд нэвтрэх хэрэгсэл болохын хувьд гар утасны давуу болон сул тал юу вэ? Энэ нь Монголын хувьд урагшлах арга зам мөн үү? Хэрэв үгүй бол, урагшлах арга зам нь юу вэ?

Дасгал 4: Монголд хүртээмжийг хөхиүлэн дэмжих нь

Модуль 7: Онлайн дахь хувийн нууц ба мөрдөн хянах ажиллагаа

“Мөрдөн хянах ажиллагааны урьдчилсан таамгуудыг нягтлан үзвээс Жорж Орвел өөдрөг үзэлтэн байсан нь нотлогдоно.”

- Микко Хиппэнэн, Аюулгүй байдлын судлаач
“How the NSA betrayed the world's trust -time to act”, October 2013
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олгож буй хэрэгслийн хувьд интернэт хэрэглээний түлхүүр болдог цахим харилцаа холбоонд хэрэглэгчид итгэдэг гэдгийг баталгаажуулах гол хэмжүүр үзүүлэлт нь хэрэглэгчийн хувийн нууцын хамгаалалт юм. Энэ нь хувийн хэвшлийнхэн, тухайлбал интернэт үйлчилгээ үзүүлэгч болон арилжааны вэб сайтууд, цаашилбал засгийн газарт ч хамааралтай.
- Гэсэн хэдий ч, 2013 оны зургадугаар сараас эхлэн мөрдөн хянах ажиллагааны тухай Эдвард Сноудений ил болгосоор буй асуудал нь цахим орчин дахь хувийн нууц баталгаажих яагаа ч үгүй байгааг илтгэн харуулдаг. Компьютер болон бусад төхөөрөмж дээрээ та ганцаараа ажиллаж байна гэж бодож болох хэдий ч, цахим ертөнцөд ажиллахад тийм биш гэдэг нь тодорхой байна. Мэдээллийг шинээр илчлэх болгонд засгийн газрын мөрдөн хянах ажиллагаагааны түгшүүрт байдал улам эрчимждэг хэдий ч, дижитал ертөнцийг аюулгүй байлгахын тулд ажиллаж буй хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын байгууллагын хүчийг сулруулах мэдээлэл тараалаа хэмээн Удирдах албан тушаалтнууд нь заргалддаг.
- Олон хүний хувьд нэрээ нууцлах нь цахим орчны чухал үнэт зүйл болдог юм. Нууцалж хадгалах мэдрэмж, сонирхлоо баримтлах боломжтой бөгөөд хэрэглэгчид өөрсдийн гэр бүл, нийгмийн тойрог, эсвэл ажил олгогчоос юу гэх бол гэсэн айдасгүйгээр янз бүрийн сэдвээр үзэл бодлоо илэрхийлж болно. Нэрээ нууцлах эрмэлзэл нь мөрдөн мөшгих айдас түгшүүр бодитойгоор байгаа тохиолдолд нийгмийн бэрхшээлээс хамгаалагдахад оршино. Уганда, Оросын гей хүмүүс, эсвэл Саудын шашинд үл сүсэглэгчдийн хувьд интернэт бол өөрийгөө илэрхийлэх цорын ганц нээлттэй орон зай болдог бөгөөд нэг сэтгэлгээтэй ард иргэдтэй сүлжээнд шахалт үзүүлэх боломжтой байдаг.
 - *Жишээлбэл:* танил болсон вэб форум TechCrunch.com нь технологийн бүтээгдэхүүнээ хэлэлцүүлэхийн тулд аливаа сэтгэгдэл бичигч эдгээдийг өөрийнхөө жинхэнэ нэрийг бичихийг хэрэглэгчдээсээ шаардаж форматаа өөрчилсөн. Энэ нь шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүнээ ширүүн шүүмжлэлийг өрнүүлсний үндсэн дээр мэддэг байсан уг сайтын шүүмжлэл хурц ширүүн, шударга шинж чанараа алдсан болохыг тэд олж тогтоосон байна.
 - *Жишээлбэл:* Харилцаа холбооны эрх чөлөөний Европын Зөвлөлийн Тунхаглалаар цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэхэд нэрээ нууцлахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Цахим орчинд мөрдөн хянагдахын эсрэг хамгаалалтыг баталгаажуулахын тулд мэдээлэл, санаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг бэхжүүлэхийн тулд (...) Улс орнууд өөрийгөө илчлэхгүй байх интернет хэрэглэгчийн хүсэл эрмэлзлийг хүндэтгэвэл зохино.

- Цахим орчин дахь хүний хувийн нууцын хязгаарлалт эрүүгийн болон иргэний хуульд, тэр байтугай гэрээний заалт ч болсон байдаг. Эрүүгийн хуульд зааснаар,

эрх бүхий байгууллагад мөрдөн хянах ажиллагааны зарим зэрэглэл нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах кибер гэмт хэргийг зогсоох, эсвэл хүүхдийг садар самуунд уруу татахаас хамгаалахад зайлшгүй шаардлагатай болох нь тогтоогдох ёстой. Тийм арга хэмжээ явуулах үед хүний эрхийг хамгаалах нуувчийн асуудал гарч ирнэ.

- Иргэний хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хувийн нууцад хязгаарлалт тавьдаг. Мөн бусдын нэр төр, оюуны өмчийн эрхийг хамгаалахад шаардлагатай тохиолдолд цахим орчинд нууц нэр хэрэглэхийг мөн хязгаарладаг.
- Гэрээний үндсэн дээр хувийн нууцад халдахдаа интернэтээр дамжуулж буй үйлчилгээнийхээ нэг чухал хэсгийг дэмжихийн тулд бизнесийн загвар болгож үндсэндээ ажиллуулдаг. Google, Facebook зэрэг онлайн орчинд “үнэгүй” үйлчилгээ үзүүлдэг ихэнх компаниуд зар сурталчилгаа болон хэрэглэгчийн мэдээллийг худалдаж дийлэнх орлогоо бүрдүүлэн ажилладаг. Эдгээр вэбсайтаар зочлох болон түүний үйлчилгээг ашигладаг хүмүүс төлбөрөө мөнгөөр төлөхөөс илүүтэй хувийн мэдээллээрээ төлөхийг илүүд үздэг. Ийм онлайн үйлчилгээ эрхлэгчдийн зонхилох загвар гарч ирж байгаа ч, үүний үр дагавар эсвэл альтернатив сонголтын талаар ямар нэг олон нийтийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнгүйгээр хийгдэж байгааг тэмдэглэвэл зохино. Хэлбэрийн хувьд, мэдээж хүн бүр эдгээр үйлчилгээг ашиглах, ашиглахгүйгээ сонгох нь чөлөөтэй хэдий ч бодит байдалд онлайн үйлчилгээ нийлүүлэгчдэд асар их хувийн нууцаа золиослохгүйгээр орчин үеийн амьдралаар амьдрахад маш хүнд болж байна.
- Хувийн хэвшлийн компаниудын цуглуулж буй хувийн мэдээллийн багтаамжийн талаар хууль ёсны ашиг сонирхол байгаа хэдий ч өгөгдөл цуглуулах механизмын хувьд интернэтийн боломж нь Улс орны нөхцөл байдлын үүднээс авч үзвэл илүү хөнөөлтэй юм. Улс орон нь хувийн компаниудын хийхгүй албадлагын хүчний түвшинд үүний гол шалтгаан байгаа юм.
- Цаашилбал, шүүх, хяналтын байгууллага нь мэдээлэл хамгаалах журмыг дагаж мөрдөх үүрэг авсан хувийн компаниудаас илүү, үндэсний аюулгүй байдлын асуудлыг дэгдээгээд байгаа төрийн байгууллагуудад дур зоргоор авирлах боломж олгон, тэдэнд маш хүндэтгэлтэй ханддаг байна. Энэ нь чөлөөт зах зээлд ажиллаж буй хувийн компаниудад хэтэрхий төвөгтэй байдлыг бий болгодог гэдгийг тэмдэглэвэл зохино. Хэрвээ тухайн сайт нь интернетийн системийн ул мөр хянах тогтолцоогоо жаахан гүнзгийрүүлбэл аюулгүй байдлын байгууллагуудад ямар ч нөлөө үзүүлэхгүйгээр тэдэнд мөнгө олох бизнес болгох боломж бий. Хэрэглэгчдийн хязгаарлагдмал боломжийг эдлүүлэх, үнэн хэрэгтээ, үйлчилгээний хэрэглэгчийн баазад нөлөөлдөг халдлагын бодлогын түвшинд хувийн нууцын бодлогын хязгаарласныг ойлгох учраас хяналтын энэ хэлбэрийн түвшин хязгаарлагдмал юм. Гэхдээ болзошгүй санхүүгийн хор уршигийг хамгийн бага байлгах зарим хэлбэрийн нягтлах ажлыг явуулж болно.

1. Хувийн нууцын тодорхойлолт ба хүрээ

- Хувийн нууц нь олон улсын хуулиар баталгаажсан хүний эрх юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйлд:

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

Хэлэлцүүлэг: 17 дугаар зүйл нь хувийн амьдралд оролцох төрийн боломжийг тодорхой хязгаарлаж өгсөн. Ийм оролцоог хувийн салбарт мөн хязгаарлахын тулд юуг өргөжүүлэх ёстой гэж бодож байна вэ? энэ ажлыг хэрхэн хуульчилж болох вэ?

- Хувийн нууцтай байх эрх нь Еврэй, Христосын шашинтан, Мусалманы зэрэг нэлээд олон шашны уламжлал дээр үндэслэсэн, эртний Грек, Хятадад бий болсон маш эртний эрх юм. Тэр үед энэхүү эрхийн тодорхой агуулгаар зөвшилцөлд хүрэхэд хүндрэлтэй байсан нотлогдсон. Энэ нь гадны халдлагаас ангид байх эрхийн зарим үндсэн ойлголтыг гаргасан нь тодорхой байна. Гэхдээ энэ нь янз бүрийн зохиогчид цааш өөр өөр тодорхойлолт гаргаж ирсэн.
 - *Жишээ нь:* 1890 онд энэ сэдвээр Уоррен ба Брандэйс нар “Хувь хүний нууцтай байх эрх” /The Right to Privacy/ хэмээх бүтээлдээ хувь хүний нууц гэдгийг “ганцаараа буюу зөнгөөрөө байх эрх” хэмээн тодорхойлсон байдаг. 1998 оны Элли Лэйк, Мэллисса Уэбэр нарын “Уол-Март” Сүлжээ дэлгүүрийн эсрэг гаргасан нэхэмжлэл/*Lake v. Wal-Mart-Stores Inc (1998)*/-ийн мөрөөр Миннесота мужийн Дээд шүүхээс хувь хүний нууцтай холбогдох дөрвөн төрлийн сонирхлыг тодорхойлсон/*орч. ө.х. “tort” буюу “иргэний эрхэд халдсан үйлдэл” гэж үзэх 4 тохиолдол:* үүнд, хувь хүний халдашгүй дархан байдалд учир шалтгаангүйгээр халдах, хувь хүний нэр эсхүл дүр төрхийг зөвшөөрөлгүй ашиглах, хувь хүнийг ташаа, буруу ойлголт төрүүлэхээр нийтэд мэдээлэх, хувь хүний амьдралыг учир шалтгаангүйгээр олон нийтэд дэлгэх зэрэг болно. 2007 оны НМ нарын Смит болон бусад хариуцагчдын эсрэг гаргасан нэхэмжлэл/*NM and Others v. Smith and Others (2007)*/-ийн мөрөөр Өмнөд Африкийн Үндсэн хуулийн цэцээс хувь хүний нууцыг “хувь хүн амьдралаа өөрийн хүсэл, үзэмжийн дагуу авч явах, амьдрах эрх” гэж тодорхойлсон байдаг. Канад Улсын Дээд шүүхээс 1997 оны Мишел Гоодбөүтийн Лаунжел хотын захиргааны эсрэг үүсгэсэн нэхэмжлэл/*Godbout v. Longueuil (City) (1997)*/-ийн мөрөөр хувь хүний нууцыг “угаас хувийн шинж чанартай шийдвэр гаргадаг, аливаа хувь хүний хараат бус, бие даасан бичил ертөнц” хэмээн тодорхойлсон байдаг. Европын холбооны Хүний эрхийн дээд шүүх энэ ойлголтыг томъёолохоос зайлсхийн: “Шүүх нь ‘хувийн амьдрал’ гэдэг ойлголтыг бүрэн тайлбарлаж, томъёолох боломжгүй бөгөөд ийм оролдлого хийх шаардлагатай гэж үзэхгүй байна” гэжээ. (1992 оны Ниemetзийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эсрэг гаргасан нэхэмжлэлээс /*Niemietz v. Germany, 1992*/)
- Цаашилбал, хувийн нууцын агуулга нь субъектив элементүүдтэй байдаг нь харьцангуй тодорхой юм. Тийм учраас нийгмийн мөн чанарын хувьд зарим хамгаалалтаар түүнийг үр дүнтэй хийнэ гэж нэг болно, эсвэл нэгнийхээ хувийн нууцын хэсгийг найр тавин өгч магадгүй юм. Иймд, хэн нэгний гэр бүлийн байдал бол хувийн нууц боловч дахин дахин олон нийтэд дэлгэснээр үүнийг өөрчилж болно. Үүнтэй холбоотойгоор, нэр төр, эсвэл үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг хүний бусад эрхтэй сөргүүлэн тавьж үзвэл илүү ойлгомжтой тодорхой, илүү объектив хил хязгаартай байна.
- Хүний бүх эрх төртэй холбогддог бөгөөд олон улсын эрх зүйгээр хувийн нууцад хөндлөнгөөс нэвтрэхгүй байх үүргийг төрд ногдуулах нь илүү тодорхой байдаг. Олон улсын шүүхийн олон шийдвэр энэ үзэл санааг илэрхийлж байна. Эдгээр шийдвэрийн нэлээд олонх нь онцгойлон анхаарч буй зүйл бол утас болон бусад

харилцаа холбоонд мониторинг хийхийг оролцуулан цагдаагийн мөрдөн хянах ажиллагааны асуудал бөгөөд мониторинг хийх эрх мэдлээ урвуулан ашиглахгүй гэдгийг баталгаажуулахын тулд хамгаалалт үйлчилж байх ёстой гэдэг асуудал юм.

- *Жишээ нь:* Хувийн нууц гэдэг ойлголтын цар хүрээний хувьд, Европын шүүхээс хүүхдэд эрх олгох, бэлгийн амьдрал, эмнэлгийн чанартай албадлагын эмчилгээнд хөндлөнгөөс оролцох, төрд хадгалагдаж буй хүний нэр, эсвэл тухайн хүний зураг, хүний бие махбодийн болон сэтгэл санааны байдлын талаарх тодорхой төрлийн мэдээллийг олж авах, харилцаа холбооны агуулгыг үл харгалзан хувийн харилцаа холбоо эсвэл утасны яриаг дундаас нь сонсох зэргээр эрхийг зөрчсөн байж болох Улс орнуудын авч байгаа арга хэмжээний нэлээд олон төрлийг тодорхойлсон.
 - *Жишээ нь:* 1992 оны Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эсрэг Нийметзийн гаргасан нэхэмжлэлийн мөрөөр Европын Холбооны Хүний эрхийн дээд шүүхээс “тус ойлголтыг хувь хүн амьдралаа өөрийн сонголтоор авч явах, амьдрах, түүнийгээ гадаад ертөнцөөс бүхэлд нь битүүмжлэх эрх бүхий ‘дотоод тойрог’ хэмээн тодорхойлох нь хэт хязгаарлагдмал байна” гэж дүгнээд, үүний оронд, “хувийн амьдрал нь бусад хүмүүстэй харилцаа бий болгох, үүсгэсэн харилцааг үргэлжүүлэн авч явах, өргөжүүлэх гэсэнбүрэлдэхүүнийг энэ ойлголгод хамруулан авч үзэх шаардлагатай” гэж үзжээ. Тус ойлголтын хамрах хүрээнд ажил хэргийн болон мэргэжлийн харилцааг хамруулан авч үзэн, улмаар ажил хайх зэрэг үйлдэл нь хувь хүний амьдралд тодорхой хэмжээнд оролцох нөхцөл үүсгэдэг гэж онцолсон байна.
- Хувийн нууцтай байх эрх нь хамгийн түрүүнд төрийн оролцоо нөлөөнөөс хамгаалагддаг боловч, олон улсын эрх зүйн дагуу энийг мөн “хэвтээ түвшинд” ч хэрэгжих эрх үздэг. Тухайн тохиолдолд, төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ эсвэл үйлдэл хийхээс татгалзсан аль нэгнийх нь улмаас төр болон хувь хүний хооронд харилцаа байдаггүй бөгөөд энэ нь асуудал болж байна. Чухамдаа, хувийн амьдралыг үр дүнтэй хамгаалахыг шаардсан гомдол зарга нь төрийн-бус этгээдүүд, тухайлбал, хувийн нууцад халдсан тохиолдолд шийтгэл ногдуулж буй этгээдүүдийн хоорондох харилцааг зохицуулахыг төрөөс шаарддаг.

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудалтай холбоотой зарим тохиолдлуудад хувийн нууцын ойлголтын хүрээ хамгийн чухал болдог. Жишээ нь, батлан хамгаалахын сайд ресторанд хувь хүнийхээ хувьд, гэхдээ гадаадын зэвсгийн наймаачинтай хамт оройн хоол идэх үед хувийн нууцтай байх эрхийг хүлээн зөвшөөрүүлэх үү? Ерөнхий сайд хуримын ёслолын ажиллагаанд уригдсан тохиолдолд юу болох вэ?

2. Өгөгдөл хамгаалах ба Хувийн нууц

- Өгөгдөл хамгаалах үзэл санаа нь Засгийн газрын өсөн нэмэгдсээр буй хувь хүмүүсийн талаарх хувийн өгөгдлийн сан дотроос түүний гарал үүслийг үндэслэн олж буй хүний хувийн нууцын хамгийн сүүлийн үеийнх юм. Компьютер эхлээд, дараа нь интернэт бий болсноор өгөгдөл хамгаалах үзэл баримтлалыг боловсруулахад асар их түлхэц өгсөн. Хамгийн эхний өгөгдөл

хамгаалах тухай хуулийг 1970 онд Германы Хэссэ мужаас үүсэлтэй гэж үздэг ба 1973 онд баталсан Швед улсад анхны үндэсний бие даасан хуулийг тооцдог.

- Өгөгдөл хамгаалах үзэл баримтлалын мөн чанар нь хувь хүмүүсээс өөрсдийгөө хэн болохыг тодорхойлж чадах (хувийн өгөгдөл) өгөгдлийг цуглуулах, ашиглахад хяналт тавих эрхтэй юм. Энд гол үзэл санаа нь хувь хүний тухай мэдээллийн сангийн асар их цар хүрээний өсөлтөөс зарим зөрчил бий болж болно гэдэгт оршино. Жишээлбэл, Зар сурталчилгааны компани нь кредит карт хэрэглэх талаарх өгөгдлийн сантай болбол, зар сурталчилгаанд үндэслэсэн худалдан авалтын хэв маягтай хувь хүмүүсийг зорилтот этгээдээ болгох хэрэгтэй.
 - *Жишээ нь:* Өнөө үед нүүр царай таних програм өндөр түвшинд хөгжиж, хүний царай Фэйсбүүк зэрэг олон нийтийн хэрэгслээр өргөн хүрээнд тархсан тул цахим сурталчилгааны самбар ашиглан тус самбарын урдуур өнгөрч буй хүмүүсийг таниулж, өгөгдлийн сан үүсгэх, олон төрлөөр өгөгдлийг шүүж, тэдгээр хүмүүсийн байрлал, аялах зуршил, худалдан авалтын хэв маяг, сонирхол зэргийг тодорхойлон, түүнд тохирсон зар сурталчилгаа нэвтрүүлэх боломж бүрдсэн байна. Одоогоор компаниуд ийм маягийн боломжуудыг ашиглахгүй хэмээн сайн дурын үндсэн дээр харилцан тохирсон боловч, энэ төрлийн технологи аль хэдийн бий болчихсон.
- Дийлэнх өгөгдөл хамгаалах дэглэм нь тухайн хувь хүнийг хэн болохыг тодорхойлж чадахуйц бүхий л мэдээллийг агуулсан хувь хүний өгөгдлийн маш өргөн хүрээний тодорхойлолтоос эхэлдэг. Журам нь хувийн өгөгдөлд (цуглуулах, хадгалах болон бусад гэх мэт) хийх аль ч үйл ажиллагааг хамарна гэж маш өргөн хүрээгээр бас тодорхойлсон өгөгдлийг боловсруулах ажиллагаанд дагаж мөрдөнө. Журмын дагуу өгөгдөл хянагч этгээдийг ч гэсэн өгөгдлийг боловсруулах зорилго, арга хэрэгслийг тодорхойлж буй аливаа бие хүн, хувь хүн байна хэмээн мөн л маш ерөнхий тодорхойлсон.
- Эдгээр тодорхойлолтын дагуу авч үзвэл гар утсандаа утасны дугаар хадгалсан ямар ч хувь хүн нь өгөгдөл хянагч болно. Гэсэн хэдий ч, ихэнх өгөгдөл хамгаалах дэглэмийг бодгаль хүний "цэвэр хувийн болон ахуйн" шинжтэй үйл ажиллагаанд, бүхэлд нь буюу хэсэгчлэн боловсруулах ажиллагааны удирдлага автомат хэрэгслээр хийгддэг (өөрөөр хэлбэл ихэвчлэн цахим хэлбэрээр), эсвэл файлын системийн нэг хэсэг болж буй өгөгдөл нь албан бус болон биет байдлаар (өөрөөр хэлбэл, цахим бус хэлбэрээр) хадгалагдсан бусад өгөгдлийг боловсруулахад дагаж мөрдөхгүй.

Хэлэлцүүлэг: Өгөгдлийг хамгаалах үзэл санааны талаар та юу гэж бодож байна вэ? Хувь хүний нууцын журмыг нэмэлтээр гаргах шаардлагатай гэж бодож байна уу? Өгөгдөл цуглуулах, боловсруулах ажиллагаанд ямар шинжтэй нөхцлүүдийг оруулах хэрэгтэй вэ?

- Хувийн өгөгдлийг цуглуулах, ашиглах асуудал нь Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий Ассемблейн 45/95 тогтоолоор баталсан компьютер дахь хувийн өгөгдлийн файлуудыг зохицуулах удирдамжийн зарчмуудыг удирдлага болгоно. Үндэсний хууль тогтоомжтой холбогддог байсан өгөгдөл хамгаалах

үндсэн арван зарчмыг тогтоосон бөгөөд үүнийг тоймлон авч үзвэл дараах байна.

Үүнд:

- *Хууль ёсны бөгөөд шударга байх*: Өгөгдөл мэдээллийг цуглуулах ажиллагааг шударга, хууль ёсны дагуу, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зарчим, зорилгод харшлахгүйгээр хийх ёстой
 - *Нягт нямбай байх*: Мэдээлэл хянагч нь үнэн зөв, ач холбогдолтой байдлыг хангахын тулд тогтмол мэдээллийг шалгах үүрэгтэй. Энэхүү зарчмаа хангахын тулд аль болох бүрэн дүүрэн цуглуулж, орхигдуулах алдаанаас зайлсхийвэл зохино.
 - *Зорилго-үзүүлэлтдээ нийцэх*: Өгөгдөл цуглуулсан зорилго нь хууль ёсны бөгөөд өгөгдлийн сэдэвт анхаарлыг хандуулсан байвал зохино. Өгөгдөл нь бусдын зохисгүй зорилгод ашиглагдахгүй бөгөөд энэ зорилгоо биелүүлж байхад шаардлагатай урт удаан хугацаагаар хадгалагдах ёстой байна.
 - *Сонирхогдож буй этгээд хандах боломжтой байх*: Өгөгдлийн эзэн нь өөрийнхөө мэдээллийг цуглуулж, боловсруулж буйг мэдэх эрхтэй бөгөөд хэт их хугацаагаар саатуулах, зардал гаргахгүйгээр ойлгомжтой хэлбэрээр өгөгдөлд нэвтрэх, тодорхой алдааг засах буюу устгах зэргээр хандах боломжтой байна.
 - *Ялгаварлан гадуурхахгүй байх*: эдгээр зарчимд ялгаварлан гадуурхсан шинжтэй аль ч зүйл хүлээн зөвшөөрөгдөхгүй.
 - *Аюулгүй байдал*: зөвшөөрөлгүй хандалт хийх, буруу хэрэглэх, эсвэл физик бохирдол зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлийн эрсдлээс өгөгдлийг хамгаалахын тулд тодорхой арга хэмжээ авбал зохино.
- Эхний таван зарчимд үл хамаарлын шаардлага хамаарч болохыг энэхүү удирдамжаар хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ энэ нь үндэсний аюулгүй байдал, ниймгийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, болон бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй шаардлагад нийцсэн байна. Дээрх зарчмыг хүндэтгэн баталгаажуулах үүрэг хариуцлага хүлээсэн, журмыг зөрчвөл санкц хүлээлгэх эрх бүхий хараат бус хяналтын байгууллагыг томилохыг уриалдаг. Харьцуулахуйц хамгаалалт санал болгодоггүй улс орнуудад мэдээллийн түгээлтийг хязгаарлахын мөн уриалдаг. Сүүлчийнх нь бүр илүү чухал юм. Европын холбоо нь өгөгдөл хамгаалах тодорхой журмаа дагаж мөрддөггүй улс орнуудтай өгөгдөл хуваалцахыг хатуу хориглодог. Энэ журам нь тэдгээр улс орнуудтай ажиллах худалдааны харилцаанд маш чухал ач холбогдолтой хязгаарлалт тогтооход үр нөлөөтэй байдаг.
- *Жишээ нь*: Европын холбоо нь өгөгдөл хамгаалах хангалттай стандарттай Швейцари, Канад, Аргентин зэрэг тодорхой улс орнуудын системийг энэ хөтөлбөрөөрөө хүлээн зөвшөөрдөг. Гэсэн хэдий ч, Америкийн Нэгдсэн Улсад хувийн хэвшлийнхний мэдээллийг хамгаалахтай холбогдсон төвлөрсөн хууль эрхзүйн зохицуулалтын хувьд дутагдалтай тул, энэ асуудлаар “хангалттай” гэсэн үнэлгээ авахааргүй байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Аж үйлдвэрийн газраас Хувийн нууцын зарчмыг баталгаажуулах хөтөлбөр/International Safe Harbor Privacy Principles Certification Program/-ийг гаргажээ. Тус хөтөлбөрт компаниуд сайн дурын үндсэн дээр Аюулгүйн арга хэмжээний долоон зарчмыг мөрдөхөөр бүртгүүлэн, гэрчилгээждэг байна. Эдгээр зарчмууд нь Европын холбооны өгөгдөл хамгаалах дүрмүүдтэй харилцан нийцсэн бөгөөд өгөгдөл авах зорилго, гуравдагч этгээдэд цааш нь өгөгдөл дамжуулах буюу бусад зорилгоор ашиглахаас татгалзах хувь хүний эрх, өгөгдлийн аюулгүй байдлын

шаардлага зэрэг болон бусад төрлийн мэдэгдэл өгдөг байна. Гэрчилгээжсэн компани нь Европын холбооны дүрмүүдийн хүрээнд хувь хүний нууцлал хангалттай хамгаалагдсан гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

- Субъектийн зөвшөөрөл нь ямар ч өгөгдөл хамгаалах системийн гол хэсэг бөгөөд энэ нь хоёрдмол утгагүй байх ёстой. Гэсэн хэдий ч, нэг нь байнга интернетэд суурилсан үйлчилгээ үзүүлэх зэргээр хугацаа, нөхцөлөө тохиролцсоноо тодорхой чагтлан тэмдэглэх нь энэ стандартад нийцнэ. Ихэнх тохиолдолд субъектүүд уншдаггүй хэдий ч, эсвэл тэд хугацаа, нөхцөлийг уншаад ч ойлгоход хүндрэлтэй байж магадгүй ч энэ нь баримт болно. Субъектэд хэтэрхий их үүрэг үүрүүлээ гэж шүүмжилж болох ч, хэн нэгний мэдээллийг хянах тухайн цаг үед бүх санаа нь дийлэнхдээ энэ рүү зайлшгүй хөтөлж дагуулж байдаг.
- Хувийн нууц болон өгөгдлийн хоорондын нарийн холбоо хамаарал нь чухал асуудал юм. Нэлээд хэдэн ялгааг энд гаргаж бичив. Үүнд:
 - Хувийн нууцыг дангаар нь хамгаалах болон өгөгдлийг хамгаалах журмын хооронд маш чухал ялгаатай талууд байна. Хувийн бие дааж тусгаар байх тодорхой хүрээг хуучин хамгаалж байсан ч, сүүлдээ төрийн болон хувийн хэвшлийн байгууллага хувь хүний тухай мэдээллийг системтэйгээр цуглуулахад оролцох үед үүсэн гарч болох тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарал хандуулдаг болж байна.
 - Өгөгдөл хамгаалах журам нь хувийн нууцынхаас ялгаатай бөгөөд хоёулаа өөрийн хүрээ, эрх зүйн хэм хэмжээтэй. Өгөгдөл хамгаалалт нь хүнийг таниулах бүхий л өгөгдөлд хэрэглэгдэж байхад, хувийн нууцыг хэзээ ч бүх талаас нь тодорхойлж байгаагүй боловч ч, хувийн нууц гэж хүлээн зөвшөөрөх шаардлагатай байгаа хүний тухай энгийн мэдээлэл, маш явцуу мэдээлэлд л хэрэглэгдэнэ.
 - Үүний зэрэгцээ, өгөгдөл хамгаалах журам нь өргөн хүрээнд ярихын хэрээр илүү хязгаарлагддаг. Зөвхөн өгөгдлийг автоматаар боловсруулах, өгөгдлийг зохион байгуулалтын бүтцэд оруулан боловсруулахад энэ журмыг хэрэглэнэ. Тэгвэл хувийн нууцын журам нь аль ч мэдээлэлд хэрэглэгдэнэ. (жишээ нь, хүн ресторанд өөр нэг хүнтэй хоол идэж байгаа баримт).

3. Мөрдөн хянах ажиллагаа

- Интернет нь өргөн хүрээнд өгөгдөл цуглуулах ажлыг олон талаар хялбаршуулсан. Өгөгдөл цуглуулах, тоон өгөгдөл боловсруулахад өндөр хүчин чадал бүхий компьютерүүдийг ашиглах нь оффлайн төрлийн бусад холбооны хэрэгслээс илүү хялбар байх нь мэдээжийн ойлголт юм. Тухайлбал, өнгөрсөн үед, утасны харилцан яриаг амьдаар нь сонсох буюу дуу хураагуураас сонсохоос өөр аргагүй байдаг байсан бол, өнөө үед тухайлсан үгээр нь хялбархан хайх боломжтой болсон байна.
- Түүнчлэн, интернет холбооны дэд бүтцийг нэгтгэж, хялбаршуулсан. Анхандаа холбоог тус тусдаа, харилцан хамааралгүй сүлжээгээр дамжуулан явуулдаг буюу, тухайлбал, захидал илгээхэд шаардагдах дэд бүтэц, утсаар дуудлага хийхэд шаардагдах дэд бүтэц нь хоорондоо адилгүй, бие даасан шинжтэй байжээ. Иймд аливаа бичгэн харилцаа эсхүл телефон холбоог хянахын тулд хоёр өөр төрлийн ажиллагаа явуулдаг байсан байна. Үүний эсрэгээр, онлайн холбоо нь харилцан адилгүй холбооны олон төрлүүд/утас, имэйл, видео хурал г.м/-ийг

нэгтгэн нэг төрлийн өгөгдлийн урсгал болгодгоороо өгөгдөл олборлох явцыг эрс хялбаршуулсан.

- Upstream collection буюу Сөрөг урсгалаар өгөгдөл цуглуулах гэдэг нь шилэн кабель болон бусад төрлийн дэд бүтцээр дамжин урсаж буй мэдээллийг дундаас нь саатуулахыг хэлнэ. Снөүдэний хийсэн илчлэлтээс үүдэн, сөрөг урсгалаар дамжуулан мэдээлэл цуглуулах ажлыг АНУ өөрийн улсад байрлалтай харилцаа холбооны компаниудтай хамтран интернэтийн тулгуур бүтцийн зангилаа цэгүүд дээр хянах төхөөрөмж суулгаснаар хэрэгжүүлдэг гэсэн ойлголт олны дунд дэлгэрээд байна.
- Өөр нэгэн арга хэрэгсэл нь Deep packet inspection (DPI) буюу Нарийвчилсан үзлэг бөгөөд, үүнийг интернэтийн сүлжээнд урсаж буй бүх өгөгдлөөс түлхүүр үг эсхүл компьютерийн эх кодын хэсэг зэрэг тодорхой тэмдэглэгээ хайх гэж ойлгож болно. Вирус илрүүлэх, сүлжээний халдлагаас хамгаалах зэргээр DPI-ийг тодорхой хүрээнд ашиглах хуулийн үндэслэл байдаг боловч, нийтэд ашиглагддагаараа мөрдөн хянах ажиллагааны түрэмгий хэлбэр буюу халдлагын шинж чанартай болж байна. Үүнээс гадна, DPI-ийн боловсронгуй хувилбар нь урсаж буй өгөгдлийн хөдөлгөөнийг өөрчлөх хүчин чадалтай. Тухайлбал, өгөгдөл ашиглагчдад өөрт нь мэдэгдэлгүйгээр тухайн нэг улстөрийн зүтгэлтний талаар вэбсайт дээр байршуулсан таагүй өгөгдлийг устгаж, түүнийг таатай өгөгдлөөр сольж болох юм.
- Эдгээр өгөгдөл цуглуулах арга хэлбэрүүдээс гадна АНУ-ад PRISM гэдэг код нэрээрээ танигдсан хоёрдогч хөтөлбөр байдаг. Тус хөтөлбөр нь АНУ-ын компаниудын хадгалагдсан өгөгдлөөс олборлолт хийдэг бөгөөд тэдгээрийн хэрэглэгчдийн талаар асар их хэмжээний мэдээлэл агуулдаг байна. Снөүдэний задруулсан мэдээллээс үзэхэд АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын газар голлох онлайн болон харилцаа холбооны байгууллагуудын төв серверт чөлөөтэй нэвтэрдэг бөгөөд дурын зүйлийнхээ талаар мэдээлэл цуглуулах боломжтой байдаг гэсэн байна.
- Бидэнд бусад улс орнуудаас хэрэгжүүлдэг ижил төрлийн хөтөлбөрүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хараахан байхгүй боловч бусад олон улс орнууд ийм төрлийн хөтөлбөртэй, эсвэл энэ талаар АНУ-тай хамтран ажилладаг гэсэн нотолгоо бий. Жишээ дурдвал, Five Eyes programme буюу “Таван нүд хөтөлбөр” нь АНУ, Их Британи, Австрали, Канад болон Шинэ Зеланд гэсэн таван улсыг нэгтгэсэн хөтөлбөр юм.
- Зарим улс өгөгдөл саатуулах аргыг хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд аливаа харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчид тодорхой хугацаанд өгөгдлөө хадгалж, түүн дээр нь аюулгүй байдлын буюу цагдаагийн шинжээчид үзлэг, шинжилгээ хийдэг байна.
 - *Жишээ нь:* Ийм төрлийн олонд танигдсан системүүдийн нэг нь Европын холбооны 2006/24/ЕС буюу Өгөгдөл саатуулах тогтоол юм. Энэ тогтоолоор Европын холбооноос бүх гишүүн улсуудаа аливаа үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг бүх хэрэглэгчдийнхээ телефон утас, интернэт холбооны мэдээллийн урсгал байршлын өгөгдлийг 6 сараас 2 жил хүртэлх хугацаанд хадгалах тухай хууль тогтоомж батлах үүрэг өгсөн байдаг. 2014 оны 4 дүгээр сард Ирландын цахим эрхийн байгууллага /Digital Rights Ireland/-аас гаргасан нэхэмжлэлийн дагуу Европын холбооны Шударга ёсны дээд шүүх /ЕСJ/-ээс энэ Тогтоол нь Европын холбооны Үндсэн эрхийн тухай Тунхаг бичигт заасан нууцын тухай болон мэдээлэл хамгаалах заалтуудыг зөрчсөн гэсэн үндэслэлээр Өгөгдөл саатуулах тогтоолыг хүчингүй болгосон.

Хэлэлцүүлэг: Эдгээр холбоо хамаарал та бүхэнд төсөөлөгдөхөөгүй байсан уу? Монгол улс мөрдөн хянах ажиллагаанд өргөн хүрээгээр оролцдог гэж бодож байна уу? Та үүнд санаа зовж байна уу? Хятад улсын мөрдөн хянах ажиллагааны талаар юу гэж бодож байна вэ?

Олон улсын хэм хэмжээ

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө ба хувийн нууцын холбоо хамаарлын талаар 2013 оны Нэгдсэн Үндэсний байгууллагын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгчийн тайланд:
 - Хувь хүмүүс чөлөөтэйгөөр мэдээлэл хайх, хүлээн авах, эсхүл хувийн нууцын эрхийг хүндэтгэж, хамгаалж, хөхиүлэн дэмжихгүйгээ өөрийгөө бүрэн илэрхийлэх эрхийг баталгаажуулж чадахгүй байна. ... Хувийн нууц, аюулгүй байдал, харилцаа холбоонд нэрээ нууцлах эрхийн баталгааг хангахуйц түвшний хууль эрх зүйн орчин, стандарт бүрдээгүй цагт сэтгүүлчид, хүний эрхийн төлөө тэмцэгчид, шүгэл-үлээгчдийн харилцаа холбоо нь төр засгийн мөрдлөгө хяналтаас гадуур байгаа гэсэн баталгаа үгүй.
- Хамгийн эхний стандарт бол аливаа мөрдөн хянах ажиллагааны хөтөлбөр хувийн нууцтай холбогдох тохиолдолд заавал “хуулийн дагуу байх” гэсэн олон улсын шүүхээс тогтоосон хатуу шаардлагад үндэслэдэг. Үүнийг өөрөөр хэлбэл, аливаа мөрдөн хянах ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн зохицуулалт нь нээлттэй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх боломжит нөхцлүүдийг тодорхойлон заасан байх шаардлагатай.
 - *Жишээ нь:* Английн *Malone v. 1984*, Хүний эрхийн Европын шүүхэд гаргасан мэдүүлэгт илэрхийлсэнээр:

1 дүгээр хэсэгт заасан эрхүүдийг хамгаалах, тэдгээр эрхүүдтэй холбоотой төрийн байгууллагуудын хөндлөнгийн оролцоог хязгаарласан дотоодын хууль тогтоомж, хууль эрх зүйн хамгаалалтыг арга хэмжээ заавал байх ёстой. Нэн ялангуяа төрийн эрх мэдэл далд хэрэгждэг газарт хөндлөнгийн оролцоо байх бодит эрсдэл байгаа нь тодорхой байна. ... иймд ямар нөхцөл байдалд, ямар төрийн эрх бүхий байгууллагуудад ийм төрлийн нууц ажиллагаа явуулах, цаашлаад хувийн амьдрал, хувийн харилцаатай холбоотой асуудалд онц ноцтойгоор оролцох эрх үүсдэг болохыг хууль тогтоомжоор хангалттай хэмжээнд, маш тодорхой ойлголтыг иргэдэд өгөх ёстой.
- Нэгдсэн Үндэсний байгууллагын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч 2013 оны тайландаа эрх зүйн орчинг маш ойлгомжтой тодорхой болгох шаардлагатай байгааг цохон тэмдэглэсэн.

Үндэсний хууль эрх зүйн орчны хангалтгүй байдал нь харилцаа холбоонд хувийн нууцтай байх эрхийг дур зоргоор, хууль бусаар зөрчих таатай хөрсийг бүрдүүлж, үзэл бодлын эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалахад аюул занал учруулж байна.
- Хоёр дахь үндсэн түлхүүр асуудал бол ил тод байдал юм. Ил тод байдал нь ил тод байдлын ерөнхий зарчим болон үр нөлөөтэйг нотолсон олон улсын мэдэгдлүүдээс урган гарч ирдэг.

- *Жишээ нь:* үндэсний аюулгүй байдлын шаардлагыг ил тод байдалтай хэрхэн тэнцвэржүүлэхийг чиглүүлж буй мэдэгдэл болох Үндэсний аюулгүй байдлын бөгөөд Мэдээллийн эрх чөлөөний Тшване зарчимд үүний ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн. Үүнд:

Зарчим 10Е. Мөрдөн хянах ажиллагаа

...

(2) Олон нийт нь мөрдөн хянах ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байгууллагын тухай болон тийм мөрдөн хянах ажиллагаа явуулсан тухай статистик мэдээллийг авах эрхтэй байвал зохино.

(3) Үүнээс гадна, олон нийт аливаа хууль бус мөрдөн хянах ажиллагааны баримт мэдээллээр бүрэн хангагдсан байвал зохино. Ийм мөрдөн хянах ажиллагааны талаарх мэдээлэл нь мөрдөн хянах ажиллагаанд өртөгдөж буй хүмүүсийн хувийн нууцтай байх эрхийг зөрчихгүйгээр, байж болох хамгийн дээд хэмжээгээр ил тод байх ёстой.

(4) Эдгээр зарчмууд нь мөрдөн хянах ажиллагаанд өртсөн байж болзошгүй гэдэгт итгэж байгаа, эсвэл өртсөн хувь хүмүүсийн нэмэлт материаллаг болон процессын эрхийг хөндөхгүйгээр мэдээлэл олж авах олон нийтийн эрхэд анхаарлаа хандуулна.

(5) Ил тод болгох өндөр магадлалыг хүлээн зөвшөөрсөн энэ зарчим нь гадаад улсын засгийн газрын үйл ажиллагааг мөрдөн хянахтай холбоотой мэдээллийн хувьд хэрэглэгдэхгүй.

- *Жишээ нь:* 2015 оны Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын тусгай бүрэн эрхт төлөөлөгчдийн Хамтарсан тунхаглалын 8(с) хэсэгт ил тод байдлын ач холбогдлыг мөн цохон тэмдэглэсэн:

Улс орнууд нь мөрдөн хянах ажиллагаа явуулахдаа системийн хувьд, үүн дотроо түүний бодлого, эрх зүйн орчины мэдээллийг байнга бүрэн дүүрэн ил тод байлгах ёстой.

- Гуравдугаарт, мөрдөн хянах ажиллагааны зохистой (жишээ нь, хараат бус, үр нөлөөтэй) хяналтыг баталгаажуулах нь чухал юм. 2015 оны Хамтарсан тунхаглалын 8(d) дэх хэсэгт зааснаар:

Мөрдөн хянах ажиллагааны системд хангалттай хараат бус хяналт тавьдаг байх ёстой. Тэр дундаа эрх бүхий байгууллагууд мөрдөн хянах ажиллагааг бодит зорилтдоо нийцүүлж явуулж уу гэдгийг хянана.

- Дөрөвдүгээрт, мөрдөн хянах ажиллагаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зайлшгүй шаардлагын шалгуурыг хангасан тохиолдолд л түүнийг хэрэгжүүлнэ. “Зайлшгүй шаардлага” гэдгийг юун түүрүүнд, тухайн үйл ажиллагаа нь хууль ёсны зорилтыг хангуулах цорын ганц боломж болсон, эсвэл ингэх хэд хэдэн арга зам байгаа ч тухайн арга зам нь хамгийн түрэмгий бус арга хэлбэр байх тохиолдол гэж ойлгоно. Нийтийг хамарсан мөрдөн хянах хөтөлбөрүүд болон Снөүдэний нийтэд илчилсэн хөтөлбөрүүд хүний хувийн нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой ноцтой харанга дэлдэж чадсан эсэх нь эргэлзээтэй. Харин аюулгүй байдлын агентлагууд нийтийг хамарсан мөрдөн хянах хөтөлбөрт ингэж их цаг хугацаа, анхаарал хандуулахын ашиг тус, мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч буй зардал зэрэг нь ихээхэн анхаарал татаж, шүүмжлэл дагуулсан асуудал болоод байна.

- Зайлшгүй шаардлагатай байх хэм хэмжээгээр одоогийн мөрдөн хянах тогтолцоонд олон байгаа зорилгогүй хандлага нь хууль бус бөгөөд үүний оронд хор уршигийн тодорхой эрсдлүүдэд үндэслэсэн, илүү чиглэл зорилготой хандлагыг зөвшөөрөхийг улс орнуудаас шаардахыг зөвлөж байна.
- Дахин хэлэхэд, 2015 оны Хамтарсан тунхаглалын 8(a) and (b) хэсэг үүнд чиглэсэн бөгөөд дараах байдлаар илэрхийлсэн. Үүнд:

Өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон гурван талт шалгуурын нэг болох зайлшгүй шаардлагатай эсэх тухай шалгуурын хүрээнд мөрдөн хянах ажиллагааг явуулахдаа зөвхөн тодорхой хугацаанд, хязгаарлагдмал хүрээнд төвлөрч, чингэхдээ нэг талаас хууль хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг хангуулах асуудал, нөгөө талаас хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх, халдашгүй дархан байхын тэнцвэрийг хадгалах шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, хууль сахиулах, аюулгүй байдлыг хангуулах зорилгод хамааралгүй үндэслэлээр хувь хүний мэдээллийг авч үлдэх нь хууль бус юм. Харин зөвхөн тодорхой хугацаанд, хязгаарлагдмал байдлаар, нэг талаас хууль сахиулах, аюулгүй байдлыг хангуулах асуудал, нөгөө талаас хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх, халдашгүй дархан байхын тэнцвэрийг хадгалах тохиолдолд хувь хүний мэдээллийг хууль хэрэгжүүлэх, эсвэл аюулгүй байдлыг хангуулах зорилгоор авч үлдэж болох юм.

- Эцэст нь хэлэхэд, хувийн этгээдүүд аливаа нэрээ нууцлах болон шифлэлтийн арга хэрэгслүүдийг ашиглах боломжтой байх ёстой. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэхдээ нууц нэр ашиглахын ач холбогдлыг Европын зөвлөлийн Харилцаа холбооны эрх чөлөөний талаарх Тунхаглалаар хүлээн зөвшөөрсөн.

Онлайнд мөрдөн хянах ажиллагааны эсрэг хамгаалалтыг баталгаажуулах, мэдээлэл, үзэл санааг чөлөөтэй илэрхийлэх бэхжүүлэхийн тулд (...) улс орнууд интернэт хэрэглэгчдийн хүсэл эрмэлзлийг хүндэтгэн тэдгээрийг таниулж илчлэхгүй байвал зохино.

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгчдийн 2015 оны Хамтарсан тунхаглалын 8(e) хэсэгт мөн ингэж хүлээн зөвшөөрөгдсөн. Үүнд:

Онлайнд шифр/код болон нууц нэр хэрэглэх нь үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг чөлөөтэй эдлэх боломжтой байх бөгөөд аливаа хориг, саад учруулж болохгүй. Харин хүний эрхийн хуулийн хүрээнд зөвхөн гурван-талт шалгуурыг хангасны үндсэн дээр нарийвчилсан хязгаарлалт хийхийг зөвшөөрнө.

Хэлэлцүүлэг: Эдгээр зарчмууд нь бодитой, эсвэл идеалист юм шиг санагдаж байна уу? Монголын тагнуулын байгууллага эдгээр журмыг заримыг нь, эсвэл бүгдийг нь хүлээн зөвшөөрнө гэж та бодож байна уу? Тэгвэл алийг нь? Эдгээрийн чухам аль нь хүлээн авахад илүү хүндрэлтэй байх болно гэж та бодож байна вэ?

Интернэттэй холбоотой лавлагаа

1. Centre for Law and Democracy, *A Truly World-Wide Web: Assessing the Internet from the Perspective of Human Rights* (2012). Available at: <http://www.law-democracy.org/wp-content/uploads/2012/04/final-Internet.pdf>.
2. Special international mandates on freedom of expression, Joint Declarations of 2011 and 2015, available at: <http://www.osce.org/fom/66176>.
3. Council of Europe, *Declaration on Freedom of Communication on the Internet*, Principle 7 (2003). Available at: http://www.coe.int/t/information/society/documents/Freedom%20of%20communication%20on%20the%20Internet_en.pdf.
4. Michael Karanicolas, *Travel Guide to the Digital World: Surveillance and International Standards* (2014). Available at: <http://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2012/08/Travel-Guide-to-the-Digital-World-Surveillance-and-International-Standards.pdf>.
5. International Telecommunications Union, *Measuring the Information Society* (Geneva: 2011). Available at: <http://www.itu.int/net/pressoffice/backgrounders/general/pdf/5.pdf>.
6. Internet Rights and Principles Dynamic Coalition, *Charter of Human Rights and Principles for the Internet*, available at: <http://irpcharter.org/charter/>.
7. Centre for Law and Democracy, *Commentary on the Charter of Human Rights and Principles for the Internet*, available at: <http://www.law-democracy.org/live/commentary-on-internet-rights-and-principles-charter/>.

Модуль 8: Өөрийн зохицуулалт

1. Танилцуулга

- Өөрийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн хариуцлагатай байдал, сэтгүүл зүйн мэргэжлийн стандартууд бөгөөд төрийн шууд үүрэг даалгаваргүй, эрүүгийн хуульд заасан төрийн зохицуулалт, төрийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлдэг хяналтын зохицуулалтгүйгээр тэдгээр зарчмаа баримталж буй эсэхэд хяналт тавьдаг механизм юм.
- Өөрийн зохицуулалтын шалтгаан нь:
 - Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бэхжүүлэх: төрийн болон хуулийн хяналт шалгалтаас тусгаарладаг.
 - Зах зээлд итгэл инэмшилтэй байдлыг нэмэгдүүлэх: сэтгүүл зүй болон нийтийн хэвлэл мэдээллийн институцэд олон нийтийн хууль ёсны байдлын урьдач нөхцөл болно.
- Өөрийн зохицуулалтын тогтолцоо нь үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Өөрийн зохицуулалтын үндсэн гол элементүүд нь (1) ёс зүйн код дүрэм (2) ерөнхийдөө тусгай байгууллагаар, бидний хэлж заншсанаар Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр хянагдаж, хариуцлага хүлээлгэх тогтолцоо юм.

2. Хэвлэл мэдээллийн эсвэл Хэвлэлийн зөвлөл: Гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа

Өргөдөл гомдол хүлээн авах

- Хэвлэлийн зөвлөлийн хамгийн анхны гүйцэтгэх үүрэг нь хэвлэл мэдээллийн мэргэжлийн үйл ажиллагааны талаарх гомдлыг олон нийтээс хүлээн авах байдаг. Үүнийг зохих ёсоор хийхийн тулд зөвлөл нь мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу болохыг тогтоосон стандарт, ерөнхийдөө баримтлах ёс зүйн кодыг тогтоох хэрэгтэй болдог. Мөн тэд гомдлыг хянан шийдвэрлэх нарийн тодорхой процедуртай байх шаардлагатай. Зарим тохиолдолд тусгай гомдол хэлэлцэх байгууллага нь энэ системийнхээ нэг хэсэг болж байдаг. Ерөнхийдөө нь, энэ байгууллага үндсэн хэвлэл мэдээллийн зөвлөлөө байгуулж болно. Гэхдээ энд бусад гишүүдийг оролцуулж, ихэнхдээ олон нийтийн төлөөлөл олонх нь болдог байж болно. Өөрөөр хэлбэл, энэ бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл уруу илүү хазайсан байна гэсэн хардлагыг зөвтгөх боломжийг нээж өгнө.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих нь

- Олон хэвлэлийн зөвлөлд гомдол хэлэлцэх үйл ажиллагаанаас гадна хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах нийтлэг эрх хэмжээ олгогдсон байдаг. Дэмжлэг үзүүлэх талаасаа, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, ач холбогдлын тухай хэвлэл мэдээллийн ажилтнуудын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх ажлыг явуулдаг. Энэ хүрээнд нийгмийн төрөл бүрийн салбарынханд чиглэсэн, эсвэл янз бүрийн сэдэв асуудлаар сургалт, семинар явуулах, мэдлэг дээшлүүлэх кампанит ажил, гадны туршлага хуваалцах зэрэг олон янзын үйл ажиллагаанд татан оролцуулдаг.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хамгаалалт гэдэгт энэхүү эрхийг зөрчсөн халдлагад хариу үзүүлэх шаардлагаас хамаарч, мөн өргөн хүрээний үйл

ажиллагаанд татан оролцуулна. Зарим тохиолдолд, хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй хууль батлагдахаас нь өмнө төсөлд нь санал өгөх үйл ажиллагаа явуулдаг. Мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний халдлагын эсрэг эсэргүүцэл илэрхийлж болно. Зарим тохиолдолд тэд шууд хамгаалах үйл ажиллагаанд ч оролцож болно. Тухайлбал, хуулийн асуудалд холбогдсон хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлын сургалт, эсвэл аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмжөөр хангах зэргээр сэтгүүлчдийн аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Бүртгэл

- Олон улсын эрх зүйгээр үүнийг зарим талаараа зөрчилтэй гэж үздэг хэдий ч олон улс оронд сонины бүртгэлийн систем байдаг. Бусад улс орны туршлагаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дарамт учруулах байдлаар урвуулан ашиглагдаж болдог дутагдалтай тал харагддаг тул бүртгэлийг хязгаарлахыг зөвлөсөн. Хэрэв сониныг бүртгүүлэхийг шаарддаг бол хэвлэлийн зөвлөлөөр хянуулснаар урвуулан ашиглагдах эрсдэл нь буурна. Энэ бол Индонезид байдаг жишээ юм.

Нийгмийн хэлэлцүүлгээр шийдвэр гаргах

- Нийгэм илүү ардчилсан болохын хирээр уламжлалт ойлголт, харилцаа алга болж болно. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй илүү холбоо хамааралтай байдаг. Сэтгүүлчид заримдаа юу ч хамаагүй хүссэнээ бичих, хэвлэн нийтлэхийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэж ойлгодог. Бусад нийгмийн гишүүдэд ч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний шинэ хил хязгаарыг ойлгох, хүндэтгэхэд эргэлзээ байнга төрдөг. Жишээ нь, хувь хүмүүс нийгмийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг явуулах дургүй байгаа бол улс төрчид маш хүчтэй шүүмжлэлд өртөхгүй байх боломжтой.
- Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд зарим улс оронд хэвлэлийн зөвлөл хувь хүнд чиглэсэн гомдлоос гадна, өргөн хүрээнд хэлэлцүүлж маргааныг шийдвэрлэх үүрэг хүлээдэг.
 - *Жишээ:* Индонезид Хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн ажиллагаанд тавих зүй ёсны, тохирох хязгаарлалтын тухай маргалдаантай, үл ойлголцолтой байсан хэвлэл мэдээлэл, Лалын шашинтны холбооны хооронд хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хэвлэл мэдээлэл болон цагдаа, засгийн газар зэрэг нийтийн албан тушаалтнуудын хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэхэд мөн ингэж ажилласан.

Мэргэжлийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих

- Олон улс оронд хэвлэлийн зөвлөл маш сайн мэргэжлийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихийг тэргүүн ээлжинд тавьж, гомдол гарахаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Энэ бол үндсэн зорилт нь болдог. Их дээд сургууль, сургалтын байгууллагууд, засгийн газар, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хамруулан бусад оролцогчид нь үүний төлөө гол хариуцлага хүлээдэг. Гэхдээ, зөвлөл нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, бусад санаачлагуудыг зайлшгүй боловсронгуй болгоход энэ туршлага нь тусална.

Хэлэлцүүлэг: Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн хувьд зайлшгүй үүрэг ролийг та юу гэж харж байна вэ? Аль хэсэг нь маш чухал, аль арай бага гэж дүгнэж байна вэ?

Баримтлах ёс зүйн код

- Хэвлэл мэдээллийн гомдол барагдуулах аль ч тогтолцооны хувьд ёс зүйн код амин чухал бүрэлдэхүүн хэсэг нь болно. Ёс зүйн код нь нэлээд олон үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - Түүний амин чухал зүйл болсон код нь гомдлын эсрэг шүүн хэлэлцэх хэм хэмжээний нийлбэр юм. Үүнтэй холбогдоод, энэ нь зохицуулалтын арга хэрэгсэл болно (жишээ нь, биеэ авч зан үйлийн зайлшгүй баримтлах хэм хэмжээг тогтоодог). Үүнтэй холбогдуулан, уг тогтолцоог өөрийнх нь шударга байдлыг хангах нь чухал юм. Тэдэнд ойлгомжтой тайлбарлаж байгаагүй хэм хэмжээндээ сэтгүүлчид нийцэн ажиллахыг зохистойгоор хүлээх нь төвөгтэй байна. Маш ойлгомжтой бичсэн кодтой байх нь шударга байдлын нэг хэсэг болсон цаг хугацааны туршид тууштай хэрэглэгдэж болно гэж урьдаас харж хангаж ажиллах нь тустай.
 - Олон нийтийн хувьд, гомдлыг шийдвэрлэхэд хэрэглэгдүүн болдог ёс зүйн код нь хэвлэл мэдээллийн төлөвшил байдлаараа ямар стандарттай байхыг хүсэн хүлээж байгаагаар тодорхойлдог. Энд чухал зүйл нь ардчилалд шилжиж буй улс орнуудад энэ талаар ойлголтгүй байх нь түгээмэл. Хэрэв олон нийт тодорхой хэвлэл мэдээллийн стандартуудыг санал болгосон кодыг хэрэглэж эхэлбэл, энэ нь мэдлэг ойлголтыг дээшүүлэх арга хэрэгсэл болж, хэвлэл мэдээлэл, нийгмийн хоорондох санал зөрөлдөөнийг багасгахад тусална.
 - Хэвлэл мэдээллийн хувьд, ёс зүйн код нь чанд мөрдөхөөр хүлээн зөвшөөрсөн төлөвшил байдлын хамгийн доод түвшний стандартыг тогтоодог. Энэ нь мэдлэг ойлголтыг дээшлүүлэх элементтэй. Тодорхой сэтгүүлчид ёс зүйн кодыг бэлтгэхэд илүү сайн оролцуулж байхад, зарим нь энэ тухай ойлголтгүй байдаг.
- Хэвлэлийн зөвлөлийн гол үүрэг хариуцлага бол ёс зүйн кодыг батлах байдаг. Үүний сацуу, хамгийн чухал зүйл нь ёс зүйн кодыг боловсруулахад бүхий л оролцогч талуудад хувь нэмрээ оруулах боломжийг олгох явдал юм. Зөвхөн эрх барих байгууллагаас баталсан зохицуулалтын арга хэрэгслийнхээ хувьд батлагдсан код нь олон нийтийн хэлэлцүүлгийн сэдэв болох шаардлагатай. Энэхүү үйл явцад сэтгүүлчдийг илүү татан оролцуулах нь мөн онцгой чухал байна. Ёс зүйн кодоод мэргэжлийн хэвлэл мэдээллийн баримтлавал зохих шинж байдлын бодит стандартыг тусгасан байх ёстой бөгөөд хэвлэл мэдээлэлд тулгараад буй сорилт бэрхшээлийг ойлгомжтой байлгахад үндэслэн тулгуурласан байна. Эргээд энэ нь сэтгүүлчид боловсруулах ажиллагаанд оролцсон тохиолдолд л үр дүнд хүрнэ.
- Баримтлах ёс зүйн кодууд нь нэг улсаас нөгөөд ямар нэг байдлаар ялгаатай байдаг бөгөөд мөн өргөдөл хүлээн авах хүрээ (хэвлэмэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөвхөн, эсвэл мөн өргөн нэвтрүүлэг гэх мэт)-нээс хамаарна. Мөн тухайн үедээ, эдгээр нь хамгийн их тохиолддог үндсэн стандартууд байдаг. Агуулгын асуудал (яг юу хэвлэн нийтэлсэн) болон сэтгүүлчдийн бие авч явах байдал (сэтгүүлчид өгүүлэл түүхээ бичихийн тулд юу хийж чадсан) аль алиныг ихэнхдээ хамруулдаг.

- Зарим нэг түгээмэл, чухамдаа бараг олон улсын болчихсон ёс зүйн кодын өвөрмөц онцлог нь нягт нямбай байхыг шаардах, хувийн мэдээллийг хамгаалах дүрэм журам, мэдээнд орж буй хүүхэдтэй харьцах журам, мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах үүрэг, өгүүлэлд төлбөр төлөх журам зэрэг шаардлагууд багтдаг.
- Дийлэнх хэргүүдийг гомдол хэлэлцэх процессын дагуу нарийвчлан ёс зүйн код өөрөө зохицуулдаг. Ихэнх тохиолдолд, хэвлэлийн зөвлөл нь гомдол хянан шийдвэрлэх үйл явцаа илүү нарийвчлан тодорхойлж, түүнчлэн цаг үедээ тохируулан шинэчлэх, өөрчлөх боломжтой болохыг ёс зүйн кодоод өөрт нь заадаг. Зөвлөлийн гомдол хянан хэлэлцэх барагдуулах процессыг маш тодорхой, шударга дүрэм журмаар батлан мөрдөх нь сайн туршлага болно

Хэлэлцүүлэг: Дүрэм журмын зарим чухал хэлбэрийн хувьд та юу гэж бодож байна вэ? Монгол улсад хэвлэл мэдээлэлтэй хамааралтай тухайлсан асуудлуудад үндэслэдэг үү, эсвэл хэвлэл мэдээллийн ерөнхий асуудалд уу?

Зарим түлхүүр асуудлууд

- Хэвлэл мэдээллийн баримтлах зарчмын талаар хэлэлцүүлгээр ямагт гурван үндсэн асуудал сөхөгдөж яригддаг.
- Эхний асуулт нь хэн, юуг тус зарчмаар зохицуулах гэж байгаа вэ? Хувь сэтгүүлчдээс илүүтэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тухайлбал, сонин, сэтгүүл өөрсдөө тогтоодог бол сайн жишиг болно. Энэ нь хоёр үндсэн шалтгаантай. Үүнд:
 - Нэгдүгээрт, хувь хүн нийтлэл бичсэн хэдий ч, хариуцлагатай редактор хэвлэл мэдээллийн хэрэгсэлдээ нийтлэх шийдвэр гаргадаг тул хувь сэтгүүлчээс илүү байна. Цаашилбал, ихэнх тохиолдолд, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж, үүний үр дүнд өргөн хүрээнд уншигчдад түгээгдсэнээс хохирол учирсан тул гомдол гардаг.
 - Хоёрдугаарт, дийлэнх хэвлэл мэдээллийн гомдлын систем нь маш чухал, үр нөлөөтэй залруулгыг санал болгодог. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөвхөн дагаж мөрдөх ёс зүйн кодыг зөрчсөн гэдгээ хүлээн зөвшөөрснөө нотолсон нийтлэлийг гаргаснаараа үр дүнтэй байдаг.
- Хоёрдугаарт, ёс зүйн код болон баримтлах код хоорондын ялгааны тухай төөрөгдөх нь түгээмэл бөгөөд олон кодыг нэрлэхдээ "ёс зүй" гэсэн үгийг оруулсан байдаг. Ёс зүйн код болон баримтлах зарчим хоёрын хооронд чухал ялгаанууд бий. Өмнө нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэзээ ч зөрчиж болохгүй наад захын хэм хэмжээг тогтоох зорилготой байсан бөгөөд дараа нь зөрчсөн тохиолдолд санкц ногдуулах болсон. Сүүлийн үед сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүрэхийг эрмэлзэж буй боловч бүхий цаг хугацааны турш хүрэхийг хүссэн хэмжээндээ хүрч чаддаггүй, зөрчигдөхөөрөө заавал санкц оногдуулахуйц илүү өндөр, ёс зүйтэй хэм хэмжээг тогтооход чиглэж байна.
 - *Жишээ нь:* Непалын Хэвлэлийн зөвлөлийн ёс зүйн кодын 3(1) дэх хэсэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд уриалдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд “тууштай, сонор сэрэмжтэй, шалмаг шуурхай” байхыг шаардана. Энэ бол цэвэр ёс зүйтэй холбоотой мэдэгдэл бөгөөд энэхүү дүрмийг зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санкц хэрэглэх боломжгүй юм. Нөгөө талаар, 4(5) дахь хэсэгт “Ялгаварлан гадуурхалт байж болохгүй. Аливаа мэдээ, үзэл бодол нь арьсны өнгө, хүйс, шашин

шүтлэг, бүс нутаг, хэл, өнгө гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхах шинж чанартай байж болохгүй” гэж заажээ. Энэ бол илүү зохицуулсан мэдэгдэл тул зөрчигдсөн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санкц ногдуулж болно.

- Гуравдугаарт, Ёс зүйн кодын зөрчилд ногдуулах тодорхой шийтгэл санкцын тухай байнгын яриа хэлэлцүүлэг өрнөж байдаг. Ихэнх хэрэг дээр өөрийн зохицуулалтын тогтолцоо нь зөөлөн санкц оноох, залруулгын хэлбэрүүдийг ашигладаг. Ёс зүйн кодыг зөрчвөл хамгийн түгээмэл хэрэглэгддэг санкц нь зөрчил гаргасан тухайгаа хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл гаргахыг сониноос шаарддаг. Мөн олон хэрэг дээр зөвлөл энэхүү мэдэгдлийг бэлтгэдэг бөгөөд зарим хэрэг дээр сонинд шийдвэрийг бүхэлд, эсвэл түүний гол хэсгийг хэвлэн нийтлэхийг шаардаж болдог.
- Алдаагаа засах буюу хариу өгөх эрх олгох нь сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн кодоо зөрчсөний төлөө хамгийн түгээмэл хэрэглэгддэг хариуцлагын хэлбэр болдог. Алдаагаа засах гэж өмнө нь алдаа мадагтай, нягтлан шалгаагүй гаргасан мэдээллийнхээ алдааг залруулсан мэдээлэл нийтлэхийг сониноос шаардахыг ойлгоно. Хариу өгөх гэж ташаа мэдээллээр буруутгагдсан этгээд тухайн хэвлэгдсэн нийтлэлд өөрийн үгээрээ хариулт өгөх эрх олгохыг ойлгоно. Алдааг засах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний цаашдын хандлагад хамгийн улиг болж залхаасан шинжтэй ч, алдаатай өгүүлэл нийтэлж, зөрчил гаргасан л бол цаашид ч хэрэглэхээс өөр арга байхгүй.
- Баримтлах ёс зүйн кодыг зөрчсөний төлөө залруулахаар хариу өгөх эрхийг хүлээн зөвшөөрсөн ч гэсэн, тухайн үедээ энэ нь урвуулан ашиглагдаж болдог. Тухайлбал, эрх мэдэл бүхий улс төрчид шүүмжлэгдэх бүртээ хэвлэл мэдээллийг өөрийн талд олж авахыг оролддог. Үр дүн нь, тухайн этгээдийн эрхээ эдлэж буй тухайн нөхцөл байдалд хязгаарлалт тогтоох нь чухал ач холбогдолтой. Жишээ нь, хувь хүний нууцад халдсан, эсвэл нэр төр гутаасан нийтлэл байгаа учраас нэхэмжлэгчийн хууль ёсны эрхийг гажуудуулсан, ёс зүйн кодоо шууд зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд энэ арга нь боломжтой байна. Хариу өгөх нь уртын хэмжээ, хүрээгээрээ хязгаарлагдах ёстой (тухайлбал, ёс зүйн код зөрчсөнөө залруулж, нэр төр сэргээх г.м).
- Хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд торгууль ногдуулах эрх хэмжээтэй болж практик өөрчлөгдөж байна. Эдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нэлээд онцгой үр нөлөө үзүүлж байгаа ба энэ нь өөрөө болон холимог зохицуулалтын тогтолцоонд хэрэглэх тохиромжгүй гэдгийг нэлээд улс орон тогтоосон. Нөгөө талаар, энэ нь зөрчлийг нэн ноцтой гэдэгт дохио өгөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэвлэлийн зөвлөл торгууль ногдуулах эрх хэмжээтэй байвал тэрхүү торгуулийн дүнгийн дээд хэмжээг тогтоож өгөх нь сайн туршлага болно.

Хэлэлцүүлэг: Монгол улсад эдгээр хамгаалалтын аль төрөл нь үр нөлөөтэй гэж бодож байна юу? Илүү хүнд санкц байх шаардлагатай юу? Хэвлэлийн зөвлөл хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд илүү хүнд санкц оногдуулбал ямар асуудлууд бий болох вэ?

3. Гомдол гаргах болон эрх зүйн залруулга хийх механизмын хоорондын харилцаа

- Гомдлын энэхүү систем нь хандах гэж буй асуудлаар давхардсан зүйл байсан хэдий ч иргэний болон эрүүгийн хуулийг орлохгүй
- 1960 онд Бельгийн түүхч Жон Gilissen "түүхчид тэднийг мэргэшлийн хувьд хэвшил болговол зохих дүрмийг боловсруулах биш, шүүгчид л тэдний оронд үүнийг хийх болно" гэж тэмдэглэсэн байна. Зарим улс орны энэ салбарт арай илүү тодорхой нэр томъёо хэрэглэдэг хэвлэл мэдээлэл байдаг нь мөн үнэн юм. Жишээ нь, Нэгдсэн Вант улсад 1953 онд сайн дурын байгууллага байгуулагдсан хэвлэл мэдээллийн зөвлөлийг үр дүн муутай гэж нэлэнхүйдээ үздэг байсан. 1990 оны 6-р сард засгийн газраас нийтэлсэн Калкутын тайланд хэвлэл мэдээлэл нь хэрвээ хууль ёсны хэвлэл мэдээллийн зөвлөлөө үр дүн муутай гэж нотолж чадвал шинэ өөрийн зохицуулалтын байгууллага бий болгохын тулд нь тодорхой цаг хугацаа тогтоож өгөхийг зөвлөжээ. Ингэснээр өөрийн зохицуулалтын Хэвлэлийн гомдол барагдуулах комисс байгуулагдсан бөгөөд түүнийг ерөнхийд нь харьцангуй үр дүнтэй гэж үзэж байна.
- Өөрөө зохицуулалтын тогтолцоо болон хуулийн дагуу хохирлоо барагдуулахын хамгийн гол нэг ялгаатай тал нь зөвлөлийн шийдвэр цаашид хууль ёсоор заавал биелэгдэх явдал байдаг. Өөрийн зохицуулалтын ихэнх тогтолцоонд байдаг тохиолдол биш юм (гэхдээ энэ нь зарим тохиолдолд хэрэг болдог). Эндээс олон тооны чухал үр дагаврууд гарч ирдэг.

Жишээ: Индонезид, хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэргийг шүүхээр авч хэлэлцэхийн тулд нэхэмжлэл гаргагч нь шүүх руу очихоосоо өмнө хамгийн эхлээд Хэвлэлийн зөвлөлд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн байхыг шаарддаг. Хэвлэлийн зөвлөлийн шийдвэр нь тэдний эсрэг гарсан, эсвэл буруутай үйлдлийн төлөөх нөхөн төлбөрт сэтгэл хангалуун биш байгаа зэрэг аль ч байдлаар Хэвлэлийн зөвлөлийн гаргасан шийдвэрт сэтгэл ханамжгүй, эс зөвшөөрч байвал нь шүүхэд нэхэмжлэл гарган зарга үүсгэх боломжтой байна.

- Өөрийн зохицуулалтын гомдлын системийн гол зорилго нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл наад захын мэргэжлийн хэм хэмжээг хангаж чадахгүй байна гэж боддог хүмүүст хүртээмжтэй, хөнгөн шуурхай тусламж үзүүлэхэд оршино. Эрх зүйн тогтолцооны гол зорилго нь нийгмийн асуудлаарх гомдлын эцсийн, заавал биелэгдэх шийдвэрээр хангахад оршино. Энэ нь хандлагын хувьд 3 үндсэн ялгааг бий болгодог:
 - Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй боловч, түүнчлэн хүлээлгэх санкцын ноцтой шинж байдал зэргээрээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавих эрх зүйн хязгаарлалтыг хууль ёсных болоход хатуу шахалт үзүүлдэг. Өөрөө өөрсдийнхөө зохицуулах мэргэжлийн байгууллагыг үүсгэн байгуулдаг, өөрийгөө зохицуулалтын тогтолцооны үнэн бодит байдал нь илүү бага байна. Бид үүнийг эргэн ярилцах болно.
 - Гомдол/давж заалдах гомдол шийдвэрлэх хянан шийдвэрлэх ажиллагаагаараа ялгаатай. Тогтолцооны хүртээмжтэй байдлыг хадгалахын тулд хөнгөн хэлбэрийн хамгаалалтын аргыг хэрэглэх ерөнхийдөө боломжтой. Өөрийн зохицуулалтын тогтолцоо нь илүү хөнгөн боловч шударга, гомдол хянан шийдвэрлэх журамтай байхад анхаарлаа хандуулдаг. Өөрийн зохицуулалтын тогтолцоонд ялангуяа хуульчийн туслалцаа шаардлагагүйгээр хандаж болдог. Энд гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэж, шаардлагатай газарт нь хохирлыг барагдуулдаг. Нөгөө тохиолдолд буюу хууль эрх зүйн тогтолцоонд илүү

хянан шийдвэрлэх иж бүрэн цогц систем шаардлагатай. Шүүхээр эрхээ хамгаалуулахад маш хүнд байх нь ойлгомжтой. Цаашилбал, эрх зүйн тогтолцооны хувьд эрүүгийн болон иргэний хуулийн тогтолцооны тэс өөр хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж, эдгээр хуулийн заалтуудад үндэслэн нөхөн төлбөр гаргуулах эсвэл санкц ногдуулах боломжтой (түүнчлэн, төрийн эрх мэдэл нь эрүүгийн тогтолцоонд авчрах факт болно).

- Эцсийнх нь, өмнө дурдсанаар, зөвхөн хягаарлагдмал хүрээнд эрхээ хамгаалуулах боломж гомдол шийдвэрлүүлэх тогтолцоонд байдаг. Ихэнх тохиолдолд, зөрчлөө гэдэг мэдэгдэл (уучлал гуйх нэг хэлбэр)- ийг хэлэн нийтлэх шаардлагаа зөвхөн үргэлжлүүлнэ, дийлэнхдээ маш бага хэмжээний торгууль ногдуулж болно. Эсрэг тохиолдолд, иргэний хуулиар маш их хэмжээний нөхөн олговор олгож болно (Гэхдээ, энэ нь олон улсын хэм хэмжээгээр учруулсан хохиролтойгоо дүйц байх ёстой гэсэн зарчим бий). Эрүүгийн хуулиар бол урт хугацаагаар хорих зэрэг илүү хүнд санкц ногдуулах нь мэдээж юм.

Хэлэлцүүлэг: Та энэ ялгаатай байдлыг юу гэж бодож байна вэ? Шүүх дээр нэмээд гомдол барагдуулах ийм тогтолцоотой байх үнэхээр шаардлагатай юу?

Журмын зохицуулалтын мөн чанарын ялгаа

- Дээр дурьдсанчлан, баримтлах ёс зүйн код нь олон улсын хүний эрхийн баталгаа, үзэл бодлоо илэрхийлэхтэй холбоотой биеэ авч явах байдлын эсвэл агуулгад тавих эрүүгийн болон иргэний хуулийн хязгаарлалтаар мөн адил хязгаарлагдана. Олон улсын хууль нь энэ нутаг дэвсгэрт, ялангуяа эрүүгийн хуульд нэлээд эсэргүүцэлтэй тулгардаг. Жишээ нь, бид гүтгэх, нэр төр гутаах хатуу стандартай байна. Нөгөө талаас нь авч үзвэл, өөрийн зохицуулалтын тогтолцоо нь гишүүдээсээ ямар дүрэм журам мөрдөхийг хүсч байна түүнийгээ үндсэндээ чөлөөтэй бий болгох боломжтой. Мэдээжийн хэрэг түүний гишүүд нь (хэвлэл мэдээлэл болон/эсвэл сэтгүүлчид) тэр дүрэм журам нь тохиромжтой гэдгээ хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай бөгөөд энэ бол хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өвөрмөц хамгаалалт юм.
- Нэг талаас нь үзвэл, материаллаг хэм хэмжээний хувьд баримтлах ёс зүйн кодыг хэвлэл мэдээлэлд, нөгөө талаас нь харвал, иргэний болон эрүүгийн хуульд заасан агуулгын хязгаарлалтын хувьд нэлээд хэдэн төрлийн ялгааг гаргаж болно.
 - Нэгдүгээрт, баримтлах ёс зүйн код ихэвчлэн нь иргэний болон/эсвэл эрүүгийн хуулиас олж болохоос илүү цаашид биеэ хэрхэн авч явах байдлын дүрэм журмыг гүнзгийрүүлэн заадаг.
 - Хоёрдугаарт, зарим тохиолдолд, баримтлах ёс зүйн код нь иргэний болон/эсвэл эрүүгийн хуулийг бүхэлд нь үгүйсгэсэн асуудлыг авч хэлэлцдэг бөгөөд эсрэгээрээ иргэний болон/эсвэл эрүүгийн хуулийн авч хэлэлцсэн зарим асуудал нь ёс зүйн кодоор авч үздэггүй байна.
 - Гуравдугаарт, зарим тохиолдолд, иргэний болон/эсвэл эрүүгийн хуулиар авч хэлэлцэх асуудалд илүү хатуу чанга хэм хэмжээ тогтоосон баримтлах ёс зүйн код батална.
 - Эцсийнх нь, бусад тохиолдол бүрт, иргэний болон/эсвэл эрүүгийн хуулийнхтай бараг ижил дүрэм журамтай баримтлах ёс зүйн код баталдаг.

- Биеэ авч явах байдлын дүрэм журмын хувьд, баримтлах ёс зүйн кодоод заасан нэлээд олон асуудал нь иргэний болон/эсвэл эрүүгийн хуульд тусгагдаагүй байдаг. Зарим жишээг дурьдвал:
 - Агуулгыг нийтлэхэд тавьсан хориг, мэдээллийн нууц эх сурвалжийг (эрх зүйн хэм хэмжээгээр эрхийнх нь хувьд орхигдуулсан) хүндэтгэхийг үүрэг болгох
 - уй гашуу, эсвэл хагацал зовлонгоос болж зовж шаналж буй хүмүүсийг тэр байдлаар нь шууд үзүүлэх
 - Зүй бус дарамт үзүүлэх, эсвэл залилан мэхэлж, ялангуяа хүүхдийг оролцуулж ярилцлагын бичлэг олж авахгүй байх
 - Мэдээллийн төлөө төлбөр авахыг хязгаарлах

- Агуулгынхаа хувьд авч үзэхэд нийтлэг ёс зүйн кодоор шийдвэрлэх олон асуудал байгаа хэдий ч иргэний болон/эсвэл эрүүгийн хуулиар шийдвэрлэхгүй (эсвэл байх ёсгүй) байна. Зарим жишээ нь:
 - Бодит баримт, санаа бодол, редакцийн засварын хоорондын ялгаа заагийг тогтоох
 - Тэнцвэртэй, шударга байх үүрэг (зарим үед өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар ийм үүрэг ногдуулдаг)
 - Хэн нэгний мэдээ нийтлэл нь нягт нямбай байх үүрэгтэй. Зарим улс оронд ерөнхий "худал мэдээлэл" заалт байдаг боловч эдгээрийг олон улсын эрх зүйн дагуу хууль ёсны гэж үздэггүй. Бүх улс орнууд нэр төр гутаахтай холбоотой хуулийн цаад агуулгаар нягт нямбай байх үүрэг хүлээнэ. Энэ бол мэргэжлийн талбар бөгөөд нягт нямбай байх ерөнхий үүргээс эрс ялгаатай юм.
 - Сонгуулийн үеэр бүхий асуудлаар харж мэдээлэх эерэг үүрэг (олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хуулийн дагуу үүрэг ногдуулсан боловч, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр энэ нь албан ёсны биш юм).

- Иргэний болон/эсвэл эрүүгийн хуульд заасан ч, ёс зүйн кодоор авч үздэггүй асуудлууд байна. Зарим жишээ нь:
 - Нэр төр гутаах. Ихэнх тохиолдолд, ёс зүйн кодоор асуудлыг шууд авч үздэггүй, харин нягт нямбай байх, шударга байх ерөнхий үүрэг хүлээлгэхийн оронд зарим нэг тохиолдолд, хоёр яг ижилхэн давхардсан ч асуудалд ялгаатай, тэс өөр өөрөөр хандаж байна. Энэ нь олон хүнд гайхаж эргэлзмээр санагдах боловч, ёс зүйн код нь нөхөн төлбөрийн хэлбэрийг бодитойгоор томъёолж чадаагүй бол боломжгүй. Нэр төр гутаахтай ерөнхийдөө холбоотой (өөрөөр хэлбэл хохирлыг барагдуулах) асуудлыг Иргэний хуулиар шийдвэрлэх нь илүү тохиромжтой.
 - Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, шүүхийн захиргааг хамгаалах зэрэг илүү ноцтой асуудлууд байна. Эдгээр нь ёс зүйн кодоор санал болгодог эрхийн хамгаалалтын хүрээнд багтдаггүй бөгөөд эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэгдэх нь илүү тохиромжтой.

- Иргэний болон/эсвэл эрүүгийн хуульд ерөнхий заасан ч илүү хатуу чанга хэм хэмжээг тогтоосон ёс зүйн код баталсан байна.
 - Шашны мэдрэмтгий байдалд санаа тавих. Олон улсын хуулийн дагуу бурханыг үл ойшоох хуулиуд нь хууль ёсоор, буюу ийм хууль үйлчилж

байгаа боловч авч хэлэлцдэггүй байна. Шашин шүтэгчдийг ихээхэн гомдоодог мэдээллүүддээ хязгаарлалт тавих нь сайн туршлага болдог. Эсрэг тохиолдолд, энэ талбарт маш их хатуу чанд дүрэм журмыг ёс зүйн кодоор баталдаг.

- *Жишээ нь:* Мьянмарын Хэвлэлийн зөвлөлийн саяхан баталсан ёс зүйн баримтлах кодоод дараах байдлаар заасан:

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тэдний амьдралаа даатгаж баримталдаг шашны тусгай газруудад хүндэтгэлтэй хандвал зохино. Мьянмар шиг олон янзын шашин шүтлэгтэй нийгэмд шашны мэдрэмжтэй, тэнцвэртэй сэдвүүд чухал ач холбогдолтой. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь шашныг дүрслэхдээ өнгөц, учир шалтгаангүй болон хараалын үг хэллэгийг иш татсанаар итгэгчдэд зэвүүцэл гомдлын шалгаан болж болохыг мэдэрч ойлгосон байх ёстой.

- Хүчтэй үг хэллэг, хүүхдийн хамгаалалт, хүчирхийллийн дүрслэлт, үзэн ядалт эсвэл арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтаас үүдсэн үг хэллэг, гэмт хэрэг, нийгмийн-эсрэг зан үйл болон бусад асуудлуудад тавих аливаа ч хязгаарлалт нь хардлагыг төрүүлж болох хэдий ч иргэний болон/эсвэл эрүүгийн хуулийнхаас илүү хатуу чанга зохицуулалт бүхий баримтлах ёс зүйн кодоод анхаарч буй хандлага байна.

Ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй үг хэллэг Кейсийн судалгаа

Ялгаварлан гадуурхах эсвэл үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгэнд тавигддаг ёс зүйн дүрмийн стандартуудын зөрүүтэй байдал нь бусад ихэнх улс оронд ялгаатай байдаг төдийгүй олон улсын хуулиар зөвшөөрсөн хэм хэмжээнээс ч ялгаатай байдаг.

Энэ асуудлаар олон улсын хуульд тодорхой хэм хэмжээг тодорхойлсон бөгөөд Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын 20(2)-р зүйлд дараах байдлаар тусгажээ.

Алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглоно.

Тус гэмт хэрэг олон элементүүдтэй. Үүнийг өдөөн турхирахыг шаардах гэж нийтээр ойлгодог ба “ухуулга сурталчилгаа” гэсэн албан нэршил тэмдэглэсэн байна. Өдөөн турхиралт гэсэн нэршил нь сүүлийн жилүүдэд шүүхийн анхаарлыг нэлээдгүй татаж байгаа нь мөн чанартаа ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийлэл болон маргааны илэрхийлэл хоёрын хоорондын шалтгаант холбоог тогтоох шаардлага юм. Ялгаварлан гадуурхах болон хүчирхийлэх гэсэн хоёр нь маш тодорхой бөгөөд, энгийнээр хэлбэл хууль бус үйлдэл юм. Гуравдугаарт, дайсагнал болон үзэн ядалт нь оюун санаагаар илэрхийллэгддэг зүйлс билээ. Эцэст нь ‘хуулиар хориглосон гэдгийг эрүүгийн хуулийн хэлж байна’ гэж ойлгож болох юм.

Ихэнх тохиолдолд, дийлэнх улс орон үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийг

эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг. Гэхдээ үүний шинж чанар нь харилцан адилгүй байдаг. Үлгэрлэвэл тухайн байдал нь эрүүгийн хуульд харшилж 20-р журмыг ч зөрчиж буй хэрэг, цаашлаад олон улсын хуулинд заасан өөрийн үзэл бодлыг илэрхийлэх эрх нь зөрчигдсөг тохиолдол гарч байсан. Канад улсын эрүүгийн хууль дахь үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийн талаарх 319-р хэсгийн заалт үүний нэг жишээ болдог. Үүнд:

(2) хэн боловч хувийн харилцан ярианаас бусад олон нийтийн танил хэсэг бүлгийн эсрэг мэдээлэл хийсэн бол доорх байдлаар гэм буруутай

(a) мөрдөн шалгалтаар зөрчилтэй нь батлагдсан бол хоёроос илүүгүй жил шоронд хорих эсвэл

(b) тухайн зөрчилд зохих хөнгөн шийтгэл оноох

(3) Дараах тохиолдолд зөрчил гаргасан зөрчсөн хэнийг ч (2) хэсэгт заасан үндэслэлээр шийтгэх ёсгүй:

(a) хэрэв тухайн хүн гаргасан мэдээллийг үнэн зөв гэдгийг нотолсон бол

(b) хэрэв сайн санааны үүднээс, иргэн шашны ном бичигт итгэх итгэлийн тухай бодол эсвэл шашны холбоотой үзэл бодлын маргааныг үндэслэхийг оролдож нотолсон бол

(c) хэрэв тухайн мэдээлэл олон нийтийн ашиг сонирхолын тухай сэдэвтэй холбоотой, олон нийтийн сайн сайхны төлөө мэтгэлцээн, тухайн маргаан нь үнэн байх боломжтой бол эсвэл

(d) хэрэв сайн санааны үүднээс, Канадын олны танил хэсэг бүлгийг гутаан доромжлох санааг бий болгохыг чиглэсэн, тухайн асуудлыг арилгахыг эсвэл түүнийг онцлохыг оролдсон бол

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20-р зүйлээр шаардсан ихэнх онцлогуудыг багтаасан байна. Үүнд санаа зорилготой, турхирах болон хориотой үр дүн.

Хэрэв бид ёс зүйн дүрмийг хэвлэл мэдээллийнхэнд зориулан гаргавал 20-р зүйлд заасан үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийн тухай заалтаас хэтэрсэн хэрэг болоод байдаг. Жишээ нь:

- Шинэ Зеланд Free-to-air телевизийн ёс зүйн кодын дүрмийн 7 дугаар стандарт нь Ялгаварлан гадуурхах болон Гүжирдлэгийн тухай заалт байдаг:

Олон нийтийн телевиз нь өөрийн нэрийн өмнөөс аль ч хэсэг ялгаварлан гадуурхах болон гүжирдэхийг дэмжихгүй /ялгаварлан гадуурхах шалтгаан олон төрөлтэй/

Ялгаварлан гадуурхах эсвэл гүжирдлэгийг дэмжих нь мэдээж өдөөн турхирахаас стандартын хувьд доогуур байдаг.

- Английн редакторуудын дүрэм нь илүү олон заалттай байдаг ба 12-р зүйлд дараах байдлаар заасан:

Хэвлэл мэдээлэл нь хүнийг яс үндэс, арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг хандлага болон сэтгэл мэдрэлийн өвчтэй эсвэл тахир дутуу байдлаар нь хор учруулах эсвэл доромжилсон аливаа үйлдлээс зайлсхийх ёстой

- 12(ii) зүйлээр тухай явдал бодит түүхтэй хамааралтай биш бол дээрх ямар нэг шинжийг агуулсан дэлгэрэнгүй мэдээллээс байнга зайлсхийх

ёстойг заасан байдаг.

Үнэндээ хуульд харшлах маш олон зүйлс байдаг. Английн редакторуудын дүрмийн 16-р заалтаас ирээдүйд олон нийтийн ашиг сонирхолд байх 10-н заалтыг бүгдийг эсвэл хэсэгчлэн хүчингүй болгох байх. 12-р заалт бол зөвхөн тэдний нэг хэсэг биш юм. Тиймээс олон нийтийн ашиг сонирхлыг бүхлээр нь үл хамааран хэрэглэгддэг.

- Сонирхолтой нь олон улсын сэтгүүлчдийн холбооны зарчмууд энэ тал дээр чив чимээгүй байдаг бөгөөд сэтгүүлчдийг “хэвлэл мэдээллээс цаашид шалтгаалан гарах ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлуудаас сэрэмжлэх” ба “ялгаварлан гадуурхах байдлыг хөнгөвчлөхөөс зайлсхийх”-г уриалдаг. (зарчим 7)

Тэгэхээр бид эндээс эрүүгийн хууль болон ёс зүйн дүрэм дэх эрс ялгаатай хэм хэмжээнүүдийг олж харлаа.

Хэлэлцүүлэг: Яагаад ёс зүйн дүрэм эрүүгийн хуулиас илүү ялгаварлан гадуурхсан эсвэл гүжирдсэн ярилцлага илтгэлд хэвлэл мэдээллийн салбарынханд хатуу үүрэг хүлээлгэж байгаа гэж бодож байна вэ? Энэ нь байж болох уу? Монгол улсад энэ дүрэм хэрэгжих боломжтой гэж бодож байна уу?

- Нөгөө талаар, ес зүйн кодын хэм хэмжээний олонх хүрээ нь иргэний болон эрүүгийн хуулийнхтай ижил төстэй байдаг. Жишээ нь, хувийн нууцыг хамгаалах нь үнэн юм. Ихэнх улс оронд хувийн нууцыг хамгаалахдаа иргэний хуулийн дагуу хандахаас илүү хувийн арга хэмжээ авдаг. Харин зарим эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад нууц байдлыг зөрчсөн зэргийг шийтгэх буюу гэм хорын хуулиар шийдвэрлэнэ. Дийлэнх олон улс орнууд хууль бусаар утас чагнах гэх зэргээр хувийн нууцад ноцтой халдвал эрүүгийн хуулиар шийтгэгдэг байна.
- Хувийн нууцтай холбоотой журам нь төвөгтэй байдаг бөгөөд шүүн таслах ажиллагаа бүр ялгаатай байдаг. Гэхдээ ихэнх улс оронд үүнтэй холбоотой хоёр үндсэн ойлголт байна. Нэгдүгээрт, эзлэн түрэмгийлэх санаа бүхий хувийн нууцын талаарх төсөөлөл нь байж болохуйц хэмжээнд байхад хэрэглэх дүрмүүд. Асуудлын гол нь олон нийтийн газар эсвэл хувийн байршилд байхаас үл хамаарч- хэн нэгэн хүн байнга очдог ресторанд өөрийн гэсэн нууцтай байх боломжтой хэдийгээр тус газар олон нийтийнх боловч бүх нөхцөл байдалд өргөн хүрээтэй шалгалт хийхэд.
 - *Жишээ нь:* Гомдол гаргагчийн далбаат завиар явж байх үеийн гэрэл зургууд нь хувийн нууц сонирхлыг зөрчсөн гэсэн хэргийг Францын шүүхэд авч хэлэлцээд завь нь далайн эрэг болон боомтоос хол явж байсан учраас зорчин явагчдад хувийн нууцтай байх үндэслэл бүхий хүсэл байсан гэж үзсэн байна.
- Хоёрдугаарт, олон нийтийн ашиг сонирхол нь хууль ёсоор хамгаалагдсан хувийн нууцаас илүү байх ёстой гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, Европын зөвлөлийн Сайд нарын хорооны хариу өгөх эрхийн асуудлаарх тогтоолоор нийтлэл нь хувийн нууцтай байх эрхийг зөрчсөн материал, бусад зүйлс хэвлэн нийтлэл нь бусад зүйлсээс олон нийтийн хууль ёсны ашиг сонирхолд чухал ач холбогдолтой болох нь тогтоогдвол үр дүнтэй хамгаалалт болно.
- Мөн адил санааг хувийн нууц хамгаалах тухай ёс зүйн кодоор дэмжсэн байдаг.

- *Жишээ нь:*, Шинэ Зеланд улсын олон нийтийн телевизийн ёс зүйн кодын хувийн нууцын Стандарт 3-т зааснаар: “Олон нийтийн телевизүүд нь хувь хүний нууцыг чандлан хадгалах хэи хэмжээг баримталбал зохино” хэмээсэн байна. Үүний хоёрдугаар хавсралтад үүнийг хэрхэн баримтлах талаар нухацтай бодож гаргасан удирдамж болон үүнийг ажил хэрэг болгох гол ухагдахуунуудыг заажээ. Хувийн нууцад халдах “хувь хүний нууцын” ямар тохиолдолд ил болгох зэрэг багтсан байна. Мөн тус зөвлөмжид олон нийтийн ашиг сонирхлын тулд хувийн нууцын хамгаалалтыг хүлцэх удирдамжийг тусгагдсан. Энэ нь дээр дурьдсан эрх зүйн дүрэм журмаас илүү өндөр стандарттай гэдгийг тэмдэглэсэн байна.
 - *Жишээ нь:* Хэвлэлийн гомдол санал авах ёс зүйн кодын 3 дахь хэсэгт, хувийн нууц гэдэгт “хүн бүр бусдын гэр бүл, орон байр, эрүүл мэнд болон захидал харилцааг хүндлэхийг ойлгоно” гэсэн байдаг бөгөөд редоктарууд зөвшөөрөлгүйгээр бусдын хувийн амьдралд халдсан тохиолдолд зохих шийтгэл ногдуулна гэсэн байдаг. Олон нийтийн ашиг сонирхлыг няцаах нууцлалтай байх ёстой ба хувийн эзэмшил газарт хувийн нууц байх ёстой гэдэг саналууд нийлж байгаа юм. Энэ нь дээр хэлсэнчлэн, иргэний хуулийн стандарттай ижил байгаа юм. Тус дүрэмд хүний уй гашуудал, мэдрэмжээсээ болж гэнэтийн шоконд орсон тохиолдолд анхаарах шаардлагатай зүйлс, хувийн нууцыг олж авахын тулд нууц тоног төхөөрөмж эсвэл арга заль хэрэглэж болохгүй зэрэг бусад олон зүйлсийг тусгажээ.
- Тэгэхээр бид сая ёс зүйн код болон эрх зүйн системд хувийн нууцын асуудлаарх зохицуулалтын хоорондын өндөр зэргийн харилцан зохицол байдгийг олж мэдлээ.
 - Үзэн ядалтаас үүдэлтэй үг ярианы асуудлаар хатуу чанга зохицуулалт байх нь хэвлэл мэдээллийн нийгэм дэх манлайлалын үүргээр тайлбарлагдаж болох юм. Ёс зүйн кодыг боловсруулагчдын ихэнх нь хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд байдаг бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудлыг сайн мэддэгийн хувьд хэвлэл мэдээлэл бол энэ асуудалд хамгийн бага нөлөө үзүүлэх ёстой гэж итгэдэг. Хамгийн чухал нь ялгаварлан гадуурхсан үг ярианд хатуу зохицуулалтай байх нь “хоточ нохой” буюу “дөрөв дэх засаглал” гэгддэг хэвлэл мэдээлэлд маргаан бараг гардаггүй байна.
 - Асуудал гэдэг бол хувийн нууцын хувьд эрс ялгаатай зүйл. Энэ нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн эрх ашгийн асуудлуудыг олон нийтэд цацсанаар бодит маргааныг буй болгодог. Энэ нь маргаан гаргасан талд хэцүү асуудлуудыг бий болгодог учир нь шуугиан тариваг сэтгүүл болон шар хэвлэлүүдэд их хэмжээний асуудлуудыг дагуулдаг. Шар хэвлэл хэзээ ч олон нийтийн ашиг сонирхлыг анхаардаггүйгээс гадна гомдоллогч тал наана хянуулах үүргээ гаргахаа мэддэггүй. тэд олон нийтийн эрх ашгийн үгүйсгэсэн механизмын тэнцвэржүүлэхийн тулд синсацтай ажлуудыг бус харин мэдээллийн чанартай хөтөлбөрүүдийг зөвшөөрдөг байна.

Бусад асуудлууд

- Ёс зүйн кодын хэм хэмжээ нь эрх зүйн шийдвэрүүдэд өөр арга замаар нөлөөлөхүйц кейсүүд байдаг. Жишээ нь нэр төр гутаасан гэх үндэслэлтэй нийтлэлүүдийн хамгаалалтын талаар дээр тайлбарласан. Гомдол гаргах систем нь ёс зүйн кодын хэм хэмжээнд нийцэх тодорхой зарим зан байдлыг авч үздэг бол шүүх нь шүүгдэгчийн зан төлөв нь нэр төр гутаах хуулийн зорилго

үндэслэлтэй нийцэх эсэхийг шийдвэр гаргахдаа харгалзах тал байдаг. Нөгөө талаар ёс зүйн кодыг зөрчсөн болохыг аль хэдийн тогтоочихсон бол шүүх шүүгдэгчийн зан байдал нь үндэслэлтэй байх эсэх талаар гэж үзэх магадлал багасдаг.

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийг захиргааны хуулийн хэрэгжүүлэгч болохын хувьд нийтийн байгууллагын статустай байх гэдэг асуудал урган гарах магадлалтай. Жишээ: хэвлэл мэдээллийн зөвлөл нэг гомдол ирснийг шийдвэрлэх хэрэгтэй болсон бөгөөд энэ асуудалд өмнө шийдвэрлэж байсан хэрэг нөлөөлж болохуйц байж болно. Хэрэв үүнийг нийтийн эрх бүхий байгууллага гэж үзвэл шүүх тэдэнд шударга байх шүүн таслах энгийн хэм хэмжээг шаардах бөгөөд процесс ажиллагааг хамтран явуулж болно.
- Зарим улс орнууд хэдийгээр хэвлэл мэдээллийн зөвлөл нь албан ёсоор хувийн хэвшил боловч, шүүх тодорхой эрх мэдэл өгснөөр захиргааны хуулийн шаардлагын хүрээнд тодорхой эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Энэ нь ямар ч нөхцөлд тэдгээр байгууллагын хувьд шүүн таслах ажиллагааны дүрэм журмыг хүндлэх сайн туршлага болох нь мэдээж (ялангуяа үйл ажиллагаа шударга байхтай холбоотой).
- Хэвлэл мэдээллийн зөвлөл нь мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу төрийн байгууллагаас мэдээлэл хэрхэн олж авахыг нарийн тодорхойлж болох юм. Энэ бол хуульд хэрэглэгдэж буй хэлнээс хамаарна. Энэ нь нийтийн албаны чиг үүрэгтэй байгууллагад мөрдөгддөг бол хэвлэл мэдээллийн зөвлөлийн гомдол хянах чиг үүрэг нь илүү мэргэжлийн байхад чиглэнэ. Энэ нөхцөлд, хэвлэл мэдээллийн зөвлөл нь олон нийтээс ирүүлсэн мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх шаардлагатай бөгөөд зарим төрлийг мэдээллийг идэвх санаачлагатайгаар нийтлэх хэрэгтэй болно.

Дасгал ажил 5: Хууль зүйн болон Өөрийн зохицуулалтын журмаар гомдол гаргах

Өөрийн зохицуулалттай холбоотой лавлагаа

1. EthicNet collection of journalists' codes of ethics, available at: http://ethicnet.uta.fi/codes_by_country
2. Mike Jempson, "Codes of Conduct" (2004), available at: http://www.mediawise.org.uk/www.mediawise.org.uk/display_pagef2d3.html?id=676
3. "Media Accountability Systems" (Includes collections of codes of ethics and descriptions of Press Councils), available at: <http://www.rjionline.org/mas/index.php>
4. Carmen Palzer and Alexander Scheuer, Self-Regulation, Co-Regulation, Public Regulation (2004), available at: http://www.emr-sb.de/news/Palzer_Scheuer_Unseco-Clearinghouse_Yearbook2004.pdf